



The Asia Foundation



Хүйсийн тэгш
эрхийн төв

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ГАРЫН АВЛАГА

Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудад зориулав.

Боловсруулсан: Хүйсийн Тэгш Эрхийн Төв
Г.Ганбаясгах
Г.Цогзолмаа
Э.Хишигбаяр

Улаанбаатар хот
2011 он

Энэхүү номыг АНУ-ын Төрийн Департментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих газрын санхүүгийн тусламжтайгаар АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрхийн төвийн захиалгаар бүтээв.

БҮТЭЦ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ	5
1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн түүхэн тойм	5
1.2. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тоо, баримтууд	7
1.3. Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт	8
1.4. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэрүүд	14
1.5. Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн байдал	16
1.6. Хүн худалдаалах гэмт хэрэг ба цагаачлал, хууль бусаар хил нэвтүүлэхийн ялгаатай талууд	19
1.7. Хүн худалдаалах гэмт хэргийн үр дагавар	20
1.8. Хүн худалдаалах гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйлс	20

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД	21
2.1. Монгол улсын хууль тогтоомж	21
2.2. Олон улсын гэрээ, протокол, хэлэлцээр	24
2.3. Эрхзүйн туслалцаа үзүүлэх тухай эрхзүйн харилцан туслалцааны тухай үндсэн ойлголт	29

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	37
3.1. Утсаар мэдээлэл авах, холбоо тогтоох	37
3.2. Хохирогчид болон бусад хүмүүс гэмт хэргийг шууд мэдээлэх нь	38
3.3. Төмөр замын цагдаагийн ажилтны үүрэг	39
3.4. Анхан шатанд хуулийн байгууллагын үүрэг	40
3.5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид мэдээлэл өгөх	41
3.6. Хохирогчийг хилээр гарахаас өмнө авч болох арга хэмжээ буюу туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлыг хангах	42
3.7. Хохирогчийг аврах ажиллагаа	43

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	48
4.1. Хилийн зөрчил, хүн худалдаалах гэмт хэргийн хоорондын хамаарал	49
4.2. Хил хамгаалах байгууллагын зааврууд	49

ТАВДУГААР БҮЛЭГ

ХАВСРАЛТ	55
5.1. Монгол улсын ХЦУГ ЦЕГ, УАБХГ-ын дарга нарын хамтарсан тушаал, журам тогтоох тухай	58
5.2. МУ-ын Эрүүгийн болон Иргэний хууль	66
5.3. ЦЕГ-ын 202 тоот журам - Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах	69
5.4. ЦЕГ-ын 242 тоот журам- Хэлний бэрхшээлтэй хүнд туслах	72
5.5. ЦЕГ-ын 244 тоот журам – Гэрч, хохирогчийг хамгаалах	75
5.6. ЦЕГ-ын 317 тоот журам – Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ	78
5.7. Монгол улсын дээд шүүхийн тогтоол	
5.8. Хүний эрх болон хүн худалдаалах асуудлын талаар санал болгож буй удирдамж	82

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн түүхэн тойм

Хүнийг худалдаалах нь нийгэм үүсэн бий болсон цагаас улбаатай гэх агаад түүхийн хөгжлийн үе шат бүрд хувьсан өөрчлөгдөж иржээ. Хүний заяагдмал эрхийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч хүнийг энэрэн хамгаалах хамгийн таатай нөхцөл бүрдүүлэх зорилгод дэлхийн улс орнуудын төрийн бодлого чиглэгдсээр багагүй хугацаа өнгөрч буй хэдий ч хүний наймаа хил хязгаарыг үл харгалзан өргөжин тэлсээр байгаа билээ¹.

ХХГХ-тэй тэмцэж ирсэн түүхэн тоймыг эртний боол худалдах, худалдан авах явдалтай холбоотойгоор авч үздэг. 1850 онд зөвхөн Америкийн өмнөд хэсэгт гэхэд 4 сая боолчуудтай болсон байжээ². 17-18-р зуунд Европт хүнийг боол болгож худалдаалахын эсрэг хөдөлгөөнүүд өрнөсний үр дүнд 1802 онд Дани улс анх удаа (Дараа нь Франц, Голланд, Португали зэрэг улсууд) 1838 онд Их Бринтаний Эзэнт гүрэн боол худалдаалахыг хориглосон журам тогтоосон. 1865 онд АНУ-д иргэний дайны төгсгөлд боолчлолыг халсан тухайгаа зарлаж, Үндсэн хуулиндаа оруулсан. 1904 онд анх удаа “Цагаан боол” худалдаалахыг хориглосон Олон Улсын гэрээ батлагдан гарснаас хойш дэлхий нийтээрээ 1910, 1921, 1933, 1949 онуудад эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахыг хориглосон олон улсын конвенцийг батлан гаргаж ХХГХ-тэй тэмцэж ирсэн түүхтэй.

2000 онд НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн нэмэлт “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх протокол”-ыг батлан гаргасан.

Одоо энэхүү протоколд дэлхийн 129 улс нэгдэн орж, 111 улс соёрхон батлаад байгаа бөгөөд АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр эрхлэн гаргадаг тайлан илтгэлд дурдагдсанаар дэлхийн 171 улс ХХГХ-т ямар нэгэн байдлаар холбогджээ³.

Монгол улсад хүн худалдаалах гэмт явдал дундад зууны үеэс эхлэн олон хэлбэрээр үйлдэгдэж байсан гэх бөгөөд үүнийг нотлох зарим баримтыг түүхэнд тэмдэглэн үлдээсэн байна. Тухайн үед боол болгох ял оноогдох, өөрийгөө худалдах, эсхүл худалдагдах, дайн, тулааны үед хүчинд автаж олзлогдох, язгууртны хуримын инжинд өгөгдөх замаар боол болдог үндсэн хэлбэртэй байсан ажээ. Эдгээрийн дотроос бүх хөрөнгө, малаа бараад амьдралын аргагүй байдлаас өөрийгөө худалдаж

¹ Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал, 2010 он., ХТЭТ, 11-р тал

² Хүн худалдаалах гэмт хэрэг, суралцагсдын гарын авлага, 2009 он, ХТЭТ, 7-р тал

³ Trafficking in Persons Report, 10th edition, 56-60-р тал

гэрийн боол болох тохиолдолд хошууны тамгын газарт мэдүүлж батлуулдаг байв⁴. Архивын материалд дурьдсанаар Түшээт хан аймгийн Түшээт вангийн хошууны нэгэн дансанд 1747 оны байдлаар 157, 1855 онд 42 гэрийн боол байсан тухай тэмдэглэсэн байна⁵.

Хүн худалдаалах энэ мэт гэмт хэрэг XX зууны эхэн үе хүртэл үргэлжлэн үйлдэгдсээр байсан юм. 1911 онд Монгол оронд Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялснаар монголын төр тусгаар тогтнож, үндэсний төр улсын засаг захиргааны зохион байгуулалт цэгцэрч, Монгол газарт Монгол угсаатныг нэгтгэхэд чиглэсэн төрийн бодлого хэрэгжиж эхлэв.

1921 онд Ардын хувьсгал ялснаар ардын засаг тогтож хамжлагат ёсны харилцааг халахад чиглэсэн арга хэмжээнүүдийг дэс дараатай авч хэрэгжүүлсний дотор 1924 оны 11 дүгээр сард хамжлагат ёсыг бүрмөсөн устгасан тухайгаа анхдугаар үндсэн хуулиндаа тунхаглан зарласан. 1968 оны 10 сарын 31-нд “Боолчлол, боолын худалдаа болон боолчлолттой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц”-ийг соёрхон баталсан.

Монгол улс анх 1961 оны Эрүүгийн хуулийн 87-р зүйлд “Насанд хүрээгүй хүмүүс ба эмэгтэйчүүдийг садар самуунд уруу татах” гэсэн зүйл ангийг бий болгосон. 87.Б-д эмэгтэйчүүдэд эд мөнгө өгч хурьцал үйлдэх буюу биеэ байнга үнэлж явалдсан байвал хоёр жил хорих буюу нэг мянган төгрөг хүртэл торгоно гэж заажээ. Энэ зүйл ангиар 1963 онд БНХАУ-ын нэг иргэн шийтгэгдэж байжээ.

1986 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 111-р зүйл буюу “Бусдыг садар самуунд уруу татах” зүйл ангийг нэмсэн байна. 1994 оны 111-р зүйлд “Бусдыг биеэ үнэлж явалдахыг зохион байгуулсан гэсэн хэсэг нэмэгдсэн⁶.

1996 онд Эрүүгийн хуулинд 111 дүгээр зүйл, “Биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах”, 111¹ дүгээр зүйл “Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх” гэсэн зүйлээр нэмэлт оруулж, эдгээр гэмт хэргийг үйлдсэн этгээдийг 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан билээ. 2002 оны 09 сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Эрүүгийн хуулиндаа “Хүн худалдах, худалдан авах” /ЭХ-ийн 113-р зүйл/ зүйл заалтыг шинээр оруулсан ч харамсалтай нь шинэ төрлийн гэмт хэргийг шийтгэхээр хуульчилсан заалт нь төдийлэн оновчтой байгаагүйгээс 6 жилийн хугацаанд 2 хэргийг л энэ хуулийн дагуу шийтгэж чадсан. Тиймээс 2008 оны 2 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулийн 113-р зүйлийг өөрчилж, Палермогийн протоколд нийцүүлсэн.

⁴ Б.Баярсайхан . Монгол цаазын бичиг (харь цуулсан судалгаа) . УБ., 2001. 94,95-р тал

⁵ Улсын түүхийн төв архи в. М-17-1-67, 202-р тал .

⁶ Ерөнхийлөгчийн иргэний танхим, Иргэдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалах асуудал” хэлэлцүүлэг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Нямдаваа, 17-р тал

2005 онд Засгийн газраас “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр” /2005 оны 11 сарын 30, 234-р тогтоолын 1-р хавсралт/-ийг батлан гаргасан.

Мөн 2008 оны 3 сарын 26-нд УДШ-ээс ЭХ-ийн 113-р зүйлийн тайлбарыг гаргаж, 2008 оны 5 сард НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэж орсон.

1.2. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тоо баримтууд

Дэлхий даяар хамгийн хурдацтай өсөн нэмэгдэж буй гэмт хэргийн нэг нь хүн худалдаалах гэмт хэрэг юм. НҮБ-ын ХАС-ын үзэж байгаагаар хар тамхи, зэвсгийн наймааны дараа орохуйц том гэмт хэрэг болж байгаа бөгөөд жил бүр энэ гэмт хэргээс олон тэрбум долларын ашиг олдог гэжээ.

Толь бичигт “trafficking” гэдгийг арилжаалагдаж болохгүй зүйлийг худалдаалахыг хэлнэ гэжээ. Иймд бид хар тамхины наймаа, зэвсгийн наймаа болон хүний наймаа гэсэн хэллэгүүдийг хэрэглэдэг. Хүний наймаа гэдэг ойлголтыг хүмүүсийг мөлжих гэмт хэрэг гэж ойлгодог ба энэ гэмт хэрэгт хүмүүсийг ашиг олох бараа таваар болгон мөлжлөгийн янз бүрийн хэлбэрт өртүүлдэг байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь цагаачлал, эсвэл бусдыг хууль бусаар хил нэвтрүүлэхээс ялгаатай. Учир нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь нэг газраас нөгөө рүү шилжүүлэгдэн, эрх чөлөөгөө алдаж, бусдад мөлжигдөх аюулд учирдаг. Мөлжлөг гэдэг нь хэн нэгний сул дорой нөхцлийг нь далимдуулан ашиг хонжоо олохыг хэлнэ. Гэвч бодит амьдрал дээр бусдыг хууль бусаар хил дамнуулах, хууль бус цагаачлал, хүн худалдаалах гэмт хэргүүдийг ялгаж салгахад хэцүү байдаг. Яагаад гэвэл зарим хүн эхлээд цагаачлагч хэлбэрээр өөр орон руу явах боловч энэ нь эцэстээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж хувирах тохиолдол маш олон байдаг.

Дэлхий дээр жилд 2.5 сая хүн худалдаалагдаж байна. Үүний:

- 1.4 сая буюу 56% нь Ази, Номхон далайн бүсэд
- 250,000- 10% нь Латин Америк болон Карибын орнуудад
- 230,000- 9,2% нь Ойрхи Дорнод болон Хойд Африкийн бүс нутгуудад
- 130,000- 5.2% нь Сахарын орчмын орнуудад
- 270,000- 10,8% нь үйлдвэржсэн орнуудад
- 200,000- 8% нь дамжин өнгөрч буй орнуудад худалдаалагдаж байна.

Тайланд дурдагдсанаар дэлхийн 161 орон ХХГХ-т холбогдсон. (гаргагч, дамжуулагч, хүлээн авагч орон)

Дэлхийд жил тутам хүн худалдаалахын хөдөлмөр мөлжлөгийн бүх хэлбэрээс олж буй ашиг орлого нь 31,6 тэрбум ам.доллар байна⁷. Үүний:

- 15,5 тэрбум буюу 49% нь аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орнуудад,
- 9,7 тэрбум буюу 30,6% нь Ази Номхон далайн орнуудад,
- 1,3 тэрбум буюу 4,1% нь Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад,
- 1,6 тэрбум буюу 5% нь Африкийн Сахарын орнууд,
- 1,5 тэрбум буюу 4,7% нь Ойрхи Дорнод болон Хойд Африкийн бүс нутгуудад явагдаж байна.

Монгол улсын тоо мэдээ:

- ЦЕГ-ийн мэдээлэл судалгааны төвийн мэдээлснээр 2006-2010 онуудад ЭХ-ийн 113-р зүйлээр⁸ 71 холбогдогчтой 51 гэмт хэрэгт 129 хохирогчийн гомдлыг, ЭХ-ийн 124-өөр⁹ 92 холбогдогчтой 82 хэрэгт 59 хохирогчийн гомдлыг хүлээн авч шалгаж холбогдох байгууллагуудад шилжүүлжээ.
- Улсын дээд шүүхийн Судалгааны төвийн 2002-2009 оны судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 8 хэрэгт 8 хүн ял шийтгүүлсэн бол 124 дүгээр зүйлээр 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлсэн байна¹⁰.
- ХТЭТ-ийн төвд 2002 - 2010 онд нийт 385 хохирогч хандсаны:
 - 234 нь буюу 60.7 % нь бэлгийн мөлжлөгийн
 - 98 нь буюу 25.5 % нь хөдөлмөр мөлжлөгийн
 - 47 нь буюу 12 % нь зуучлалын захиалгат гэрлэлтийн
 - 6 нь 1.8 % нь эрэн сурвалжилж буй хохирогчид байлаа.
- Хохирогчдын 289 (75%) нь эмэгтэйчүүд, 58 (15%) нь эрэгтэйчүүд, 35 (9%) нь насанд хүрээгүй охид, 3 (1%) нь насанд хүрээгүй хөвгүүд:
- Эдгээр хохирогчдын 197-г (51%) гадаадын 9 орноос (БНХАУ, БНСУ, Турк, Малайз, Макао, Гон-Конг, Украин, Казакстан, Швейцари) эх орондоо аюулгүйгээр эгүүлэн авчирсан бол хохирогч болсон Филиппин улсын 3 иргэнийг эх оронд нь буцаасан.

1.3. Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт

Олон улсын хэмжээнд хамгийн өргөн хэрэглэгддэг хуулийн заалтууд нь НҮБ-ын Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн нэмэлт протокол болох Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, уг гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг шийтгэх протоколын (Палермогийн протокол) 3-р зүйлд тусгагдсан тодорхойлолт байдаг.

Хүн худалдах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах,

⁷ “ХХГХ ба Хөдөлмөр мөлжлөгийн ашиг орлогыг тооцоолох нь” судалгааны ажил, Патрик Бэслэр / Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Женев хот 2005 он/

⁸ ЭХ-ийн 113-р зүйл, Хүн худалдаалах

⁹ ЭХ-ийн 124-р зүйл, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах


¹⁰ Улсын дээд шүүх. Судалгааны төвийн мэдээ. УБ., 2009

хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээн авах үйлдлийг хэлнэ.

Мөлжих гэдэгт наад зах нь бусдын биеийг үнэлүүлэх буюу бэлгийн мөлжлөг, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно.

- а) Энэхүү зүйлийн А хэсэгт дурьдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрийг нь дээрх хэсэгт дурьдсанаар мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй.
- б) Энэхүү зорилгын А хэсэгт дурьдсан аргуудыг хэрэглэхгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах, буюу хүлээж авах үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.
- в) Хүүхэд гэдэгт 18-н нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.

Хүн худалдах гэмт хэрэг нь насанд хүрсэн хүний хувьд



Дээрх хүснэгтийг ашиглан ХХГХ үйлдэгдсэн эсэхийг анхан шатны байдлаар хялбараар тогтоож болно. Тухайн гэмт хэрэг үйлдэх зорилго нь юу байсан бэ?, ямар арга замыг ашиглан гэмт хэргээ үйлдсэн, дээрх үйлдлүүд үйлдэгдсэн үү зэргийг тогтоож болно. ХХГХ-ийг үйлдэхдээ айлган сүрдүүлэх, хууран мэхлэх, урьдчилан тааж хянахын аргагүй нөхцөл бий болгох, сэтгэл хөдлөлийг нь хянах, боломжуудыг

амлах, мөрөөдлийг нь биелүүлэхэд туслахаа амлах зэрэг арга замуудыг хэрэглэдэг. Манай улсад үйлдэгдсэн ХХГХ-ийн тохиолдлуудаас харахад хүч хэрэглэсэн 1 тохиолдол, хулгайлсан үйлдэл нэг ч бүртгэгдээгүй бөгөөд зар сурталчилгаа болон найз нөхөд, танил тал, хамаатан садны хүмүүсийн оролцоотойгоор худалдаалагдсан байдаг.

Насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой онцлог байдлууд – Харин 18 насанд хүрээгүй хүүхдийн хувьд, үйлдэгдэх хэлбэр заавал байх шаардлагагүй – зөвхөн үйл явц болон зорилго байхад хангалттай бөгөөд энэ гэмт хэргийг үйлдэгдсэн байна гэж үзнэ. Өөрөөр хэлбэл хүүхэд өөрийгөө мөлжлөгт өртүүлэх зөвшөөрлийг өгч чадахгүй гэсэн үг юм.

Дээр дурьдсан үйлдэгдэх хэлбэрүүд хэрэглэгдсэн тохиолдолд хохирогчийн өгсөн аливаа зөвшөөрөл хамааралгүй байна.



Одоо доорхи кейсүүдийг ашиглан ХХГХ-ийг тодорхойлох дасгал ажлыг ажиллаж үзье.

Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлох дасгалууд¹¹

Дасгал ажил 1

Болороо 18 настай, Эрдэнэт хотод амьдардаг. Болороогийн эгч Дулмаа гадаад явж нэгэн ресторанд сайн цалинтай зөөгчийн ажил хийсээр 2 жил гаруй болсон. Дулмаа гэртээ ирэхдээ мөнгөтэй, хүн болгонд бэлэгтэй ирдэг ажээ. Дулмааг гэртээ ирсэн байх үеэр нэг залуу ирж түүнтэй уулзахад Дулмаа гэрийнхэндээ болон Болороод өөрийнхөө даргыг хэмээн танилцуулж, дүүтэйгээ хамт явж ажиллахыг санал болгов. Гэрийнхэн нь бүгд зөвшөөрсөн бөгөөд эгчийг нь дүүгээ хажуудаа аваад хамтдаа ажиллаад байна гэдэг тун зүгээр юм гэлцэв. Харин Макаоод очсоны дараа Дулмаа дүүдээ биеэ үнэлэх ажил хийх болно гэдгийг хэлэв. Болороо эсэргүүцсэн боловч эгч нь түүнд өөр зам байхгүй яагаад гэвэл түүний замын зардал зэргийг тэр дарга нь гаргасан учир одоо түүнд өрөө төлөх ёстой гэж хэлэв. Дарга залуу нь түүний бичиг баримтыг нь хураан авч эгч дүү хоёрыг хянан ажиллуулдаг болжээ.

⇒ Энэ нь ХХГХ мөн. Болороо өөр улсад тээвэрлэгдсэн байна (Үйл явц). Мөн өөрийн эгч болон даргад нь хийх ажлынхаа талаар хууртагдсан, түүний бичиг баримтийг өөр хүн хураан авч хүний хяналтанд (Үйлдэгдэх хэлбэр) орсон бөгөөд албадан биеэ үнэлэх болсон (Зорилго).

Дасгал ажил 2

Хойд Солонгосын нэгэн жижиг тосгонд амьдардаг Х хэмээх 25 настай эмэгтэй нь амьдарлын наад захын хэрэгцээ нь хангагдаагүй ядуу амьдардаг байлаа. Нэг өдөр аав нь охиндоо түүнд Өмнөд Солонгост очиж ажил хийх боломж байгаа тухай хэлжээ. Аав нь түүнийг өмнөд Солонгос руу дагуулж явах хүнд урьдчилгаа болгож мөнгө төлснөөс гадна үлдсэн мөнгийг охин нь очсон хойноо (ажил хийж гэртээ мөнгө явуулж чадах болсон хойно) төлж дуусгахаар тохирчээ. Х өөр хэд хэдэн эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хамт нутгаас гарчээ. Х түүнд ямар аймшигт зүйл тохиолдохыг мэдэлгүйгээр хамт явсан нэг эмэгтэйтэй хамт Монголруу тээвэрлэгдэн албадлагаар биеэ үнэлэх болсон байна. Түүнд өрөө төлж дуусгах ёстой, хэрвээ төлөхгүй бол түүнийг Хойд Солонгос руу буцаана, тэгвэл тэнд түүнийг баривчилж, шоронд хорьж хууль бусаар хил нэвтэрлээ гэж шийтгэх болно гэж сүрдүүлжээ.

⇒ Энэ нь ХХГХ мөн. Тэрээр өөрөө зөвшөөрч Хойд Солонгосоос хууль бусаар хил нэвтэрсэн боловч түүнийг тээвэрлэж, орогнуулсан (Үйл явц) гэмт хэрэгтнүүдэд хууртагдсан. Тэрээр хууран мэхлэгдэж, айлган сүрдүүлж, албадлагад өртсөн (Үйлдэгдэх хэлбэр) мөн албадан биеэ үнэлж мөлжлөгт өртсөн (Зорилго).

¹¹ ХХГХ-тэй тэмцэхэд хуульчдын оролцоо сургалтын материал, Ruth Rosenberg, 2007 оны 9 сар, Сайнианд хот

Дасгал ажил 3

Цэцгээ хэмээх 20 настай охин өөрийнхөө найзаар дамжуулан Солонгос эрэгтэйтэй танилцжээ. Цэцгээ түүнтэй хайр сэтгэлийн холбоотой болж, улмаар гэр бүл болов. Гэр бүл болсныхоо эхний жил тэд Монголд аз жаргалтай сайхан амьдарчээ. Эцэст нь тэд хамтдаа Өмнөд Солонгос руу явахаар шийдэв. Цэцгээд түүний нөхрийн эцэг, эх тааламжгүй хандаж байлаа. Хадам эх нь хэрцгий зантай бөгөөд гэрийн бүхий л ажил төрлийг хийхийг түүнээс шаардаж байв. Ингэхдээ тэрбээр Цэцгээгийн ажилд огт тусалдаггүйгээр үл барам ямагт шүүмжлэлтэй хандана. Гэрт болон гэр бүлийнх нь жижиг ферм дээр хийх ажил мундахгүй их гарна. Цэцгээ шөнөжин, өдөржин ажилладаг байв. Хадам эхээсээ болж тэр нөхөртэйгээ маргалдах болжээ. Түүний нөхөр уух сонирхолтой болж, архи хэтрүүлэн хэрэглэсэн үедээ Цэцгээд гар хүрч эхлэв. Тэрбээр нөхрөө орхиж, Монгол руу буцах сонирхолтой байвч гэртээ очих мөнгөгүй, түүнчлэн хүүхдээ орхин явахаас эмээж байлаа...

→ Энэ нь ХХГХ-ийн тохиолдол биш. Яагаад гэвэл Цэцгээ элсүүлэгдээгүй бөгөөд нийгмийн ердийн харилцааны явцад нөхөртэйгээ танилцсан байна. Ийм учраас энэ тохиолдолд “үйл явц” болоогүй. Гэрлэлтийнхээ явцад тэрээр өөрийгөө мөлжигдсэн гэж үзэж, нөхрөө орхин явах боломж байгаагүй байж болох ч түүнийг хүчээр гэр бүл болгоогүй байна. Тиймээс үүнд ямар нэгэн “арга хэрэгсэл” байгаагүй. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн тодорхой жишээ боловч ХХГХ биш юм.

Дасгал ажил 4

Энэ бодлого нь өмнөхтэй ойролцоо боловч энэ удаад Цэцгээ гэр бүлийн зуучлалын компанийн төлбөртэй үйлчилгээгээр дамжуулан нөхөртэйгээ танилцжээ. Тэд чинээлэг, царайлаг бөгөөд эхнэртэйгээ сайн сайхнаар харилцах, гэр бүлийг нь тэжээн тэтгэх нөхөр олж өгнө гэж амласан байна. Цэцгээ нөхөр болох хүнтэйгээ хурим болохоос өмнө л ганц удаа уулзсан бөгөөд түүний дараа тэд удалгүй Солонгосыг зорьжээ. Тэрбээр энэ удаад бас л гэрийн болон фермийн ажлыг олон цагаар хийх болсноор үл барам түүний нөхөр, гэр бүлийнхэн нь ажлаа сайн хийсэнгүй хэмээн зоддог болсон байна. Тэрбээр мөн л гэртээ харихыг хүснэ. Гэвч түүнд хүслээ гүйцээх мөнгө байхгүйгээс гадна нөхрөө орхин явсан тохиолдолд гэрлэлтийн гэрээг зөрчсөн гэсэн үндэслэлээр зуучлалын компанид их хэмжээний мөнгө төлөх ёстой болох байжээ.

→ Энэ бол ХХГХ мөн. Энэ тохиолдолд элсүүлэх үйлдлийг (Үйл явц) гэр бүлийн зуучлалын компани хийжээ. Цэцгээ хүнтэй гэр бүл болохдоо ямар байдлаар тийнхүү гэрлэж буйгаа мэдээгүй бөгөөд өөрийн зүгээс төлөх боломжгүй их хэмжээний өр төлбөрт орох замаар (Арга хэрэгсэл) гэр бүл болсон байжээ. Тэрбээр хуурамч гэрлэлт хийж мөлжигдсэн байна (үүнд мөн хөдөлмөрийн мөлжлөг хамаарна) (энэ нь Зорилго болно).

Дасгал ажил 5

Сүхээ 20 настай, аймгийн төвд амьдардаг. Тэрээр аавдаа мал маллахад нь туслаж сургуулиасаа эрт завсардсан. Сүхээд Казахстан явж барилга дээр ажиллавал сард 800 ам.доллар цалин авч болно гэсэн тул тэрээр Казахстан явахыг хүсчээ. Сүхээгийн гэр бүлийнхэн зөвшөөрч ажилд зуучлагчид төлөх 500 ам.доллар цуглуулж өгөв. Сүхээг Казахстанд очиход түүнийг барилгын ажилд оруулж, гадаад паспортыг нь найдвартай хадгалж байг гээд ажил олгогчид нь өгсөн. Нэг сарын турш ажилласаны дараа түүнд ямар ч цалин олгосонгүй. Анх түүнд нэг сар ажиллаад цалингаа авч эхэлнэ гэж хэлсэн. Энэ байдал хэдэн сарын туршид үргэлжлэв. Эцэстээ тэрээр уурлан цалингаа төлөхгүй бол үргэлжүүлж ажиллахгүй гэв. Тэрээр гэрээнийхээ заалтыг зөрчиж байгаа талаар ярихад ажил олгогч нь ажлаа хийхгүй бол цагдаад мэдэгдэнэ, нэгэнт бичиг баримт нь түүнд байхгүй, мөн зохих журмын дагуу бүртгэл, виз аваагүй тул түүнийг хууль зөрчсөн гэж удаан хугацаагаар шоронд хорино гэж сүрдүүлжээ. Тэгээд түүнийг дуугай байлгах гэж түүнд 200 ам.доллар өгсөн байна.

⇒ Энэ нь ХХГХ мөн. Сүхээг элсүүлж, орогнуулсан байна (үйл явц). Түүнд хийх ажлын нөхцөл байдлын талаар худлаа мэдээлэл өгч хууран, ямар ч цалингүй эсвэл тун бага цалингаар (Зорилго) ажиллуулах болсон. Түүний гадаад паспортыг хураан авсан мөн ажил олгогч нь сүрдүүлсэн зэрэг нь Сүхээ дуртай зүгтээ, өөрийн дураар явах эрхгүй (Үйлдэгдэх хэлбэр) байна гэсэн үг.

Дасгал ажил 6

Дорж 10 настай, ядуу айлын хүүхэд. Нэг хамаатан нь түүний гэр бүлийнхэнд нэг айлд хоньчиноор ажиллачих хүү хэрэгтэй байгаа тухай хэлэв. Тэр айл Доржийг ажиллуулах болбол эцэг эхэд нь хэдэн төгрөг өгөхөөс гадна хүүг өөрийндөө аваачих болон бусад гарах зардлыг төлнө гэсэн байв. Тэд мөн хүүгийн гэрийнхэнд мөнгө өгөхөөс гадна хүү сургуульдаа заавал явах бөгөөд хичээлийг нь сайн хийлгэх тал дээр анхаарна гэсэн байв. Дорж болон түүний эцэг эх нь зөвшөөрцгөөв. Гэвч Дорж тэр айлд ирснээс хойш сургуульд явахыг нь зөвшөөрсөнгүй, тэрээр өдөр өглөө үүр цайхаас эхлэн үдшийн бүрий болтол ажиллана. Эцэг эх нь сар болгон хэдэн төгрөг авч байсан ч хүүгээ явснаас нь хойш огт сураг дуулсангүй.

⇒ Энэ нь ХХГХ мөн. Доржийг өөр айлд ажиллуулахаар элсүүлсэн (үйл явц) байна. Ямар нэгэн хууран мэхлэх болон арга заль хэрэглэх шаардлага огт байхгүй, яагаад гэвэл Дорж бол насанд хүрээгүй хүүхэд. Гэхдээ энэ тохиолдолд бол хууран мэхэлсэн үйлдэл байна, тэдгээр хүмүүс хүүхдийг сургуульд явуулна гэж амласан үгэндээ хүрсэнгүй. Хүүг хямд ажиллах хүчин болгож мөлжлөгт өртүүлсэн бөгөөд насанд хүрээгүй хүүхдийн хувьд эдлэх ёстой сурах эрх болон чөлөөт цагтай байх (зорилго) эрх нь зөрчигдсөн байна.

1.4 Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэрүүд

Дэлхий дээр жил бүр олон сая хүн худалдаалагдаж байгаа ч тэднийг худалдаж, мөлжих зорилго нь нас, хүйс, царай зүс, бие бялдар зэргээс шалтгаалан харилцан адилгүй байна.

Олон улсын байгууллагуудын мэдээлж байгаагаар хүнийг доорхи хэлбэрүүдээр худалдаж, мөлжиж байна.

Хөдөлмөрийн мөлжлөг: Хүнд, хортой, аюултай, бохир ажлыг олон цагаар хийлгэх, маш бага цалин хөлс өгөх, амралтгүй ажиллуулах, хөдөлмөрийн гэрээ зөрчих, гэрээ огт байгуулахгүй байх (уурхай, барилга, циркийн үзүүлбэр, хорт бодис, аюултай машин механизм дээр ажиллуулах, хөлсөөр мал маллуулах, туршилт нэрийн доор хөлсгүй ажиллуулах, хүчээр хулгай дээрэм хийлгэх бусад аюултай нөхцөлд ажиллуулах)

1992 оноос эхлэн Германы иргэн Монгол уран нугараачдын Европын зах зээлд гаргаж эхэлсэн. Багцаагаар 300-400 орчим хүн энэ шугамаар явсан байх. Нэг ээлжид очсон нугараачдаа Европт зарж байгаад тэд нар нь насанд хүрч, биеэ даагаад хүнтэй гэрлээд ч юм уу ажлаа хийхээ болихоор дахиад Монголоос ирж хүүхдүүд авдаг. Саяхан хүртэл Н гэдэг Монгол эмэгтэй ирж, хүүхдүүдийг шалгаад явсан.

Уран нугаралтын багш О-той хийсэн ярилцлагын тэмдэглэлээс¹².

Албадан хөдөлмөр: Тухайн хүний амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан аливаа ажил үйлчилгээг телбергүйгээр албадан гүйцэтгүүлэх (боолын хөдөлмөр эрхлүүлэх, өрийн барьцаанд авах, зохиомол өрийн боолчлолд оуулах, байнгын хяналтанд байлгах, хорьж цагдах г.м)

...1998 оны 3 дугаар сарын сүүлчээр Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн иргэн .”Ө”-ийн хүү 16 настай “У”-г тус сумын мянгат малчин “С” Өвөрхангай хүртэл малаа туулгуулан хүргүүлээд 10 ямаа хөлсөнд нь өгч 12 сарын эхээр зардлыг нь дааж буцаан явуулна, гэж тохиролцон авч явсан байна. Малчин “С”-ийнх Өвөрхангайд ирээгүй Дархан-Уул аймагт шилжин ирсэн ба хүүхдийн ар гэр сураг гаргах гээд чадахгүй байсан байна. Гэтэл тэрээр ямар ч сураггүй болж У-г тохиролцсон хугацаандаа буцаан явуулахгүй 4 жил 7 сар малаа маллуулж албадан хөдөлмөр хийлгэж, байнга зодож, дарамталж байсан байна. . Үүнийг хөрш айлынхан нь мэдэж хотоос ирсэн хүмүүстэй хамт зугтаалган 2003 онд эгчийнд нь хүргэж өгчээ. Тэд ХЭҮК-т хандаж болсон явдлыг шалгаж хохирлыг нь гаргуулж өгсөн байна. Энэ хугацаанд ар гэрт ямарч мэдээлэл өгөөгүй, ар гэрийнхэн нь эрж сурсан боловч ямарч мэдээлэл авч чадаагүй байсан байна¹³.

Гэрийн хөдөлмөр: гэрийн хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байдаг хэмээн тооцоолжээ¹⁴ (гэрийн үйлчлэгчээр ажиллуулах явцдаа бэлгийн

¹² Монгол улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгааны тайлан, ХЭҮК, 2008 он,

¹³ Монгол улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгааны тайлан, ХЭҮК, 2008 он,

¹⁴ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтгүй ирээдүй хэмээх 2002 оны тайлангийн 29 дүгээр хуудас

хүчирхийлэлд оруулах, хөдөлмөрийг мөлжих, өрийн барьцаанд оруулах, эрхшээл, хяналтандаа байлгах)

... Ер нь айлд гэрийн үйлчлэгч хийх их хэцүү байдаг. Хүүхэд асрах ч бас гайгүй. Хамгийн хэцүү нь тэд байнга архи ууцгаадаг. Тэгээд тэднийд ирсэн улсууд намайг том биетэй болохоор ч тэрүү маш их оролддог.

(УБ, БЗД, X, 15 настай эмэгтэй)

... Урд нь би өөр айлд ажилладаг байсан юм. Гэтэл тэр айлынхан өөр айлд өртэй байснаас болж намайг өрийнхөө барьцаанд энэ айлд ажиллуулж байгаа.

(УБ, БЗД, X, 16 настай эмэгтэй)¹⁵

Бэлгийн мөлжлөг: бусдын биеийг үнэлүүлэх замаар санхүүгийн болон бусад ашиг орлого олох үйл явц юм. ХХГХ-ийн хохирогчдын дийлэнхи нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болдог ба олон улсын тайлангуудад дурдагдсанаар хохирогчдын 75% нь эх орон дотроо болон гадаадад бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон байна. Хохирогчдын дийлэнхи нь эмэгтэйчүүд, охид бөгөөд биеийг нь үнэлүүлэхдээ тусгайлсан янхны газар, саун, массажны газар, шөнийн цэнгээний газруудад ажиллуулахаар буюу садар самуун материал хийхэд ашигладаг. Тодорхойлон хэлэх боломжгүй ч, Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 2000 оны хувьд 1.8 сая хүүхдийг сексийн салбарт мөлжихөөр худалдаалсан гэж үздэг¹⁶.

Цэргийн алба: Дэлхийн бүс бүрт өрнөж буй олон дайн, мөргөлдөөнд албадлагаар буюу хүчээр явуулдаг. Үүнд дийлэнхдээ эрчүүд өртдөг ч насанд хүрээгүй хүүхдүүд өртдөг болох нь тогтоогдсон. Ойрын үед болсон 30 гаруй зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг ашигласан гэсэн тооцоо байдаг¹⁷

Гэрлэлт: Гадаад шилжилт хийх, амьдарлаа дээшлүүлэх гэсэн хүслийг ашиглан ашиг олох зорилгоор зуучлал нэрийн доор, эсвэл албадлагаар гэрлүүлж, ашиг олох явдал юм. Мөн ядуурал дээд цэгтээ тулахаар охидыг эдийн засгийн хувьд боломжтой ахмад хүнтэй гэрлүүлэх нь гэр бүлийг тэжээх гарц гэж тооцдог. Зарим тохиолдолд шилжин суурьших нэрийн доор гэрлэлт хийн худалдаж, өрийн барьцаанд оруулдаг.

Хууль бус үрчлэлт: Хүмүүсийн дунд хүүхэд үрчлэх хүсэл нэмэгдсэн нь нярай болон бага насны хүүхдүүдийг хууль бусаар худалдах явдлыг нэмэгдэхэд нөлөөлж байна. Дотоодод болон гадаадын иргэдэд хүүхэд үрчлүүлэх асуудлаар дамжин ХХГХ үйлдэгдэх магадлалтай.

Спорт: Хүүхдийг, тэр дундаа бага насны эрэгтэй хүүхдийг уралдааны морь унуулж байгаа нь бэртэж гэмтэх, амь нас, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл дагуулж,

¹⁵ <http://www.mn-nhrc.org/229-rtiyryor-sssryorr-rssrrtrss-ssrrrrrr.html>

¹⁶ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, Хүүхдийн Хөдөлмөрийн устгах Олон улсын Хөтөлбөрөөс хамтран гаргасан *Facts on Commercial sexual exploitation of children /Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх бодит байдал/ хэмээх тайлан. [www.ilo.org/childlabour, February 2005]*

¹⁷ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан *Fact Sheet: Protection and Conflict, Бодит байдал: Аюулаас хамгаалах болон Зөрчилдөөн хэмээх тайлан. [www.unicef.org, February 2005]*

аюул занал учруулдаг. Хүүхдүүд өөрсдийн хүсэл сонирхлоос гадуур бизнесийн зорилгоор морь уралдуулж, ашиг олж буй хүмүүст хөдөлмөрөө мөлжүүлж, сурах эрхээ алдаж байна.

2007 онд Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө үндэсний газраас хийсэн тооцоогоор улсын хэмжээнд хурдан морь унадаг 27600 орчим хүүхэд байдаг гэсэн тооцоо гарчээ. Эдгээр хурдан морь унаач хүүхдүүд давхардсан тоогоор 150.0 орчим удаа морин уралдаанд оролцдог байна¹⁸.

Гуйлга: Гуйлга гуйх, гудамжинд юм худалдах зэргээр бусдад мөнгө олуулахын тулд хүүхдийг худалдаалж, бага насны хүүхдийг түрээслүүлэх замаар мөлждөг. Зарим тохиолдолд гуйлга гуйж буй хүүхдүүдийг өрөвдүүлж илүү их мөнгө олуулахын тулд зэрэмдэг болгодог.

Эд эрхтэний зорилго: Энэхүү аймшигт үйл ажиллагааг илрүүлэх, хянах боломж бараг байдаггүй ч энэ тухай мэдээлэл ирдэг байна. Гэвч олон улсын тайлан, судалгаануудад дурдагдсанаар насанд хүрэгчид энэхүү гэмт хэрэгт илүүтэй өртдөг бөгөөд хүүхдийг эд эрхтний зорилгоор худалдах нь бага байдаг.

1.5. Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн байдал


Манай улсад үйлдэгдэж буй ХХГХ нь доорхи хэлбэрүүдээр илэрч байна. Тухайлбал: гадаадад болон дотоодод бэлгийн мөлжлөг (70 гаруй хувь)-ийн зорилгоор, мөн зуучлалын захиалгат гэрлэлт (10 орчим хувь) нэрийн доор болон дотоод гадаадад албадан хөдөлмөр (20 орчим хувь) эрхлэх зэрэг хэлбэрүүд болно.

Мөн ХХГХ-г оролцож буй байдлаар нь дэлхийн улсуудыг гаргагч, дамжуулагч, хүлээн авагч улс хэмээн 3 түвшинд авч үздэг.

- Монгол улсыг 1999 оноос өмнө ХХГХ-ийн **дамжуулагч улс** гэж үздэг байсан бөгөөд БНХАУ, БНАСАУ-ын иргэдийг манай улсаар дамжуулан гуравдагч оронд гаргаж байсан тухай мэдээллүүд байдаг.
- Харин 2001 оноос хойш олон улсын хэмжээнд ХХГХ-ийн **гаргагч орон** гэж үзэж буй нь тус улсын иргэд БНХАУ-ын хот, мужууд, Макао, Гон-Конг, БНСУ, Сингапур, Тайван, Турк, Израйл, Япон, Малайз, АНУ, Герман болон ЕХ-ны улсуудад худалдагдсан албан ёсны эх үүсвэрүүдээс үүдэлтэй.
- Зарим тайланд¹⁹ дурдагдсанаас үзвэл **хүлээн авагч** орон болсон байх магадлалтай тухай дурдагдсан байдаг. БНХАУ, БНАСАУ-ын иргэдийг барилга, замын салбарт ажиллуулах явцад хөдөлмөр нь мөлжигдөж байгаа тухай мэдээлүүд тайланд дурдагджээ.

¹⁸ Монгол улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгааны тайлан, ХЭҮК, 2008 он, хуудас 77

¹⁹ www.humantrafficking.org/mongolia



Мөн зарим эх сурвалжаас харахад үрчлэлт нэрийн доор хүүхдийг худалдаалах боломжтой байгаа бөгөөд хараа хяналтгүй хүүхдийн асуудал ч өндрөөр тавигдаж байна. Хараа хяналтгүй хүүхдийг хүч хэрэглэн гэмт хэрэг үйлдүүлэх, хуурамч бичиг баримт ашиглан хилийн чанадад аваачин хулгай хийлгүүлэх зэрэг хэргүүд мэдээлэгдэж байгаа ч араас нь нэхэмжлэх хүнгүйгээс хэн хаана хохирёон талаар бодит тоо мэдээг олох боломж хязгаарлагдмал байгаа юм. Зарим тохиолдлуудад бага насны хүүхдээ бусдад өдрийн 5000-12000 төгрөгөөр түрээслүүлэн гуйлга гуйлгаж амьдарч буй мэдээллүүд ч цагдаагийн байгууллагад бүртгэгдэж эхэллээ. Уламжлалт спорт өөрчлөгдөж, улирал харгалзахгүй элдэв уралдаан тэмцээн зохиогдон, арилжааны шинж нь хэт давамгайлснаас хурдан морь унаач хүүхдүүд хөдөлмөр нь мөлжигдөж, эрх нь зөрчигдөж байгааг ХТҮГ-аас мэдээлэх болсон. Энэ гэмт хэргийн талаар илүү сайн мэдлэгтэй байж, гэмт хэргийг үйлдэгдэхээс өмнө таслан зогсоож, урьдчилан сэргийлж чадах нь өнөөдөр энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагууд төдийгүй иргэн бүрийн үүрэг болоод байгаа билээ.

Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэх үе шатууд



Гэвч эдгээр үеүд нь давхцаж болдог. Зарим хохирогчид нэг газраас нөгөө рүү дахин дахин тээвэрлэгдсээр байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь маш нарийн зохион байгуулалттай бөгөөд илрүүлэн танихад хүнд байдаг.

Жишээ нь нэг эмэгтэй зочид буудалд ажилд авах зарын дагуу хандаад эцэст нь баар буудал гэх зэрэг газруудад биеэ үнэлэгч болж хувирч болох юм. Эсвэл хэн нэг нь загвар өмсөгч болгоно гэсэн сайхан амлалт авсан боловч порно кинонд хүчээр тоглох нөхцөлд ч орж болно. Залуухан бүсгүй нэг залууд дурлан харийн оронд очиж хуримаа хийн сайхан амьдарна гэсэн үгэнд нь хууртан дагаж яваад түүний найзуудад сексийн зорилгоор худалдагдах тохиолдол ч байхад хүүхдийг гадаадад аваачин сургуульд сургаж, өндөр боловсрол олгох санал тавих боловч тэднийг гудамжинд гуйлга гуйн эсвэл хулгай хийж байгааг нь олох нь ч бий. Гэмт этгээдүүд нь сайтар зохион байгуулагдсан гэмт хэргийн бүлэглэл эсвэл уг гэмт хэргийн явц тус бүрт оролцдог бие хүмүүс ч байж болно. Жишээ нь хуурамч бичиг баримт бүрдүүлэх, тээвэрлэлт, орон байраар хангах гэх мэт. Хүн худалддаг гэмт этгээдүүд маш аюултай ба ямар ч аймшигтай гэмт хэргийг үйлдэхэд бэлэн байдаг бөгөөд өөрсдийгөө үргэлж сайтар халхлан нууж санхүүгийн сонирхлоо хадгалж байдаг.

1.6. Хүн худалдаалах гэмт хэрэг ба цагаачлал, хууль бусаар хил нэвтрүүлэхийн ялгаатай талууд

Жил бүр олон хүмүүс түр болон удаан хугацаагаар нэг газраас нөгөөд шилжин нүүдэг бөгөөд энэ нь сайхан амьдрах, амьжиргаагаа дээшлүүлэх хүсэлтэй нь холбоотой байдаг. Улс орон хоорондын цалингийн болон амьдралын хэв маягийн ялгаатай байдал нь хүмүүст өндөр хөгжилтэй улс руу явж амьдралаа сайжруулна гэсэн найдлага төрүүлдэг.

- **Шилжилт хөдөлгөөн** гэж нэг улсаас нөгөөд, мөн улс дотроо шилжих хөдөлгөөнийг (бичиг баримт нь хууль ёсны дагуу байна. Харин тухайн улсад очсон хойноо тухайн улсын цагаачлалын болон хөдөлмөрийн хуулийг зарчих асуудлууд гардаг).
- **Хууль бусаар хил нэвтрүүлэх** гэж гуравдагч этгээд хэн нэгнийг ашиг олох зорилгоор хулгайгаар хил давуулах үйлдлийг (бусдын бичиг баримт ашиглах, хил зөрчих, хулгайгаар хил нэвтрэх зэрэг үйлдлүүдээр илэрдэг)
- **Хүн худалдах гэмт хэрэг** гэж хэн нэгнийг шилжүүлэн гуравдагч этгээдэд ашиглуулан мөлжих үйлдэл юм. Насанд хүрэгчдийн хувьд хууран мэхлэх, залилах аргаар үйлдэгддэг. (Шилжүүлэх үйлдэл нь дотоодод болон хил дамжсан байж болно)

Хүн худалдаалах гэмт хэрэг болон шилжилт хөдөлгөөний ялгаа

Хүнийг хууль бусаар хил давуулах нь аливаа улс орны цагаачлалын, шилжилт хөдөлгөөний гэх мэт хуулийг л зөрчиж байгаа бол хүн худалдах гэмт хэрэг нь хүний эрхийг зөрчиж байдаг тул “хохирогч” гэсэн нэр томъёо зөвхөн энд л хэрэглэгддэг. Хүн худалдаалах, хүнийг хууль бусаар хил давуулах гэмт хэрэг нь хоёулаа хүнийг зөөж тээвэрлэж байгаагаараа гэмт хэргийн эхний адил алхмуудыг хийж байгаа боловч хүнийг хууль бусаар хил давуулагчдын хувьд урвуулан элсүүлэх гэсэн процесс байдаггүй, ихэвчлэн хилийг хууль бусаар давах гэсэн хүмүүс өөрсдөө тэдэнд хандсанаар уг хэрэг гардаг

Хууль бусаар хил давахыг хүсэгчид нь ямар ч аюултай нөхцөл байдлыг даван туулах байсан ч гэсэн өөрсдөө хүлээн зөвшөөрсөн байдаг бол хүн худалдах гэмт хэргийн хохирогчид нь өөрсдийг нь хүлээж байгаа зүйлийг зөвшөөрөөгүй, мэдээгүй байдаг.

Хууль бусаар хил давагчид тухайн очих гэсэн газраа очингуут асуудал дуусдаг бол хүн худалдах гэмт хэргийн хохирогчид нь хүний наймаа эрхлэгчдэд ашиг авчрах гол хэрэгсэл нь хэвээр байж мөлжлөгт өртсөөр л байдаг.

Хууль бусаар хил давуулах гэмт хэрэг нь дандаа улс хооронд болдог бол хүн худалдах гэмт хэрэг нь улс дотооддоо үйлдэгдэж болдог. Хууль бусаар хил давагчид нь хил дээр байхдаа л юу хийж байгаагаа мэдэж байдаг бол хүн худалдах гэмт

хэргийн хохирогчид нь эцсийн цэг дээр очиж, өөрсдөөр нь хийлгүүлэх ажил нь эхлэхэд л юунд өртсөнөө мэддэг.

Гэвч хууль бусаар хил давуулсны дараа ХХГХ-ийн хохирогч болгох тохиолдлууд ч байдаг тул хуульчдаас энэ асуудал дээр туйлын мэдрэмтгий ажиллахыг шаарддаг.

1.7. Хүн худалдаалах гэмт хэргийн үр дагавар

Гэмт хэргийн бүлэглэлүүдийн хувьд хүнийг худалдан авч, зарах “зардал” нь төдийлөн өндөр биш бөгөөд хар тамхи, зэвсгийн наймаанаас бага эрсдэл хүлээж, мөлжлөгийн явцад тогтвортойгоор асар их ашгийг олдог. Манай улсад ч жилээс жилд ХХГХ-т өртөж, хохирогчдын тоо нэмэгдсээр байгааг шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд болон туслалцаа хүсэж үйлчилгээ авсан төрийн, ТББ-ын тоо мэдээнүүдээс харж болно.

Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэх явцад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан бие даасан хэд хэдэн гэмт хэрэг давхар үйлдэгддэг. Тухайлбал, хуурамч бичиг баримт үйлдэх, ашиглах, хулгайлах, устгах, нуух, хүн хулгайлах, хууль бусаар хорих, насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хууль бусаар хил нэвтрүүлэх, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах, түүнд оролцох, хууль бусаар үр хөндүүлэх, заналхийлэх, хүчиндэх г.м гэмт хэргүүд давхар үйлдэгддэг онцлогтой. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийг хуулийн байгууллагад мэдээлэх, шалгах ажиллагаанд саад учруулах зорилгоор хохирогчдыг айлган сүрдүүлэх, заналхийлэх, аргуудыг өргөн хэрэглэдэг.

Бүртгэгдсэн хэргүүдээс харахад хохирогчдын дийлэнхи нь 18-24 настай (70% гаруй) эмэгтэйчүүд байгаа бөгөөд бэлгийн мөлжлөгт өртөн, 95% нь худалдаалагдах, мөлжигдөх явцдаа бие болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байжээ²⁰. Хэдийгээр хохирогчид эх орондоо ирж чадсан ч тэдний маш бага хувь нь хууль хяналтын байгууллагад хандаж, эрхээ хамгаалахаар тэмцдэг.

1.8. Хүн худалдаалах гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйлс

Дотоодод гадаад ажилчдын хэрэгцээ өсөж, гадаадад мөн монгол ажилчид очиж ажиллах боломж бий болж байгаа ч энэ байдлыг зохицуулах зохицуулалт дутмаг байдал нь энэ гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйл болдог. Цагаачлал, гадаадад ажиллах боломжийн талаар мэдээлэл хүртээмж муутай байдгаас хуурч мэхлэгдэх, хууль бусаар гадаадад зорчих магадлал улам нэмэгддэг.

Хүн худалдах болон зугаа цэнгэлийн бизнесийн тэрбум доллараар хэмжигдэх ашгийн өсөлт нь хүн худалдах гэмт хэрэг үйлдэгчдийг өөгшүүлдэг. Хүн худалдах гэмт хэргийн бизнест гарч буй бага эрсдэл - өндөр орлогын шинж чанар, зуучлагч, худалдагч, худалдан авагчдад хуулийн хариуцлага тооцох, илрүүлэх, арга хэмжээ

²⁰ ХТЭТ-ийн тайлан мэдээ, 2010 он

авах боломж дутмаг байдал нь энэ гэмт хэргийг улам бүр өөгшүүлж байна.

Сүүлийн үед биеэ үнэлэгчдийг авах нь маш их эрэлт хэрэгцээтэй, ялангуяа бага насны хүүхдүүд ихээхэн эрэлттэй болж, биеэ үнэлэгчид зохион байгуулалтанд орж, зуучлагчаар дамжих болсон.

Мөн энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, мэдээлэл, шийдвэрлэлт төдийлөн сайн биш, хэрэг шалгах хугацаа хэт удаан, хуулийн байгууллагын ажилтнуудын харьцаа, хохирогч, гэрчийг хамгаалах бодлогогүй зэрэг байдал нь хохирогчийг хуулийн байгууллагаас татгалзахад хүргэдэг. Зөвхөн 2006 онд гэхэд дэлхий даяар ХХГХ-ийн 5808 эрүүгийн гэмт хэрэг холбогдох байгууллагуудад мэдүүлж шалгагдсанаас 3160 нь шийдвэрлэгджээ. Энэ нь ХХГХ-ийн 800 хохирогчдын тутамд нэг гэмт хэрэгтэнд ял оноосон гэсэн үг юм²¹

Хэдийгээр ХХГХ-тэй тэмцэх олон ажлуудыг хийж байгаа ч энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл авсан даруй хохирогчийг эрэн сурвалжлах, гэмт хэргийг таслан зогсоох тал дээр төдийлөн амжилтанд хүрч чадаагүй. ХХГХ-ийг үүсгэж буй хүчин зүйлс, шалтгаан нөхцлүүдтэй бүрэн хэмжээнд тэмцэж байж энэ хэргийг шийдвэрлэх, бууруулах, улмаар таслан зогсооход амжилтанд хүрч чадна. Ялангуяа энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, хохирогч хамгааллын асуудал дээр төрийн, ТББ-ын нягт хамтын ажиллагаа чухал үр дүнтэй.

²¹ АНУ-ын Төрийн департаментын ХХГХ-ийн судалгааны тайлангийн 36-р тал /2007 он/

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

2.1. Монгол улсын хууль тогтоомж

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь 2000 оноос эхэлсэн. 2000 онд батлагдсан Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд Эрүүгийн хуулийн 111-р зүйлийн 1-д “**Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол 3- 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ**” гэсэн заалтыг шинээр оруулсан байна. Энэ нь хүний биеийг үнэлүүлж ашиг олохоор хууран мэхэлж гадаадад гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх анхны заалт байсан байна.

2002 оны 9-р сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлд «Хүн худалдах, худалдан авах» гэмт хэргийг хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн чухал алхам болсон.

2008 оны 02 сарын 01 өдөр эрүүгийн хуулийн 113-р зүйлийг өөрчлөн найруулсан.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл; “хүн худалдаалах гэмт хэрэг”

113.1. “Ашиг олох зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

113.2. Энэ хэргийг;

113.2.1. Насанд хүрээгүй хүнийг;

113.2.2. Хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.3. Хулгайлах,

113.2.4. Эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.5. Давтан,

113.2.6. Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

113.3. Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.²²

Гэмт этгээдийн зүгээс хүнийг худалдаалахын тулд худалдагдаж буй хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах хууран мэхлэх, эрх мэдлээ ашиглах болон эмзэг байдлыг нь далилдуулах зэрэг аргыг ашиглан бусдыг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах үйлдлээр илэрнэ.

Хүч хэрэглэх гэдэгт: биеийн хүчээр хохирогчид халдаж, хөнгөн, хүндэвтэр, гэмтэл учруулсан, учруулах бүрэн боломжтой байна. Мөн сэтгэл зүйн хүч хэрэглэж болно. Биеийг нь үнэлүүлэхийн тулд болон албадан хөдөлмөрлүүлэхийн тулд хохирогчийн бие сэтгэцэд хүчтэй нөлөөлөх, амь насанд нь аюултай эм уулгах, тариа хийх, гоо сайхны болон мэс ажилбар хийх явдлаар илэрч болох юм.

Хүч хэрэглэхээр заналхийлэх гэдэгт: төрөл бүрийн гэмтэл учруулах, алах, эрх чөлөөг нь хязгаарлах гэх мэтээр заналхийлэх сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөхийг ойлгоно.

Хууран мэхлэх гэдэгт: үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ.²³ Өөрөөр хэлбэл элдэв хуурамч аргаар төөрөгдүүлэх замаар гадаад улс оронд гарахад хүргэх, тухайлбал: хууран мэхлэгч өөрийн ажил албан тушаал, үйл ажиллагааны боломжийг дөвийлгөн ойлгуулах замаар /гадаадад өндөр цалинтай ажилд оруулна, гадаадын иргэнтэй гэр бүл болгоно, гадаад хэл сургана гэх мэт/ түүнчлэн хуурамч бичиг баримт /гадаадад ажиллах хүч гаргадаг тусгай зөвшөөрөлтэй байгууллага гэх мэтээр/, тусгай албаны хувцас, цол тэмдэг ашиглан төөрөгдүүлэх /үнэмшүүлэх/ замаар түүнийг элсүүлсэн байж болно.²⁴

Эмзэг байдлыг нь далимдуулсан гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.²⁵

Элсүүлсэн гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтонд нэгэн адил хамаарна.²⁶

Тээвэрлэсэн гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд

²² Төрийн мэдээлэл.УБ.,2008.,№5

²³ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

²⁴ С.Жанцан.Монгол улсын Эрүүгийн эрх зүй” тусгай анги.УБ.,2003.,158-р тал

²⁵ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

²⁶ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.²⁷

Дамжуулсан хүн худалдаалж байгаа мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно.²⁸

Орогнуулсан гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүн худалдаалж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.²⁹

Хүлээн авсан гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.³⁰

Улсын Дээд Шүүхээс 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолдоо Эрүүгийн хуулийн 113-р зүйлийн тайлбарын 1 дэхь хэсгийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

Биеийг нь үнэлүүлэх гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.

Бэлгийн хүчирхийлэлд оруулах гэдэгт биеийг үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчилахад татан оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно. Өрийн дарамтанд оруулах зэргээр биеийг үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.

Албадан хөдөлмөр хийлгэх гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.

Боолчлох гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.

Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах гэж хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.

Эд эрхтнийг авч ашиглах гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эд /өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг/-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.

²⁷ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

²⁸ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

²⁹ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

³⁰ Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

2.2. Олон улсын гэрээ, протокол, хэлэлцээр

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн олон улсын гэрээ конвенцуудын түүхэн тойм:

1. 1899 онд Бэлгийн мөлжлөгийн зорилгоор эмэгтэйчүүдийг худалдахын эсрэг Лондонгийн бага хурлын тэмдэглэл гарч, улмаар 1904, 1910 онуудад “Цагаан боолын худалдаа”-г хориглосон олон улсын гэрээ хийгдсэн байна.
2. 1921 онд Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдахыг хориглосон олон улсын конвенци, 1927 онд Боолчлолын эсрэг конвенцийг Үндэстнүүдийн Лиг батлан гаргасан явдал нь анхны хүний эрхийг хамгаалсан орчин үеийн олон улсын гэрээ байсан юм.
3. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас батлан гаргасан “Албадан хөдөлмөрийн эсрэг конвенци” нь хүнийг боолчлолтой төстэй нөхцөлд хүчээр хөдөлмөрлүүлэхийг хориглосноороо мөлжлөгийн зорилгоор хүн худалдах явдлыг хязгаарлахад дөхөм үзүүлсэн.
4. 1933 онд эмэгтэйчүүдийг худалдаалахыг хориглосон олон улсын конвенци батлагдан гарсан. Энэ нь хохирогч эмэгтэйчүүд ухамсартайгаар/ямар нэгэн хүч, дарамтгүйгээр/ энэ үйлдэлд хамрагдсан байсан ч гэмт хэрэгт тооцохоор заасан байлаа. Ийнхүү хүн худалдах, худалдан авах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө нийт 5 гэрээ конвенциуд батлагдаж байсан байна.
5. Дамжуулан худалдах ба биеэ үнэлэх хоёрын холбоо хадгалагдан явсаар эдгээр 4 гэрээ конвенцийг нэгтгэн 1949 оны “Хүнийг дамжуулан худалдах болон бусдын биеийг үнэлүүлэн ашиглахыг хориглох олон улсын гэрээ” батлагдсан. Энэ гэрээ нь хүн худалдах асуудлыг зөвхөн биеэ үнэлэх асуудалтай холбож үзэж байсан ба энэ өрөөсгөл ойлголт нь өнөөг хүртэл хүн худалдахын эсрэг зарим үйл ажиллагаанд хадгалагдсаар ирсэн. Мөн эдгээр конвенциуд нь зөвхөн биеэ үнэлүүлэх зорилгоор худалдаалагдсан эмэгтэйчүүд, хүүхдүүдээр хязгаарлагдсан ажээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 8-р зүйлд

Хэнийг ч боолчлолын байдалд байлгаж болохгүй, боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно. Хэнийг ч өөрийн эрх мэдэлгүй байлгаж болохгүй хэмээн хүн худалдаалахтай холбоотой ямар ч үйлдэл эс үйлдэхүйг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөхгүй байх үндсийг баталгаажуулсан.

А. ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НУБ-ЫН КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ БОЛОХ ХҮН, ЯЛАНГУЯА ЭМЭГТЭЙЧҮҮД БОЛОН ХҮҮХЭД ХУДАЛДААЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ БА ШИЙТГЭХ ТУХАЙ ПРОТОКОЛ

Хүний наймаа буюу хүн худалдаалах гэмт хэрэг нь ямагт зохион байгуулалттай төдийгүй олон улсыг хамарсан онцлог шинжийг өөртөө агуулдаг. Энэ ч утгаараа хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт

хэргийн нэг бие даасан төрөл гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх зорилгоор 2000 оны 12 сард “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-г бага хуралд оролцогч улсуудаас санаачлан гарган мөрдөж байна.

НҮБ-ын энэхүү конвенц нь 41 зүйлээс бүрдсэн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг баглан гаргасан олон улсын шинжтэй эрх зүйн томоохон актуудын нэг юм. Одоогийн байдлаар 100 гаруй улс гарын үсэг зурж дээрхи конвенцид нэгдэн орж өөрийн үндэснийхээ хууль тогтоомжоор соёрхон баглаад байна.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-н конвенцын нэмэлт байх хүн, ялангуяа хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай протокол нь дараах зарчмыг тодорхойлжээ.

Тухайлбал: Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, ингэхдээ эмэгтэйчүүд ба хүүхдийн хувьд тусгайлан анхаарал тавих. Хүн худалдаалах хэргийн хохирогчдын хүний эрхийг бүрэн хүндлэн тэднийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, хамтын ажиллагааг дэмжих зэрэг зорилгуудыг тунхаглажээ.

Мөн Палермогийн протоколоор хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар нарийвчилсан зохицуулалтыг бий болгожээ. Тухайлбал оролцогч улсууд хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор судалгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн компанит ажил явуулах, түүнчлэн нийгэм, эдийн засгийн холбогдох санаачлагуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авахыг өрмэлзэнэ.

Протоколын гол онцлог нь:

1. Хүний худалдааг хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлон хууран мэхлэх болон мөлжлөгийн зорилготой гэж тэмдэглэжээ.
2. Хүнийг худалдаалах явцын хэсэгчлэлийг үйлдэл тус бүрд нь шинэ хүн цуглуулах, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах болон хүлээн авах гэж ангилан задалжээ.
3. Зөвшөөрлийг нь авахын тулд эмзэг байдлыг нь урвуулан ашиглах, хуурч мэхлэх, сүрдүүлэх, заналхийлэх, бүдүүлэг хүч хэрэглэхээс авахуулаад уран арга бүхий итгүүлэн үнэмшүүлэх зэрэг олон арга хэрэглэдэг.
4. Хүнийг дамлан худалдаалахад эмэгтэйчүүд хүүхдүүдээс гадна эрэгтэй хүмүүс өртдөг нь хүлээн зөвшөөрөгдсөн.
5. Хүний наймаа нь бэлгийн мөлжлөгөөс авахуулаад өөр олон зорилгоор үйлдэгддэгийг таньж мэдэхэд дөхөмтэй болсон.
6. Эрхэд тулгуурласан болон нийгэм эдийн засгийн, улс төрийн, хуулийн хамгаалах арга хэмжээнүүдэд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, худалдаалагдсан хүмүүсийг хамгаалах, туслах, буцаах, нөхөн сэргээх, мөн хүн худалдаалагчдыг шийтгэх болон холбогдох арга хэмжээнүүдийг агуулснаар

чухал ач холбогдолтой болсон.

7. Түүнчлэн хүн худалдаалахтай тэмцэх болон урьдчилан сэргийлэх ажилд баримтлах гол үзэл хандлагыг тусгаж өгсөн.

Б. ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦИ, НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН АГУУЛГА

Хүн худалдаалах гэмт хэргийн объектын нэг төрөл, халдлагын зүйл нь хүүхэд түүний эрх билээ. Тийм ч учраас хүүхдийн эрхийн талаар олон улсын түвшинд онцгойлон авч үзэж НҮБ-н Хүүхдийн эрхийн тухай конвенцийг Ерөнхий Асамблейгаар хэлэлцэн баталсаныг манай улс 1990 оны 7 дугаар сарын 5-нд УИХ-аар соёрхон батлан дагаж мөрдөж байна. Хүүхдийн эрхийн НҮБ-ын конвенци нь 40 зүйлээс бүрддэг.

Энэ конвенциор дэлхийн улс орнуудад хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд бүрт онцгой анхаарал шаардлагатай, улмаар хүүхдийг хамгаалах өв тэгш хөгжүүлэхэд ард түмэн бүрийн уламжлал, соёлын үнэт зүйлс чухал гэдгийг харгалзан, улс бүрт, ялангуяа хөгжиж байгаа орнуудад хүүхдийн амьдралын нөхцөлийг сайжруулахад олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрөн баталжээ.

Монгол улсын хувьд ч дээрхи конвенцын агуулгыг бүрэн хүлээн зөвшөөрч Монгол улсын их хурлаас “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг” 1996 оны 5 дугаар сарын 7-нд батлагдан одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцаас гадна “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц”-ийн 1-р зүйлд Хүүхдийг хулгайлах, худалдаалах, эсхүл дамлах явдлаас сэргийлэх зорилгоор хэлэлцэн тохирогч улс орнуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох талаар зааж өгсөн байна.

В. ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙН ТУХАЙ 182-Р ЗӨВЛӨМЖ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хүүхдийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар зөвлөмж нь 1999 онд батлагдсан бөгөөд Монгол улс 2000 онд нэгдсэн орсон³¹. Энэхүү конвенцийг соёрхон баталж буй гишүүн орон бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зорилготой.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд гэдэгт:

- Боочлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдаалах, дамжуулан худалдаалах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боочлолтой төстэй үйл ажиллагаанууд,

³¹ Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүүхдийн хөдөлмөрийг устгах Олон улсын хөтөлбөр “Хүүхдийн хөдөлмөр” их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг 263-р хуудас

- Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох,
- Хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох, гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох,
- Мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэхүйц ажлыг хамааруулна.

Г. ХҮҮХДИЙГ ХУДАЛДААЛАХ, ХҮҮХДИЙН БИЕЙГ ҮНЭЛЭХ, САДАР САМУУНД СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ НЭМЭЛТ ПРОТОКОЛ³²

Монгол улс нь хүүхдийн эрхийн конвенцийн хүүхдийг худалдаалах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколд 2002 онд нэгдэн орсон.

Уг конвенцийн Хүүхдийг худалдаалах, биеийг үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг Нэмэлт Протокол 2000 оны 05 сард батлагдсан. Энэхүү Нэмэлт Протокол нь 182-р Конвенц дэх хүүхдийг худалдаалах, биеийг нь үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг үзэл санааг баяжуулахдаа холбогдох нэр томъёог тодорхойлж, авах хариу арга хэмжээг тухайлан зааснаар онцлогтой. Жишээ нь: зарим үйл ажиллагааг тодорхойлж тэдгээрийг үндэсний эрүүгийн хуулиар хориглох үүргийг Гишүүн орнууд хүлээх, Протоколд хориглосон үйл ажиллагааны хохирогч хүүхдүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг тодорхойлж, зохистой арга хэмжээ авах үүргийг Гишүүн орнууд хүлээх, Протоколд хориглосон гэмт үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх үүргийг Гишүүн орнууд хүлээхээр заасан.

Мөн бусад улс орнуудад боолчлол, түүнийг практикт тодорхойлох, хориглох, тэдгээрийн эсрэг тэмцэж буй олон улсын жишиг³³ талаар дурьдахад

1. Нигер зэрэг зарим оронд насанд хүрсэн хүнийг худалдсанд оногдуулах ял нэг тусдаа, харин хүүхдийг худалдсан тохиолдолд оногдуулах ял тусдаа, бүр ч хатуу чангаар тогтоогдсон байна. Түүгээр ч зогсохгүй хэд хэдэн хүүхдийг худалдсан бол цаазаар авах ялыг оногдуулах боломжтой.
2. Ирланд улс хүүхдийг дамжуулан худалдсан, биеийг нь үнэлүүлсэн, садар самуунд ашигласан сэжиглэгдэж буй орон байр, тэнд байгаа хүмүүсийг нэгжих эрхийг эрх бүхий байгууллагадаа олгосон байна.
3. Хятадад хүн худалдсан гэмт хэрэгтний, улс төрийн эрхийг хасах, төр, олон нийтийн алба хаших эрхийг тодорхой хугацаагаар хасах зэрэг бусад шийтгэл оногдуулдаг байна.

³² Хүүхдийн хөдөлмөрийн эрсэг орчин үеийн бодлого, эрх зүйн шийдлүүд, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүний эрхийн дээд Комиссарын газар, http://www.ohchr.org/english/countries/ratification/11_b.htm

³³ Хүүхдийн хөдөлмөрийн эрсэг орчин үеийн бодлого, эрх зүйн шийдлүүд, Олон улсын хөдөлмөрийн байгууллага

4. Хятадад хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах, дамжуулан худалдаалах гэмт хэрэгт 5-10 жилээр хорих, дээр нь торгох ялтай. Хэрэв дараах нөхцөл байдал үүссэн бол ялыг хүндрүүлж 10 жилээс дээш болон насаар нь хорих, түүнчлэн өмч хөрөнгийг нь хураах ял оноодог байна:
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах, дамжуулан худалдаалах хэргийг зохион байгуулалттайгаар үйлдсэн
 - Гурав ба түүнээс дээш тооны хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлсан, дамжуулан худалдсан
 - Хулгайлсан эмэгтэйг хүчиндсэн
 - Хулгайлсан эмэгтэйг уруу татах, хууран мэхлэх, хүч хэрэглэх аргаар биеэ үнэлэхэд татан оруулсан, эсвэл хулгайлсан эмэгтэйг өөр этгээдэд зарсан ба нөгөө этгээд эмэгтэйн биеийг үнэлүүлсэн
 - Худалдаалах зорилгоор, хүч хэрэглэх, заналхийлэх, мансууруулах, замаар хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлсан
 - Худалдаалах зорилгоор нялх хүүхдийг хулгайлсан, булаасан
 - Хулгайлагдсан хүүхэд, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл урчуулсан, амийг нь бүрэлгэсэн, бусад ноцтой хохирол учруулсан
 - Хулгайлагдсан хүүхэд, эмэгтэйчүүдийг өөр улс оронд худалдсан.
5. Макаогийн Тусгай Захиргааны Бүс биеийг нь үнэлэх зорилгоор хүнийг дамжуулан худалдсан бол уг гэмт хэргийг өөр орны нутаг дэвсгэрт үйлдсэн эсэхээс үл хамааран 2-8 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ. Хэрэв гэмт хэргийн хохирогч нь 18 хүртэлх насны хүүхэд бол ялын хэмжээг гуравны нэг дахин нэмэгдүүлж онооно. Хэрэв гэмт хэргийн хохирогч нь 14 хүртэлх насны хүүхэд бол 5-15 жилээр хорих ялтай.
6. Беларуст, хүн худалдсан этгээдийн өмч хөрөнгийг хураах шийтгэлтэй.
7. Экваторт, хамжлага болгох явдлыг хүүхдийг дамжуулан худалдаалах гэмт хэргийн мөлжлөгийн нэг хэлбэр гэж тодорхойлжээ.

2.3. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай эрх зүйн харилцан туслалцааны тухай үндсэн ойлголт³⁴

Даяарчлагдаж байгаа өнөө үед Монгол Улсын иргэд хилийн чанадад олноор оршин суух, сурч, хөдөлмөрлөх болсонтой холбоотойгоор Монгол улс болон Монгол улсын төрийн байгууллагын хувьд хилийн чанад дах өөрийн иргэдийг хамгаалах, улсын ашиг сонирхолыг хангахын тулд бусад улстай зохих түвшний харилцаа холбоо тогтоох шаардлага улам их өсөн нэмэгдсээр байна. Дипломат шугамаар бусад улстай харилцах нь цаг хугацааны хувьд удаашралтайгаас гадна дипломат шугамаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагааг явуулахад зохимжгүй байдаг. Иймд төрийн холбогдох байгууллагуудтай эрх зүйн туслалцааны гэрээ байгуулах замаар шууд харилцах нь илүү шуурхай, үр дүнд хүргэдэг. Эрх зүйн туслалцааны гэрээ нь хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудын хооронд шууд бөгөөд тогтвортой харилцааг тогтоож өгдөг. Гадаад элемент бүхий хэргийн эрх зүйн гол асуудал нь шүүх эрх мэдэлтэй холбоотой асуудал байдаг. Шүүх эрх мэдлийг өргөн утгаар нь засаглал хуваах зарчмын дагуу онцгой эрх мэдлийн нэг гэж ойлгох бол явцуу утгаар нь шүүхийн харьяалалыг ойлгоно. Шүүх эрх мэдлээр шүүх ажиллагаа тухайн улсын нутаг дэвсгэрийн хүрээгээр хязгаарлагддаг. Ингэхдээ өөр улсын нутаг дэвсгэрт процессын ажиллагааг үргэлжүүлэх шаардлагатай байдаг. Хэрэв бүрэн эрхийн зарчим өөр нэг улсын шүүх эрх мэдлийг гадаад улсын шүүх эрх мэдлээс ангид байх байдлыг хангадаг бол эрх зүйн туслалцаа хүсэх нь тухайн шүүх ажиллагааг үргэлжлүүлэх цорын ганц боломж нь байдаг. Олон улсын практикт гадаад улсын шүүх эрх мэдлийг гүйцэтгэх ажиллагаа нь холбогдох гэрээний зохицуулалтгүйгээр найрсаг харилцаан дээр тулгуурлан явагдаж болох хэдий ч гадаадын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үүргийг олон улсын гэрээгээр тогтоож, гүйцэтгэлийг нь хангаж өгдөг. Ингэхдээ тухай гэрээгээр тогтоосон журмын дагуу бүх ажиллагааг явуулна. Шүүхийн ажиллагааг тухай улсын шүүхийн байгууллага нь зөвхөн өөрийн нутаг дэвсгэр дээр явуулна. Гадаад улсын нутаг дэвсгэр дээр явуулах тохиолдолд ажиллагааг анх явуулж байсан улсаас зөвшөөрөл авсан байх ёстой.

Иймд шүүх ажиллагааг хилийн чанадад явуулах гол хэрэгсэл нь шүүхийн даалгавар болдог. Улс гүрнүүд олон улсын эрх зүйн үндсэн субъектын хувьд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулдаг. Эдгээр гэрээндээ эрх зүйн туслалцааг үзүүлэх хэлэлцэн тохирогч эрх бүхий байгууллагыг тогтоож өгдөг. Зөвхөн гэрээнд тогтоосон байгууллагуудаар дамжуулан эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын үүргээ улс гүрнүүд хэрэгжүүлдэг. Эдгээр байгууллагуудаар дамжуулан эрх зүйн туслалцаа үзүүлэх даалгавар болон хүсэлтийг дамжуулахын зэрэгцээ мөн эдгээр байгууллага нь өөрийн улсын нутаг дэвсгэр дээр эрх зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулдаг. Харилцан туслалцаа үзүүлэх зохицуулалт нь туслалцаа үзүүлэх субъектуудын хүрээг тогтоож тодорхойлох бөгөөд тэдгээрийн эрх хэмжээг болон туслалцаа үзүүлэх хүрээг тогтооно. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний зохицуулах зүйл нь эрх зүйн харилцан туслалцаа байхаас гадна үүнийг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн

³⁴ Хууль зүйн дотоод хэргийн яам, “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь” хуульчдад зориулсан гарын авлага, УБ хот, 2009 он, хуудас 12-15

харилцаа байна. Эдгээр харилцаа нь хоёр талын хамтран ажиллах байгууллагын эрх мэдэл, эрх хэмжээ болон харилцан хүлээх үүргийг тогтоосон гэрээгээр зохицуулагдана. Эрх зүйн туслалцаа үзүүлэх улс гүрний хамтын ажиллагаа нь олон улсын эрх зүйн салбар дахь хамтын ажиллагааны чухал хэлбэр мөн. Ийм хамтын ажиллагааны гол хэлбэр нь өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, шүүх эрх мэдлийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний эрх зүйн зохицуулалт

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нь дараах хэм хэмжээг агуулдаг. Үүнд:

- Материаллаг хэм хэмжээ
- Процессийн хэм хэмжээ
- Зөрчилдөөний хэм хэмжээ

Материаллаг хэм хэмжээ нь иргэн, хуулийн этгээдийн эрх мэдэл, эрх, үүргийг тодорхойлдог хэм хэмжээ юм. Тухайлбал, БНМАУ, БНХАУ-ын хооронд “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” 1989 оны гэрээний 8-р зүйлд “Хэлэлцэн тохирогч хоёр талын төв байгууллага харилцахдаа англи хэлийг хэрэглэнэ. Түүнчлэн хэлэлцэн тохирогч хоёр тал монгол, хятад, англи хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болох бөгөөд түүний загварыг харилцан солилцоно” гэж зааснаар гэрээнд оролцогч 2 талд эрх, үүргийг бий болгосон байна.

Процессийн хэм хэмжээ нь иргэн, хуулийн этгээдийн эрх мэдэл, эрх, үүргийг хэрэгжүүлэх журмыг тогтоодог бөгөөд тэдний эрхийг шүүхээр хамгаалах журмыг тогтоосон хэм хэмжээ байна. Жишээ нь: Дээр дурдсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 28-р зүйлд: “хэлэлцэн тохиролцогч хоёр Тал энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад бэрхшээл тохиолдвол дипломат шугамаар буюу энэхүү Гэрээний 3-р зүйлд заасан төв байгууллагаар дамжуулан харилцаж шийдвэрлэнэ”, “Хэлэлцэн тохирогч хоёр Тал эрүүгийн хэргийн талаар холбогдох этгээдийг шилжүүлэн өгөх, дамжуулан өнгөрүүлэх асуудлыг оролцуулан хоёр Талын эрх зүйн туслалцаа үзүүлэх хэмжээ хязгаарыг өргөжүүлэх болон хоёр Талын эрх бүхий байгууллага эрх зүйн туслалцааны талаарх харилцаанд тус дэмжлэг үзүүлэх асуудлыг дипломат шугамаар зөвлөлдөж болно” гэж тус тус заасан байна.

Зөрчилдөөний хэм хэмжээ нь гэрээ байгуулагч хоёр улсын хооронд үүссэн харилцааг зохицуулах баталгаа болох бөгөөд энэхүү хэм хэмжээ нь өөрөө харилцааг зохицуулдаггүй, зөвхөн хэрхэн зохицуулах зааврыг тогтоож өгсөн байдаг. Тухайлбал Дээрх дурдсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 10-р зүйлд “Даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Даалгавар хүлээн авсан байгууллага өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр тэрхүү улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.” Өөрөөр хэлбэл Хүсэлт хүлээн авсан тал тухайн харилцааг зохицуулах хууль тогтоомжийг сонгох боломжтой байдаг байна.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нийтлэг гэрээнд дараах үндсэн асуудлуудыг тусгасан байдаг. Үүнд:

- Гэрээний дагуу харилцах эрх бүхий байгууллагаа хэлэлцэн тохирогч улсууд тодорхойлох. Учир нь зөвхөн гэрээнд тодорхойлсон эрх бүхий байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт, түүний хэрэгжилтийг хангахыг хэлэлцэн тохирогч улсууд бие биенээсээ шаарддаг.
- Тухайн гэрээний үйлчлэх хүрээ буюу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлын хүрээг тодорхойлж өгдөг. Үүнд тухайн гэрээ нь иргэний болон эрүүгийн хэргийн талаар ямар төрлийн туслалцааг харилцан үзүүлэхийг тодорхойлсоныг ойлгож болно. Тухайлбал: Гэрээний дагуу ямар бичиг баримт гардуулах, байцаан шийтгэх ямар ажиллагаа явуулах, ямар ажиллагааг явуулахгүй байх, шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрч биелүүлэх эсэх зэргийг тусгах
- Эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтэд ямар асуудал тусгасан байхыг тодорхой заах.
- Эрх зүйн туслалцаа үзүүлсэн тухай хариу мэдэгдэх, эрх зүйн туслалцааг үзүүлэхээс татгалзах үндэслэл, эрх зүйн туслалцааг биелүүлэхтэй холбогдон гарах зардлын асуудал, хүсэлтийг ямар хэл дээр үйлдэж харилцах зэрэг асуудлууд болно.

Эрүүгийн хэргийн талаар даалгавар гүйцэтгэх³⁵

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны чухал хэлбэр бол Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудал юм. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлыг олон улсын түвшинд хоёр талт, олон талт гэрээгээр зохицуулахын сацуу дипломат шугамаар хүсэлт тавих боломж бас байдаг. Олон талт олон улсын гэрээ тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци олон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын /Палермогийн/ Конвенци түүний нэмэлт 3 протоколыг дурдаж болно. Энэхүү хоёр Конвенцид Монгол Улс нэгдсэн орсон. Конвенцид заасны дагуу гишүүн орнууд авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар өөрсдийн холбогдох байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтран ажиллах боломжтой болсон. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын /Палермогийн/ Конвенцид хуулийн этгээдийн хүлээх хариуцлага, албадлагын арга хэмжээ авах, хэрэг хянан шийдвэрлэх эрх, гэмт этгээдийг шилжүүлэх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, хамтарсан мөрдөн байцаалт явуулах аргууд, гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа техникийн туслалцаа үзүүлэх зэрэг асуудал тусгагдсан.

Хоёр талын олон улсын гэрээ тухайлбал, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, Иргэний ба Эрүүгийн хэргийн талаарх эрх

³⁵ Хууль зүйн дотоод хэргийн яам, “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь” хуульчдад зориулсан гарын авлага, УБ хот, 2009 он, , хуудас 21-26

зүйн харилцааны тухай гэрээ (1999 он), Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол Улс, БНХАУ хоорондын гэрээ (1997 он), Монгол Улс, БНЭУ-ын хооронд эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ (2001 он) гэх зэргээр нийт 15 улстай Монгол Улс энэ төрлийн гэрээг байгууллаад байна. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хулуийн 398 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааг явуулах тухай даалгаврыг гадаад улсын эрх бүхий байгууллагад явуулж болох тухай заасан бөгөөд энэхүү харилцааг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ гэж заасан байдаг.

Эрүүгийн хэргийн эрх зүйн туслалцааны хүсэлт нь дараахь нийтлэг шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

- Хүсэлт гаргасан байгууллагын нэр;
- Хүсэлт хүлээн авсан байгууллагын нэр;
- Эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн хэргийн нэр;
- Хүсэлтэд дурдсан сэжигтэн, яллагдагч буюу ялтан, гэрч, хохирогчийн овог нэр, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, эрхэлдэг ажил боломжтой бол тэдгээрийн төрсөн он, сар, өдөр;
- Хүсэлт гаргасан зорилго, гэмт хэрэгт тооцох баримт материал болон гэмт хэргийн тухай мэдээлэл;
- Эрүүгийн хэргийн талаар түүнчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх нэмэлт тодорхойлолт, түүний хуулийн зүйлчлэл, хэрэв уг хэргийн улмаас хохирол учирсан бол учруулсан хохиролын хэмжээ зэргийг тусгасан байхыг эн тэргүүнд шаардана.

Хүсэлт нь огноо, гарын үсэг, тамга тэмдэгтэй албан ёсны баримт бичиг байх бөгөөд хүсэлтийг өөрийн улсын албан ёсны хэл дээр үйлдэж Хүлээн авагч улсын хэл дээр эсхүл хоёр орны хооронд байгуулсан гэрээнд заасан хэл дээрх орчуулгыг хавсаргаж хүргүүлнэ. Ихэнх гэрээнд оролцогч улсууд ихэвчлэн өөрийн орны албан ёсны хэл дээр орчуулгыг хийх тухай заасан байдаг. Хүсэлтийг тухайн улстай байгуулсан гэрээнд заасан харилцах төв байгууллагаар дамжуулан Хүсэлт хүлээн авагч Танд илгээдэг. Хүсэлтийг Хүлээн авагч тал биелүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна. Хүсэлт хүлээн авагч Тал нь хүсэлтийг биелүүлсэн тухай бичиг баримтыг Хүсэлт гаргагч Талд илгээх бөгөөд хэрэв эрх зүйн туслалцааг үзүүлж чадаагүй, биелүүлэхэд хүндрэл учирсан бол нөхцөл байдлын талаархи тайлбарыг буцаах бичиг баримтад хавсарган хүргүүлэх үүрэгтэй. Харин Хүлээн авагч тал эрх зүйн туслалцаа үзүүлэх нь өөрийн орны бүрэн эрхт байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулахаар байна гэж үзвэл эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэхдээ татгалзсан шалтгааныг Хүсэлт гаргасан талд мэдэгдэнэ. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлэхдээ Хүсэлт хүлээн авсан улс өөрийн орны хууль тогтоомжийг баримтлах бөгөөд Хүсэлт гаргагч талын хүсэлтээр (хэрэв дотоодын хууль тогтоомжтой нь зөрчилдөхгүй бол) тухай орны процессын хэм хэмжээг хэрэглэж болдог. Иймээс хүсэлт гаргахын өмнө тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд Хүлээн авагч

Тал нь Хүсэлт гаргагч талын хууль тогтоомжийг хэрэглэж болох эсэх, хүсэлт (даалгавар) –ийг гүйцэтгэхэд аль улсын хууль тогтоомжийг ашиглах талаар заасан эсэхийг судалбал зохино. Хэрэв Хүсэлт хүлээн авагч байгууллага уг хүсэлтийг гүйцэтгэх эрх бүхий байгууллага биш бол холбогдох байгууллагад нь хүсэлтийг шилжүүлж энэ тухайгаа Хүсэлт гаргасан байгууллагад мэдэгдэнэ. Хэрэв хүсэлтэд холбогдогч этгээдийн хаяг тодорхойгүй байвал Хүсэлт хүлээн авагч байгууллага уг этгээдийн хаягийг тогтоохтой холбоотой шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой. Хүсэлтийг биелүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хүсэлт хүлээн авагч тал хариуцдаг нийтлэг зарчим байдаг бөгөөд гэрээнд заасан зарим нөхцлийн дагуу Хүсэлт хүлээн авагч талаас Хүсэлт гаргагч талд зарим зардлыг төлүүлэхээр нэхэмжилж болно. Тухайлбал, гэрч, шинжээчийн зардал, тусгай ажиллагаа явуулсан зардал гэх мэт. Хоёр талт гэрээний хүрээнд дараахь асуудлаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлж байна.

- **Бичиг баримт үйлдэх, илгээх, гардуулж өгөх Тодорхой этгээдэд:** Хүсэлт гаргасан байгууллагаас ирүүлсэн бичиг баримтыг хүлээлгэн өгөхдөө тухайн этгээд бичиг баримтыг хүлээлгэн өгөхдөө тухайн этгээд бичиг баримтыг хүлээн авсныг нотолсон гарын үсэг зуруулж, бичиг баримтыг хүлээн авсан огноог тэмдэглэн уг баримтыг Хүсэлт гаргасан байгууллагад илгээнэ. Хүсэлтэд дурдсан хаягаар бичиг гардуулан өгөх боломжгүй тохиолдолд уг этгээдийн хаягийг тогтоох арга хэмжээ авах ёстой. Харин хаяг нь тогтоогдохгүй тохиолдолд энэ талаар мэдэгдсэн бичгийг гардуулж өгөх ёстой баримт бичгийн хамт буцаан илгээнэ.
- **Хаяг болон бусад мэдээллийг тогтоох:** Гэрээ байгуулсан улсын хүсэлтээр өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа этгээдийн оршин суугаа хаяг болон бусад мэдээллийг тогтоож өгөх ажиллагаа явуулдаг. Бусад мэдээлэл гэдэгт эрхэлж буй ажил, гэр бүлийн байдал, оршин сууж буй газар, визийн ангилал гэхчилэн хүсэлт гаргасан улсын тухайлан тодруулж өгөхийг хүссэн мэдээллийг ойлХонго.
- **Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах:** Хүсэлт гаргагч талын хүсэлтийг Хүсэлт хүлээн авагч тал өөрийн орны хууль тогтоомжийн дагуу Хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн сэжигтэнтэй холбогдуулан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулж болно. Уг хэргийн сэжигтэн нь Хүсэлт хүлээн авсан орны иргэн ч байж болно. Уг ажиллагаа нь сэжигтэний овог, нэр, иргэний харьяалал болон тухайн этгээдийн үйлдэл, хэрэгт ач холбогдолтой бусад нөхцөл байдлыг тогтооход чиглэнэ. Түүнчлэн хохирогчоор тогтоох, хохирогчоос мэдүүлэг авах, учруулсан гэмт хор, хохиролын хэмжээг тодорхойлох зэрэг ажиллагааг хийнэ.
- **Гэмтэтгээдийг шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих:** Уг таслан сэргийлэх арга хэмжээг Хүсэлт хүлээн авагч улсын дотоодын хууль тогтоомжид заасан журмын дагуу гүйцэтгэнэ. Хэлэлцэн тохирогч талууд нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээндээ цагдан хорих зорилго, шилжүүлэх үүрэг, цагдан хорих, шилжүүлэхээс татгалзах үндэслэл, шилжүүлэхийг хойшлуулах талаар тодорхой заасан байхыг шаардана. Олон талт гэрээний дагуу хэдийгээр

аль нэг улсад шилжүүлэн өгөхгүй боловч түүний гадаад улсад үйлдсэн гэмт хэрэгт нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжоор эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгт холбогдуулан цагдан хорьж болно. Шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих хүсэлтийг хүлээн авсан орон уг хүсэлтийг биелүүлсэн даруйдаа энэ тухайгаа Хүсэлт гаргасан улсад мэдэгдэнэ. Даалгавар өгсөн орны шаардлагаас үүдэн шилжүүлэн өгөх тухай хүсэлт, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулах даалгавартайгаа заавал нэгтгэгдсэн байх албагүй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах үүндээс шуудан, телеграф болон факсаар цагдан хорих даалгаврыг мэдэгдэж болох ба энэ тохиолдолд урьдчилан мэдэгдсэн даалгаврын дугаарыг дурдаж, хожим нь уг этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг тусгасан даалгаврын эх хувийг хүргүүлэх ёстой. Хэрэв хүсэлтийн дагуу цагдан хорьсон боловч түүнийг нь биелүүлсэнээс хойш гэрээнд заасан хугацаанд /ихэнхдээ 1 сар байдаг/ уг этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт албан ёсоор ирүүлээгүй бол даалгаврын дагуу баривчлагдсан этгээдийг сулладаг ба гэхдээ Хүсэлт гаргагч талын хүсэлтээр цагдан хорих хугацааг сунгаж болдог байна. /ихэнхдээ 15 хоног байдаг/.

- **Нэгжлэг хийх, эд хөрөнгө хураах:** Мөрдөн байцаалтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд даалгавар хүлээн авсан улсын эрх бүхий байгууллагаас өөрийн орны хууль тогтоомжид заасан журмын дагуу энэ ажиллагааг явуулна. Хэрэв даалгавар өгөгч улс өөр улсаас бичиг браимт, дуу, дүрс бичлэг болон бусад нотлох баримтыг авах шаардлагатай бол энэ тухайгаа даалгаварт нэг бүрчлэн бичиж тэдгээрийн байгаа газар, шинж тэмдэг зэргийг нарийн тусган ирүүлэхийг шаардана.
- **Шинжилгээ хийх:** Даалгавар хүлээн авагч тал шинжилгээ хийхийн тулд өөрийн улсын холбогдох байгууллагаас зохих журмын дагуу зөвшөөрөл авсан байхыг шаардана. Шинжилгээ хийлгэхээр даалгавар өгөгч тал шинжээчид тавих асуулт болон өөрийг нь төлөөлөн шинжээч томилох эрхийг шилжүүлэн баримтыг ирүүлэх ёстой.
- **Эд мөрийн нотлох баримт шилжүүлэх:** Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, гэмт хэрэг үйлдсэний шан болгож эд зүйлийг хураан авах зорилгоор ийм эд зүйлсийг шилжүүлэн өгөх даалгавар үйлдэнэ. Эдгээр эд зүйлийг зөвхөн эрүүгийн хэргийг нотлоход ашиглах бол эрүүгийн хэргийг шийдвэрлэх хүртэл түр шилжүүлэн аваад хэргийг шийдвэрлэж дууссаны дараа нөгөө улсад буцааж хүлээлгэн өгч болно.
- **Гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдийг байцаах:** Бусад төрлийн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахтай нэгэн адил үндэслэл, журмыг баримтлан энэ ажиллагааг явуулна. Ингэхдээ эдгээр этгээдийг байцаалтад дуудах үндэслэл нь нөгөө улсаас ирүүлсэн даалгавар байдаг. Далагаварт байцаалгах хүсэлтэй этгээдийн овог нэр, хаяг, утас, холбоо дамжуулан тогтоож болох хүний тухай мэдээлэл зэргийг тусгасан байна. Хэлэлцэн тохирогч улсууд нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээндээ дээрхи этгээдүүдийг байцаах үеийн эрх зүйн хамгаалалт болон байцаалтын дагуу олж авсан мэдээллийн нууцыг хадгалах талаар тодорхой тусгасан байх

ёстой.

- **Эрх зүйн асуудлаар мэдээлэл солилцох:** Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд нь өөр хоорондоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, тэдгээрийг хэрэглэх практикийн талаар харилцан мэдээлэх үүрэгтэй.

Монгол улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээ байгуулсан орнууд

№	Улсын нэр	Гэрээний нэр	Гарын үсэг зурсан
1	Унгар Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Будапешт 1968-11-22
2	Болгар Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Софи 1968-11-27
3	Румынь Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Улаанбаатар 1972-11-25
4	Чех Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх болон эрхийн харилцаа тогтоох тухай	Улаанбаатар 1976-10-15
5	Словак Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх болон эрхзүйн харилцааны тухай	Улаанбаатар 1976-10-15
6	БНАСАУ	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Улаанбаатар 1988-10-29
7	Куба Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай	Улаанбаатар 1989-8-16
8	БНХАУ	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай	Улаанбаатар 1989-8-31 1997-8-19
9	Франц Улс	Иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, иргэний хэргийн талаарх шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Конвенци	Парис 1992-2-27

10	Казакстан Улс	Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэмт хэрэг үйлдэгсдийг эрүүгийн хэргийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэхэд тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай	Улаанбаатар 1993-10-22 1993-10-20
11	Польш Улс	Иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай	Варшав 1998-10-19
12	ОХУ	Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай	Улаанбаатар 1999-4-20
13	БНСУ	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Ялтан шилжүүлэх тухай гэрээ Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Улаанбаатар 1999-5-31 1999-5-31 2008-5-29 2008-10-15
14	Украйн Улс	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Киев 1995-6-27
15	Вьетнам Улс	Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Улаанбаатар 2000-4-17
16	Киргиз Улс	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Бишкек 1999-12-4
17	Турк Улс	Иргэн, аж ахуйн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	Улаанбаатар 2000-5-2
18	Энэтхэг Улс	Иргэн, аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай	Дели 2001-1-3
19	Канад Улс	Ялтан шилжүүлэн өгөх тухай	Улаанбаатар 2004-10-23

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүн аль ч нийгэм, ямар ч улс орон, дэлхийн хаана амьдарч байгаагаасаа үл хамааран БООЛЧЛОЛ-ыг хүлээн зөвшөөрч болохгүй. Энэ үйл ажиллагааны эсрэг тэмцэх хүсэлтэй байна гэдэг нь цаашид энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд маш их амжилт олохын эхлэл юм. Хохирогчийг хувь хүн гэдгээр нь авч үзэх чухал байдаг. Энэ гэмт хэрэгтэй хийж буй тэмцэл ихэнхдээ урагшлаагүй юм шиг байдаг боловч хэргийн шийдвэрлэлтээс харахад ахиц, дэвшил гарч байна. ХХГХ-тэй тэмцэхэд хохирогчийг дутуу үнэлэх явдал түгээмэл байдаг. Бид энэ гэмт хэргийг танин мэдэж, таслан зогсооход хохирогчийн оруулж байгаа хувь нэмрийг сайн тооцож үзэх хэрэгтэй байдаг.

Мэдээлэл авах

3.1. Утсаар мэдээлэл авах, холбоо тогтоох

ХХГХ-ийн талаарх мэдээллийг хохирогч болон түүний гэр бүлийнхэн, эсвэл найз нөхөд өгч болно. Утсаар эхэлж холбоо тогтоож байгаа хүн өндөр хариуцлагатай байх ёстой. Юуны өмнө тухайн туслалцаа хүсэгчийг хохирогч байх магадлалтай эсэх талаарх мэдээллийг эхэлж тодруулна. Үүнд:

Ерөнхий мэдээлэл

- Нас,
- хүйс,
- овог, нэр,
- регистрийн дугаар

Хохирогчийн одоогийн байгаа байршил, хаяг (гадаадад, дотоодод)

Хамгийн сүүлд хэзээ, хэнтэй холбогдсон,

- утасны дугаар,
- электрон шуудангийн хаяг
- бусад (хувь хүн, захидал г.м)

Аюулгүй байдал:

- Бичиг баримтыг нь хураасан эсэх
- Хохирогчтой холбоо барих боломж (утас, э-мэйл,)
- Хөдлөх эрх чөлөө нь хязгаарлагдсан эсэх (хянах, дагаж мөрдөх, хорьж, цагдах г.м)

Эрүүл мэнд:

- Бэртэл гэмтэл
- Хэрэв өвдсөн бол бусдын туслалцаагүй биеэ дааж авч явах боломжтой эсэх

Цагдаагийн шууд утас 102 (үнэ төлбөргүй)
Итгэлийн утас 1903 (энгийн утасны тарифаар)
Дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн утас:

- Баянгол дүүрэг 70140136
- Багануур дүүрэг 0121-102
- Баянзүрх дүүрэг 70150335
- Багахангай дүүрэг 0222-102
- Налайх дүүрэг 0123-102
- Хан-Уул дүүрэг 70130134
- Чингэлтэй дүүрэг 70121138
- Сүхбаатар дүүрэг 70120137
- Сонгинохайрхан дүүрэг 70170133

Аймгуудын цагдаагийн хэсгийн утас:

- Архангай 01332-102
- Баянөлгий 01422-102
- Баянхонгор 01442-102
- Булган 01342-102
- Говь-Алтай 01488-102
- Дорноговь 01522-102
- Дорнод 01582-102
- Дундговь 01592-102
- Завхан 01462-102
- Өвөрхангай 01322-102
- Өмнөговь 01532-102
- Сүхбаатар 01512-102
- Сэлэнгэ 01362-102
- Төв 01272-102
- Увс 01452-102
- Ховд 01432-102
- Хөвсгөл 01382-102
- Хэнтий 01562-102
- Дархан 01372-102
- Орхон, Эрдэнэт 01532
- Говьсүмбэр, Чойр 01542-102

3.2. Хохирогчид болон бусад хүмүүс гэмт хэргийг шууд мэдээлэх нь

Хохирогч болон түүний ар гэрийнхэн тохиолдсон нөхцөл байдлын талаар цагдаагийн газар хандаж шууд мэдээлж болно. Эсвэл хохирогчдыг хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа явуулдаг ТББ хандуулдаг.

Заримдаа хүн худалдах гэмт хэргийн хувьд, “үйлчлүүлэгч хохирогчийг аврах” тохиолдлууд гардаг. Цөөн тохиолдолд үйлчлүүлэгч биш ч гэсэн сайн санаат хүмүүс хохирогчийг аварч цагдаагийн газарт хүргэж өгдөг.

Дээрх мэдээллийг хүлээн авсныхаа дараа шалгаж, тодруулах асуудлууд:

1. Аюулгүй байдлын асуудал: Хохирогчийн талаарх мэдүүлгээс харагдана. Ялангуяа бага насны хүүхдэд, хуулийн байгууллагатай урд өмнө нь асуудалтай байсан хүмүүст илүү их аюул үүсгэдэг.
2. Ихэнх тохиолдолд ТББ гэмт хэргийг илрүүлж гаргадаг. Хохирогчийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй ТББ-ын хүмүүстэй илүү сайн хамтран ажиллах шаардлагатай.
3. Хохирогчийн өмгөөлөгчид тухайн гэмт хэргийн талаар бүх мэдээллийг бүрэн хүргэх хэрэгтэй. Жнь: хуулийн байгууллагад мэдүүлэг өгөх тохиолдолд хохирогч сайн дураараа ярилцах нөхцөл бүрдсэн үед л ярилцлагыг авахаар зохицуулах г.м
4. ТББ нь хохирогчийг хуулийн байгууллагатай ажиллахад бэлтгэх үүрэгтэй. Хуулийн байгууллагын оролцоо ороод ирэхээр хохирогчид хүндрэлтэй болж ирдэг.
5. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, яаралтай тусламж үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл гэмтлийн зэргийг тогтоолгох

3.3. Төмөр замын цагдаагийн ажилтны үүрэг

Монгол улсад бүртгэгдсэн ХХГХ-ийн тохиолдлуудаас харахад олонх нь төмөр замаар дамжин эх орноосоо явсан байдаг. Хүн худалдах гэмт хэргийн зарим мэдэгдэж байгаа тохиолдлуудаас харахад хохирогчид нь Замын-Үүдийн хилийн боомтоор дамжин БНХАУ руу галт тэргээр зорчдог нь тодорхой байдаг. Нэгэн хохирогч галт тэргэнд утасны үйлчилгээний мэдээллийг аваад ХТЭТ-ийн итгэлийн утсанд хандсанаар бусад хохирогчдын хамт аварч аюулгүй буцаж ирсэн бөгөөд гэмт хэрэгтэнг хуулийн байгууллагаар шийтгүүлсэн.

Тиймээс галт тэргээр зорчин явагсдыг шалгах явцад эрсдэлтэй буюу сэжигтэй тохиолдлууд болон ялангуяа насанд хүрээгүй хүүхдийн бүртгэлийг хийх нь чухал ач холбогдолтой. Бүртгэхдээ 16-с доош насны хүүхдийг асран хамгаалагчтай нь, харин 16-аас дээш насны хүүхдүүдийг цагдаагийн ажилтан ярилцах явцдаа сэжигтэй гэж үзвэл илүү нарийвчилж бүртгэнэ.

Галт тэргээр зорчиж буй хүүхдийн бүртгэлийг хийснээр мэдээллийн бааз үүсч, сураггүй алга болсон хүүхдийг аль чиглэлд, хэзээ, хэнтэй цуг явж байсныг олж тогтооход чухал үр дүнтэй. Ялангуяа хүүхдийг дагуулан явж байгаа насанд хүрэгчдийг бүртгэснээр гэмт хэрэгтнүүдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэхэд түлхэц болно. Галт тэргээр зорчих аяллын хугацаанд доорхи хүснэгтийг бүрэн гүйцэд бөглөж, хүүхдийн байцаагчдаа өгснөөр тусгай програмд орж шивэгдэх боломжтой болно.

Насанд хүрээгүй зорчигчийн бүртгэлийн хуудас

1. Хүүхдийн талаарх мэдээлэл

Овог: _____ Нэр _____
 Хүйс: Эр ____ Эм ____
 Төрсөн: _____ он _____ сар _____ өдөр
 Регистрийн дугаар: _____
 Гэрийн хаяг: _____
 Ямар зорилгоор, аль чиглэлд явж буй _____
 Хүүхдийн содон шинж тэмдэг: _____

2. Хамт яваа хүний талаарх мэдээлэл

Овог: _____ Нэр _____
 Хүйс: Эр ____ Эм ____
 Төрсөн: _____ он _____ сар _____ өдөр
 Регистрийн дугаар: _____
 Гэрийн хаяг: _____
 Ямар зорилгоор, аль чиглэлд явж буй _____
 Хүүхдийн содон шинж тэмдэг: _____

Бүртгэсэн: он..... сар.....өдөр

Бүртгэсэн хүний нэр: цол

Төмөр замын цагдаа, ажилтнуудын хувьд өөрсдийн хийж буй шалгалтын явцад болон иргэдийн мэдээллээр болзошгүй хүн худалдах гэмт хэрэгтэн, хохирогчдыг галт тэргээр зорчих явцад танин илрүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох цагдаагийн байгууллагад шилжүүлэн өгөх үүрэгтэй.

3.4. Анхан шатанд хуулийн байгууллагын үүрэг

- Мэдээлэл хүлээн авсан даруйдаа хохирогчийн аюулгүй байдлыг хангах нь нэн чухал байдаг. Гэмт хэрэгтнүүдийн байр, гэрт нэгжлэг хийхэд шалан доороо тусгай өрөөнд нуух, хүний санаанд орохооргүй газар мөнгөө нуух г.м олон аргыг хэрэглэдэг учраас энэ бүхэнд мэдээллийг маш сайн үнэлж, гярхай байх шаардлагатай.
- Хохирогчоос цаг хугацаа шахаж, тулган шаардах хэрэггүй. Гэхдээ зайлшгүй шаардлагатай, яаралтай асуудлаа мэдэгдэж шийдвэрлэх, хойшлуулшгүй арга хэмжээг авах

- Хохирогчийн айдсыг сайн тооцоолох хэрэгтэй. Учир нь тэд хууль зөрчсөн, цагаачлалын, биеэ үнэлсэн г.м айдастай байдаг.
- Мэдээллийг үнэн зөв өгснөөр тэнд байгаа олон хохирогчдыг аврах боломж бүрдэнэ гэдгийг сайтар ойлгуулах
- Дээрх үйл ажиллагааг явуулахдаа өөрийнх нь аюулгүй байдлыг хангах, мэдээлэл өгсөн талаар нууцлах зэргийг мэдэгдэх
- Хохирогчтой гэмт хэрэгтнүүдийн орогнож буй байр, гэрт нэгжлэг хийх зэрэг асуудал дээр мэдээлэл авч ойр ажиллах, (хаана гэмт хэргээ үйлддэг, хэрхэн үйлддэг, хохирогчдыг хаана байрлуулдаг, хэрхэн аюулгүй байдлыг хангаж аварч болох талаар)
- Гэрчийн этгээдүүдийн мэдээллийн нууц, аюулгүй байдлыг сайн хангаж ажиллах шаардлагатай.

3.5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид мэдээлэл өгөх:

- Хохирогч Үндсэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдэлнэ.
- Хохирогч хэдийгээр цагаачлалын хуулийг зөрчсөн ч хүний эрх нь зөрчигдөх ёсгүй гэдгийг дээд зэргээр ойлгуулах
- ХХГХ-ийн хохирогчид цагдаа, цагаачлалын байгууллагад хандвал үүнээс дор нөхцөл байдалд орж болно гэж ойлгуулсан байдаг. Тиймээс түүний эсрэг хуулиа сайн сурталчилж ойлгуулах хэрэгтэй.
- Хохирогчид хуурамч амлалт өгч болохгүй. Хэдийгээр цаасаар өгсөн ч бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжих боломжтой нь их чухал.
- Буруу мэдээлэл өгөх, түгээх зэргээс шалтгаалж хохирогчид тусгаарлагдах, эвгүй байдалд орох зэрэг асуудал үүсдэг.
- Гэмт хэргийг шийдвэрлэх явцад гэмт хэрэгтнүүдийг барьцаагаар, батлан даалтаар гаргадаг. Ийм нөхцөлд хохирогчид айдаст автагддаг. Харин тэр үед хохирогчийг маш сайн хамгаалах ёстой.
- Шүүх хурал дээр хохирогч өөрийгөө хэрхэн илэрхийлж байгаагаар шүүгчид хүлээн авдаг. Шүүгч энэ гэмт хэрэгтэй олон мэдээлэл уншиж, сонсдог боловч хохирогч өөрийн үгээрээ өөрийн хохирлоо тайлбарлаж, илэрхийлбэл илүү бодитой байдгийг сайн тайлбарлаж өгөх.
- Хохирогч ТББ-тай хамтран ажиллаж шүүх хуралд бэлтгэх хэрэгтэй. Хохирогч мэдүүлгээ өгөх нь бүх үйл ажиллагааны эцсийн зангилаа байдаг.
- Хохирогч мэдүүлгээрээ өөртөө тохиолдсон явдлыг бодитой, үр дүнтэйгээр ойлгуулсны үндсэн дээр зөв шийдвэр гарна. Ялангуяа хохирол, айдас, бодит аюул, заналхийлэл, доромжлол г.м

Алдаатай асуултууд:

ХХГХ-ийн шийдвэрлэлтийн талаар 2002-2008 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 17 хэргийн хавтаст хэрэгтэй танилцаад хийсэн судалгааны тайланд мөрдөн байцаалт, шүүх хурлын явцад асуулт тавихдаа гаргаж байсан нийтлэг алдаануудыг дурдсан байна.

- “Та нар явахдаа биеэ үнэлнэ гэж мэдэж байсан юм биш үү?”
- Ямар шалтгаанаар эргэж явсан бэ?
- Та өөрөө зөвшөөрсөн гэдэг чинь биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан юм биш үү?
- “Та урьд нь мэдүүлэхдээ үхлээ хатлаа гээд байсан яасан?”
- “Та өөрөө зөвшөөрөөд яваад байсан байна, таныг яг зодсон уу?”
- Хүч хэрэглэсэн үү? Тийм юм бол зугтаад хүрээд ирэхгүй яасан юм бэ? гэхчилэн асуусан нь хуульчийн ёс зүй, хохирогчийн эрхийг зөрчсөн байна .

3.6. Хохирогчийг хилээр гарахаас өмнө авч болох арга хэмжээ буюу туслалцаа үзүүлэх, аюулгүй байдлыг хангах

Цагдаагийн байгууллагын ажилтнууд мэдээлэл авсан даруйдаа хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудтай холбогдон нягт хамтран ажиллах шаардлага гардаг. Улсын хилээр гарах явцад хүн худалдах гэмт хэрэгтэн болон хохирогчдыг тогтоох боломжтой бөгөөд хилийн хяналтын ажилтан нь энэхүү гэмт хэргийг илрүүлэх болон холбогдох арга хэмжээг авах эрхтэй.

Харин хилийн чанадад явж буй эрсдэлтэй хүмүүсийн хувьд, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтан энэхүү аяллыг хийхгүй байхыг зөвлөн мэдээллээр хангаж, эрсдэлд орж, аливаа мөлжлөгт өртөж болзошгүй талаар сануулан мэдээлэл өгнө.

Хохирогч эх орондоо эргэн ирж байгаа тохиолдолд хилийн шалгагч шаардлагатай байгууллагатай холбон тусламж үзүүлж тухайн хэргийг мэдээлнэ. Тухайлбал: Эрүүгийн цагдаагийн газар, УМБГ, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-1903, 311512,

3.7. Хохирогчийг аврах үйл ажиллагаа

3.7.1. Аврахын өмнө

Мэдээ баримт цуглуулах нь хүний наймааны хэргийг мөрдөж эхлэх маш чухал эхлэл юм.

- ⇒ Аврахын өмнөх мэдээ баримтыг хувь хүн (хохирогч, түүний ар гэрийнхэн, бусад) болон байгууллагын эх үүсвэрээс (ТББ, нийгмийн ажилтан, болон тухайн орон нутгийн нэгжүүд г.м) болон цагдаагийн хийсэн дүн шинжилгээнээс
- ⇒ Цагдаад мөн нэрээ нууцалсан эх сурвалж утсаар болон захиагаар өгсөн мэдээллээс
- ⇒ Хүний наймааны хэргийн зохион байгуулалттай, далд нууцлагдмал байдлаас болж олон тооны гэмт хэрэгтнүүд орооцолддог тул нэгнийх нь талаар мэдээ баримт нөгөө хүний мэдээ баримт руу аваачиж байдаг.
- ⇒ Мэдээллийн үнэн мөнийг шалгах ажиллагаа эхлэхээс өмнө олж авсан мэдээллээ дахин нэгд нэгэнгүй нягтлах хэрэгтэй.
- ⇒ Хохирогчдыг мэдээллийн эх үүсвэр болгон ашиглахдаа түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр мэдээлэл авах
- ⇒ Мөн хуурамч ажиллагаа зохион байгуулагдах боломжтой. Ямар ч байсан энэ нь аврах ажиллагаа учраас үүнийг урьдчилан бэлтгэл ажил хийсний үндсэн дээр явуулах ёстой.
- ⇒ Мэдээллийн эх үүсвэрийн талаарх нууцлалыг ямар ч үнээр хамаагүй хадгална гэдгийг баттай болго.

3.6.2. Аврах ажиллагаа

Аврах ажиллагааг ямар ч шалтгаанаар хойшлуулах болон хүлээлгэж болохгүй. ХХГХ-тэй холбоотой анхны мэдээллийг авмагцаа аврах ажиллагааг ЦАГ АЛДАЛГҮЙ эхлүүлэх ёстой.

- ⇒ Мэдээллийн эх үүсвэрүүд, нэмэлт эх үүсвэр олох боломж
- ⇒ Шаардлагатай хууль эрх зүйн болон захиргааны зөвшөөрлүүд, хэнээс авах
- ⇒ Ажиллагаанд оролцох зүйлс:
 - хэн хэн ямар үүрэгтэй оролцох
 - Хэзээ болох
 - Хаана (байршил, ойр орчмын хар зураг,)
 - Шаардлагатай техник хэрэгсэл, бусад зүйлс г. м
- ⇒ Ажиллагааны явцад гарч ирж болзошгүй бэрхшээлүүд болон учирч болох аюулууд
- ⇒ Урьдчилан хийсэн Б төлөвлөгөө (ө/х. Аварсан хохирогчдыг хаана байрлуулах, яаралтай эмнэлгийн тусламжийг хэрхэн авах г.м)
- ⇒ Нууцлалыг хадгалах

3.7.3. Аврах ажиллагааны явцад

- Аврах ажиллагааг хойшлуулж болохгүй.
- Нэгжлэг хийх/аврах багт дор хаяж 1-2 эмэгтэй цагдаа байх ёстой.
- Эмэгтэй цагдаагийн ажилтан дутагдалтай бол тэтгэвэрт гарсан эмэгтэй цагдаа нарыг ажиллагаанд оролцуулж болно.
- Нэгжих болон аврах ажиллагаанд ТББ-уудыг мөн оролцуулж болно.
- Хоёр нэмэлт хүнийг гэрчийн журмаар байлцуулна.
- Аврагдсан хохирогчийг байцаахад эмэгтэй цагдаагийн ажилтан юм уу ТББ-ын эмэгтэй ажилтанг байлцуулна.
- Гэмт хэрэгтэн болон сэжигтэнгүүдээс аврагдсан хүмүүсийг тусгаарлах ёстой. Аврагдсан хүмүүсийн эрхийг цаг ямагт хамгаалж байх ёстой.
- Цагдаагийн ажилтнууд аврах ажиллагаанаас өмнө хохирогчийг хамгаалах байр хаана байдгийг мэдсэн байх ёстой. Хамгаалах байр нь хэдэн хүний багтаамжтай болон түүний талаар бусад мэдээллийг авсан байх ёстой.
- Нотлох баримтуудыг устгах болон гадагш алдахаас сэргийлж, найдвартай газар хадгална.
- Цагдаагийн бүх ажилтнууд бүх ажиллагааны туршид хуулийг дагаж мөрдөн хариуцлагаа ухамсарлана.

Аврагдсан хүмүүсийн эрхэнд дараах зүйлс орно:

- Аврагдсан хүмүүс тухайн газраас өөрийн гэсэн бүх зүйлээ, хэрэв хүүхэдтэй бол хүүхдээ авч явах ёстой. Хүүхдүүдийг авалгүй орхих явдалд анхаарал тавьж баттай болгож байна.
- Ил тод мэдээлэх явдлаас зайлсхийх ёстой.
- Хохирогчийн насыг магадлан тогтоолгох ажилтанг тусгайлан ажиллуулах хэрэгтэй.
- Сэтгэлийн цочролд зөвлөгөө өгөх мэргэжлийн хүнийг байлгах хэрэгтэй.
- Тайвшруулж, хуулийн зөвлөгөө өгөх хүн байх ёстой.
- Яаралтай эмнэлгийн тусламжийг хохирогчид үзүүлэх ёстой. (хохирогчийн нас, бэртэл гэмтэл, бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн замын халдварт өвчнүүдийг тогтоолгох эмнэлгийн шинжилгээнүүд хийгдэх ёстой)

3.7.4. Аварсны дараа

Цагдаагийн ажилтны гүйцэтгэх үүрэг нь аврах ажиллагааны дараа үнэхээр чухал болж ирнэ. Яагаад гэвэл энэ шатнаас эхлээд аврагдагч болон цагдаа хоёрын хооронд үүсэх харилцааны анхны алхмууд хийгдэж эхэлнэ. Тийм болохоор аврах ажиллагааны дараах үед хүний наймааны хохирогчид хандах цагдаагийн ажилтны анхны хариу үйлдэл маш их үр дагавруудыг авчирдаг. Учир нь гэмт хэрэгтнүүд хохирогчдыг цагдаагийн нэр барин айлган сүрдүүлэх, дарамтлах явдал их байдгаас айдас улам бүр нэмэгддэг.

- Хохирогчийн өгсөн мэдээлэл дээр үндэслэн бүх гэмт хэрэгтнүүдийн талаар тэмдэглэж авна. Ингэснээр гэмт хэрэгтнүүдийн холбоо сүлбээ болон үүргийг тодорхой мэдэж авсны үндсэн дээр баривчилгааг эхлүүлнэ.
- Хүний наймааны гэмт хэргийг тухайн хэрэг бүртгэгдсэн хуулийн заалтын дагуу баримтжуулна.

Аварсаны дараах үе шатанд хохирогчийг давтан хүний наймаанд өртүүлэхгүй байх, тэднийг дахин сэтгэлийн цочролд оруулахгүй байх үүднээс ТББ-ын болон цагдаагийн газрын хамтын ажиллагаа илүү их шаардагддаг. Хохирогч нь нийгмийн дарамт шахалт болон тэднийг дахин хүний наймаанд татан оруулах гэж хамаг авъяасаа шавхах хүний наймаачдын оролдлогоос болж маш эмзэг болсон байдаг.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээллийг авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх шуурхай арга хэмжээ авна.

Цагдаагийн байгууллагын тухай хууль, 10-р бүлэг

3.7.5. Мөрдөн байцаалт

Мөрдөн байцаах ажиллагааны зорилго нь хохирогчийн мэдүүлгээр гэмт хэрэгтэн болон хүний наймаачдыг олж тогтоон тэдний эсрэг бүрдүүлж байгаа нотлох баримтуудыг баримтжуулан хуулийн дагуу дараагийн алхмуудыг хэрэгжүүлэх явдал юм. Аврагдсан хүмүүсээс цагдаагийн ажилтан ярилцлага авахдаа тэдний талаар мэдээлэл авах болон гэмт хэрэгтнүүдийн талаар мэдээлэл авах зорилго тавина. Ярилцлагыг эмэгтэй цагдаагийн ажилтнаар авахуулах боломжтой бол ТББ-ын эмэгтэй ажилтныг байлцуулна. Хохирогчтой хүндэтгэлтэй эелдэг хандахгүйгээр тэднийг мөрдөн байцаах ажиллагаанд туслахыг шаардах нь эсрэг үр дүнг л авчрах болно.

а. Эхний байцаалтаар хохирогчдоос тодруулах асуултууд:

Хохирогчдын амссан хохирлыг түүнтэй адилаар ойлгох нь чухал. Байцаах ажиллагааг эхлэхэд хохирогчийн эмнэлгийн болон сэтгэл санааны байдлын хэрэгцээг түрүүлж олж мэдэх нь чухал байдаг. Хохирогчийн “нүүрийг хагалах”, тэдний сэтгэлийн шархыг эдгээхэд ТББ-ын ажилтан болон бэлтгэгдсэн зөвлөх нарын үүрэг маш их байдаг бөгөөд энэ нь цагдаа нарын ярилцлага авах ажлыг хөнгөвчилж өгдөг. Анхны ярилцлагаар доорхи найман бүлэг асуултыг санал болгож байна. Үүнд:

1. Өмнөх нөхцөл байдал, зорилгын талаар: Амьдарлын түүхийг болон ХХГХ-т хэрхэн элсүүлэгдсэн, тээвэрлэгдсэн тухайн газраа хэрхэн очсон талаар
2. Ажлын нөхцөл байдлын талаар: Очоод энд өгсөн мэдээлэлтэй тохирсон эсэх, ямар нөхцөлд, ямар ажил хийлгэдэг байсан, албадлага, дарамт, мөлжлөгийг

тодруулах

3. Амьдралын нөхцлийн талаар: Хөдлөх эрх чөлөө, хянах цагдах болон аюулгүй байдал, амьдарч байсан нөхцөл, өрийн тухай,
4. Хүнд нөхцөл байдлаас хэрхэн гарч ирсэн (хэрвээ өөрөө оргон зугтаж чадсан бол), одоо ямар тусламж хэрэгтэй байгаа талаар: Эр зоригийг үнэлэн урам өгөх,
5. Заналхийлэл, сүрдүүлэг болон дарамтын талаар: Биед нь үүссэн шарх сорви,
6. Бусад хүмүүс түүний нөхцөл байдлын талаар ямар бодолтой байгааг
7. Ирээдүйн төлөвлөгөө, хүсэн хүлээж байгаа зүйл нь юу болох, ямар тусламж үйлчилгээ хэрэггүй болох талаар Яагаад гэж үзэж байгаа талаар
8. Эрсдлийн үнэлгээ: Ойрын, удаан хугацааны эрсдэл болон хэрэгцээ, эдгээрийг хэрхэн даван туулах талаар

б. ХХГХ-ийн хохирогчийн онцлог, анхаарах асуудлууд

- ⇒ ХХГХ-ийн ихэнх хохирогчид өөрсдийгөө юу руу явж байгаагаа мөлжлөгт хүчээр өртөх хүртлээ ихэнхдээ мэддэггүй.
- ⇒ Эмзэг, эрсдэлтэй байдалд байгаа ХХГХ-ийн хохирогчдын зан үйлийн хэв шинж нь хохирогчийн амссан дарамт шахалтыг огт ойлгодоггүй хүмүүст маш амархан буруу ойлголт төрүүлдэг. Жнь: Тэд өөрийгөө хамгаалахын тулд бүдүүлэг үг, хэллэг, хараал хэрэглэх г.м байдлыг гаргадаг. Харин “энэ хүүхнүүд үнэхээр эвдэрчихэж, тэд хэзээ ч өөрчлөгдөхгүй дээ”, “энэ охидууд хэвийн амьдрах хөг нь өнгөрсөн, бусад сайн охидуудыг эвдэх болно” гэх мэтээр ойлгож сөргөөр ойлгохгүй байх хэрэгтэй.
- ⇒ Хохирогчид өөрсдийгөө таагүй байдалд орсныг мэдээд эсэргүүцэх гэж оролдох боловч хүчинд автан нөхцөл байдлыг хүлээж авахаас өөр аргагүй болдог. Тэд хүсээгүй шинэ нэр, гадаад дүр төрх, ажлыг хүчээр хүлээж авахдаа ёс бус харилцаа, дарангуйлал, өрийн дарамтыг биеэр амсдаг.
- ⇒ Эцэст нь тэд чөтгөрийн тойрогт орж, нөхцөл байдалд бууж өгч дуусдаг. Хохирогчийн амсаж эхэлсэн энэ олон цочролууд дуусашгүй юм шиг л санагддаг. Хохирогчийн туулж амссан эсэргүүцэл, няцаалт, урвалт, болон мэдээ алдалтуудыг хүн биеэр амсахаас нааш ойлгохын аргагүй юм.
- ⇒ Мөн хохирогчдыг эсэргүүцлээ болихгүй бол хүчээр хар тамхи, архинд оруулж хамгаалалтгүй бэлгийн харьцаанд оруулдгаас жирэмслэх, ХДХВ/ДОХ зэрэг бэлгийн замын халдварт өвчлөлүүдэд өртөмтгий болдог.
- ⇒ Хохирогч амьд үлдэхийн тулд өөрийгөө хамгаалах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай болдог бөгөөд үүнд гэмт хэрэгтэнтэй адил болохын тулд түрэмгий зан авир гаргах, тэр ч бүү хэл өөрсдийнхөө хүчирхийлэгч нарыг хамгаалах юм уу эсвэл өөрсдөө “мөлжигчид” болох ингэснээр тасралтгүй үргэлжлэх тойрогт ордог байна.
- ⇒ ХХГХ-ийн сэтгэц-нийгмийн нөлөөлөл маш гүн бөгөөд БИЕЭ ҮНЭЛЭГЧ буюу нийгмийн шившиг болсон гэсэн төсөөлөл, гэмт хэрэгтнүүдийн дарамт зэрэг нь хохирогчийг амсаж байгаа зовлон зүдгүүрийнхээ өмнө өөрсдөө буруутай гэж итгэхэд хүргэдэг.
- ⇒ Хууран мэхлэлт болон гэмт хэргийн тасралтгүй үргэлжлэх тойрог нь хүний

наймааны хохирогчид үл итгэхийн гүн гүнзгий мэдрэмж, байнга өөрийгөө хамгаалах сэтгэхүйг суулгаж өгдөг тул бүхнийг айдас, цочролтой хүлээж авдаг.

ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйн доорхи хэм хэмжээг дагаж мөрдөнө.

- 2.1. Цагдаагийн алба хаагч нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хуулийг дээдэлж, шударгаар ажиллана.
- 2.2. Цагдаагийн алба хаагч нь албаны нэр төрийг цэвэр ариун байлгаж, түүний хөгжил бэхжилтэд бодитой хувь нэмэр оруулж ажиллана.
- 2.3. Цагдаагийн алба хаагч нь мэдлэг, боловсрол, сахилга хариуцлага, зан байдлаараа иргэд олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээж ажиллана.
- 2.4. Цагдаагийн алба хаагч нь үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний болон албаны нууцыг чанд хадгалж хууль ёсны шийдвэр гараагүй байгаа хэрэг, маргааны тухай өөрийн санал бодлыг урьдчилан илэрхийлэх, олон нийтэд мэдээлэх, амлалт өгөхийг хориглоно.
- 2.5. Алба хаагч нь цагдаагийн байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагын зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, дээд байгууллага, албан тушаалтнаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлэхээс гадна нөхдийнхөө албаны ажилд хүндэтгэлтэй хандан тэдний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байна.
- 2.6. Цагдаагийн алба хаагч нь албан тушаал, хуулиар олгосон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглах, албан үүргээ биелүүлсэнтэй холбогдуулан шан харамж бэлэг сэлт бусдаас авах, шахаж шаардах, ятгах, зуучлах, хуульд харш болзол тавих, албаны нэрээр түрүү барих, далайлган сүрдүүлэхийг цээрлэнэ.
- 2.7. Цагдаагийн алба хаагч нь хүнд суртал гаргах, иргэдийг чирэгдүүлэх, хүнлэг бус харьцах, эрх чөлөө, эд хөрөнгөд нь хууль бусаар халдах, танил тал харах, бусдын нөлөөнд автах, хувийн сонирхлоор болон харъяаллын бус хэрэг, маргаанд оролцохыг хориглоно.
- 2.8. Цагдаагийн алба хаагч нь боловсрол, мэргэжил, ажлын ур чадвараа байнга дээшлүүлж зан төлвийн муу зуршил, дутагдал гаргахгүй байна.
- 2.9. Цагдаагийн алба хаагч нь гэр бүл, үр хүүхдэдээ халамж анхааралтай байж, ёс суртахууны нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөхийг өөрийн журамт үүргээ гэж үзнэ.
- 2.10. Цагдаагийн алба хаагч нь байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, эд зүйлс, албан хэрэгцээний мэдээ, материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахыг цээрлэнэ.
- 2.11. Цагдаагийн алба хаагчид: дүрэмт хувцастай, ажлын цагаар, ажлын байранд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.

Цагдаагийн байгууллагын тухай хууль

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХХГХ-ийн олон тохиолдлууд хил дамжин үйлдэгддэг. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн аргуудын нэгт хохирогчийг хил дээрээс илрүүлэн аврах явдал байдаг. Тухайн эрсдэлд өртсөн хүн нь ганцаараа байх хамгийн боломжийн хугацаандаа хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтантай уулзаж, мөн тэдний дунд насанд хүрээгүй хүүхдүүд өртөх өндөр эрсдэлтэйд тооцогддог. Тиймээс хүүхдийг хилээр заавал асран хамгаалагчтай нь хамт нэвтрүүлэх үүрэгтэй.

Хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэмдэглэл үйлдэх зорилгоор гурван цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, зөрчил гаргасан этгээдийн баримт бичгийг шалгах, түүний өмчлөлд буюу эзэмшилд байгаа эд зүйл, биед үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг түр хугацаагаар хураан авах, битүүмжлэх, согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, шаардлагатай тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах, гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох, түр саатуулагдсан этгээдийн эд зүйл, биед үзлэг хийсэн, эд зүйл, баримт бичгийг хураан авсан тохиолдол бүрд хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэх эрхтэй³⁶.

7 дугаар зүйл. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах

1. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахдаа зөвхөн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт явна.
2. Монгол Улсын 16-18 насны иргэн эцэг, эх, асран хамгаалагчийн хамт цагаачлах тохиолдолд түүний зөвшөөрлийг нь бичгээр авна.

Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиас

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд үндэсний гадаад паспорт олгоно. Харин насанд хүрээгүй хүн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд дор дурдсан баримт бичгийн аль нэгийг олгоно:

³⁶ Монгол улсын хилийн тухай хууль,

1. үндэсний гадаад паспорт;
2. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн үндэсний гадаад паспортад зургийг нааж баталгаажуулах;
3. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортад хавсаргагдах үнэмлэх;
4. гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд гадаадад зорчиход нь үндэсний гадаад паспорт;³⁷
5. гэрлэлтээ бүртгүүлсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн хоёрын дундаас гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхэд Монгол Улсад ирсний дараа гадаадад зорчих бол иргэний бүртгэлийн байгууллагаас олгогдсон хүүхдийн гэрчилгээ, регистрийн /бүртгэлийн/ дугаарыг үндэслэн түүнд энэ хэсэгт заасан баримт бичгийн аль нэгийг олгоно.

4.1. Хилийн зөрчил, хүн худалдаалах гэмт хэргийн хоорондын хамаарал

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам зөрчсөн үйлдлийг хилийн зөрчилд тооцно.

Улсын хил нэвтрэх журмыг дараахь үйлдлээр зөрчиж, хилийн боомтоос өөр газраар улсын хилийг газар, ус, агаараар нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан; хилийн боомтоор улсын хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичигтэйгээр нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан; улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн³⁸ этгээдийг хил зөрчигч гэнэ.

ХХГХ-ийн хохирогчдыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, бусдын бичиг баримтыг хуурамчаар ашиглах тохиолдол гардаг. Гэвч тухайн тохиолдолд хохирогч гэмт хэрэгтэн болж, харин жинхэнэ гэмт хэрэгтнүүд хариуцлага хүлээхгүй үлдэх явдал байсаар байна. Тиймээс хилийн зөрчлийн асуудал дээр холбогдох хууль, хяналтын байгууллагуудтай хамтран нарийвчлан ажиллах шаардлагатай.

Манай улсын хувьд хилийн хянан шалгах ажилтнууд нь хилээр гарч байгаа хүмүүсийн аялал аюултай байх болон мөн хүн худалдах гэмт хэргийн шинж тэмдэгтэй байна гэх мэтээр хүмүүст итгүүлэн үнэмшүүлж чадсан олон амжилттай жишээнүүд байна. Мөн түүнчлэн зарим улсад хилийн хяналтын ажилтнууд хохирогчдыг улс орондоо буцан ирэхэд танин илрүүлж, Цагдаагийн байгууллага болон ТББ-уудад тусламж өгөхөөр хандуулсан байдаг.

4.2. Хил хамгаалах байгууллагын зааврууд³⁹

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч ялангуяа хилийн чанад энэ төрлийн гэмт

³⁷ Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиас, 8 дугаар зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад олгох баримт бичиг, үндэсний гадаад паспорт

³⁸ Монгол улсын хилийн тухай хууль, 22 дугаар зүйл. Хилийн зөрчил, хил зөрчсөнд тооцох

³⁹ Замын-Үүдийн Шалган нэвтрүүлэх боомт, Штабын дарга, дэд хурандаа Ц.Батбаатарын судалгааны ажил

хэргийн хохирогч болсон этгээдийг илрүүлэх, таслан зогсооход хил хамгаалах байгууллагын үүрэг чухал юм. Иймээс хил хамгаалах байгууллагын хилийн шалган нэвтрүүлэх албан ажилтан дараах асуудлыг анхааралдаа авч ажиллах хэрэгтэй. Тухайлбал:

1. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэхэд хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтны гүйцэтгэх үүрэг.

- 1.1. Улсын хилээр нэвтрэх зорчигчийн биеэ авч яваа байдалд хяналт тавих, сэжиг бүхий иргэд болон дагалдан яваа хүүхэд, охид эмэгтэйчүүдийн баримт бичигт нарийвчилсан шалгалт хийх;
- 1.2. Насанд хүрээгүй хүүхэд, бага насны охид эмэгтэйчүүдийг дагуулан яваа хүмүүс нь хууль ёсны асран хамгалагч, харгалзан дэмжигч мөн эсэхийг тодруулах;
- 1.3. Насанд хүрээгүй хүүхдийг бусад этгээд дагуулан яваа тохиолдолд төрсөн эцэг, эхээс нь гаргуулан авсан нотриатоор гэрчлүүлсэн итгэмжлэхийг шалгах;
- 1.4. Улсын хил нэвтрэхээр насанд хүрээгүй хүүхэд, олон тооны охид, эмэгтэйчүүд ирсэн тохиолдолд аялалын албан ёсны зорилго болон хөрөнгийн эх үүсгэвэртэй эсэхийг нь гаалийн байгууллагатай хамтран тодруулах;

2. Хүн худалдах гэмт хэргийн шинж тэмдгийг таниж мэдэх, харилцан ажиллах;

- 2.1. Улсын хил нэвтрэхээр 2 ба түүнээс дээш хүүхэд, охид эмэгтэйчүүдийг дагуулан яваа этгээд болон дагалдан яваа хүмүүсийн биеэ авч яваа байдал, хувцаслалт, маршрут, баучер болон аялалын зорилгод тохирсон хөрөнгийн эх үүсвэртэй эсэх нь нотлогдож байгааг нягтлах;
- 2.2. Хятад, Малайз, Тайланд, Макао, Гонконг, Сингапур болон бусад гадаадын орнуудад хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нараас нь бусад этгээд хүүхэд, охид эмэгтэйчүүдийг дагуулан яваа тохиолдолд баримт бичигт нарийвчилсан шалгалт хийх, хүн нэг бүртэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулах;
- 2.3. Сэжиг бүхий иргэдэд цагдаа, тагнуулын байгууллагатай хамтарсан шалгалт хийж, зохион байгуулалттай гэмт хэргийн шинж байгаа эсэхийг торуулах, хилийн боомт газарт саатуулан шалгах;
- 2.4. Улсын хилээр охид, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдах, бэлгийн мөлжлөгийн замаар ашиглах үндэслэл байгаа тохиолдолд хууль хяналтын болон төрийн бус байгууллагуудад нэн даруй мэдэгдэх, харилцан ажиллах;
- 2.5. Охид, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдах, бэлгийн мөлжлөгийн замаар ашиглах төрлийн гэмт хэргийн шинж илэрсэн тохиолдолд зохион байгуулагч этгээдээс нэн даруй тусгаарлах, хоорондын харьцаа үүсгэхгүй байх;
- 2.6. Хохирогч нартай нэг бүрчлэн ярилцлага хийж, бодит байдлыг тогтоон ухамсарлан ойлгуулах, гэмт хэргийн хохирогч болохоос нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль хяналтын байгууллагуудтай хамтран авах;

38 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:
 - 1/ төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн хилийн асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийг бэлтгэх, байгуулах;
 - 2/ улсын хил хамгаалалтын гадаад улс төрийн болон олон улсын эрх зүйн таатай нөхцлийг бүрдүүлэх;
 - 3/ хилийн төлөөлөгчийн шугамаар шийдвэрлэж чадаагүй асуудлыг зохицуулах;
2. Тагнуулын байгууллага нь:
 - 1/ улсын хилд гарч болзошгүй зөрчлийн тухай Улсын хил хамгаалах байгууллагад цаг тухайд нь мэдээлж, бичгээр баталгаажуулах;
 - 2/ гадаадын тусгай алба, бусад байгууллага улсын хилийн орчим болон улсын хилийг ашиглан явуулж болох тагнан турших ажиллагаа, хилийн гадаад, дотоод нөхцөл байдлыг судалж улсын хил хамгаалалтад ач холбогдол бүхий асуудлаар Улсын хил хамгаалах байгууллагатай мэдээлэл солилцож харилцан ажиллах;
 - 3/ хил орчмын нутаг дэвсгэрт явагдах олон үндэсний болон улсын чанартай нийтийг хамарсан арга хэмжээний үед улсын аюулгүй байдлыг хангах ажил зохиох;
 - 4/ улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах, бусад үйл ажиллагаа явуулах.
3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:
 - 1/ улсын агаарын хил хамгаалалтыг удирдах;
 - 2/ улсын хил дээр гарсан зэвсэгт халдлага, түрэмгийллийг таслан зогсоох ажиллагааг удирдах.
4. Нийгмийн хэв журам хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:
 - 1/ улсын хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар Улсын хил хамгаалах байгууллагатай харилцан ажиллах;
 - 2/ цагдаагийн орон нутгийн байгууллагыг улсын хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавихад Улсын хил хамгаалах байгууллагад туслалцуулах;
 - 3/ хил орчмын нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах;
 - 4/ улсын хил дээр зохиогдох нийтийг хамарсан арга хэмжээний үед журам сахиулах;
 - 5/ улсын хил дээр болон хилийн боомтод гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах;
 - 6/ улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын зорчигчийн тухай мэдээллийг Улсын хил хамгаалах байгууллагаас авч хяналт тавих.
5. Төрийн захиргааны бусад төв байгууллага, аж ахуйн нэгж нь улсын хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, Улсын хил хамгаалах байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлж, улсын хил хамгаалалтад шаардагдах бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангана.

Монгол улсын Хилийн тухай хууль

ХАВСРАЛТ**5.1. МОНГОЛ УЛСЫН ХЦУГ, ЦЕГ, УАБХГ-ЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ ЖУРАМ ТОГТООХ ТУХАЙ /Хилийн цэрэг, цагдаа, аюулаас хамгаалах байгууллагын хооронд улсын хилээр нэвтрэх үед нь саатуулах, хяналт тавих хүмүүс, тээврийн хэрэгслийн талаар мэдээ, мэдээлэл солилцох журам/**

1999 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

Дугаар 414/170/351

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах, Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын болон Хилийн тухай хуулиудын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Хилийн цэрэг, цагдаа, аюулаас хамгаалах байгууллагын хооронд улсын хилээр нэвтрэх үед нь саатуулах, хяналт тавих хүмүүс, тээврийн хэрэгслийн талаар мэдээ, мэдээлэл солилцох журмыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоосон журмыг мөрдөж ажиллахыг ХЦ-ийн Штабын хил хяналтын хэлтэс, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Улсын мөрдөн байцаах газрын 1 дүгээр хэлтэс, УАБХГ-ын Сөрөх тагнуулын албаны 14 дүгээр хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг хагас, бүтэн жилээр гарган танилцуулж байхыг ХЦУГ-ын дэд дарга бөгөөд ХЦ-ийн Штабын дарга (хошууч генерал С.Гүржав), ЦЕГ-ын дэд дарга (цагдаагийн хурандаа Д.Сандаг-Очир), УАБХГ-ын дэд дарга (Д.Чимэд-Юндэн) нарт даалгасугай.

ДАРГА

ХОШУУЧ ГЕНЕРАЛ
Д.БАЗАРСАД

ДАРГА

ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.МӨРӨН

ДАРГА

Ж.ЭНХНАСАН

2000 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр улсын бүртгэлийн 1509 дугаарт бүртгэсэн.

ХЦУГ, ЦЕГ, УАБХГ-ын дарга нарын 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 414/351/170 тоот хамтарсан тушаалын хавсралт

Мэдээ, мэдээлэл солилцох журам

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах, Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын болон Хилийн тухай хуулиудаар хүлээсэн чиг үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл солилцох ажиллагааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. Солилцох мэдээ, мэдээлэл

1. Тус байгууллагууд нь улс орны аюулгүй байдлыг хангах, хилийн болон аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нийтлэг зорилтыг хангах хүрээнд холбогдох мэдээ, мэдээллийг шуурхай харилцан солилцоно.

2. ЦЕГ, УАБХГ нь ХЦУГ-т дараах мэдээ, мэдээллийг өгнө. Үүнд:

- улсын хилээр нэвтрэх үед саатуулах хүмүүс, тээврийн хэрэгслийн тухай

- хуурамч, хүчин төгөлдөр бус баримт бичгээр улсын хилийг хууль бусаар нэвтрэхийг завдагсад

- улсын хилээр нэвтрэч буй хөдөлгөөнд нь хяналт тавих хүмүүсийн талаар

3. Уг мэдээ, мэдээлэлд саатуулах, хяналт тавих хүмүүсийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, паспортын сери, дугаар, регистр, онцгой шинж тэмдэг зэрэг өгөгдөхүүн, тээврийн хэрэгслийн марк, өнгө, улсын болон арал (бүхээг)-ын дугаарыг тодорхой тусгана.

4. Мэдээ, мэдээлэл нь нууцлалын шаардлага хангасан тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байх бөгөөд солилцох ажиллагаа нь бичиг хэрэг хөтлөх ерөнхий зааврын дагуу хийгдэнэ.

5. Утсан холбоогоор мэдээ, мэдээлэл солилцохыг хориглох бөгөөд нэн яаралтай тохиолдолд факс, бие төлөөлөгч явуулж болно.

ГУРАВ. Бусад асуудал

1. Хилийн цэрэг нь УАБХГ-ын дэд дарга, Эрүүгийн цагдаагийн газрын дарга, Улсын мөрдөн байцаах газрын даргын гарын үсэгтэй ирүүлсэн албан тоотыг үндэслэн хилээр үл нэвтрүүлэх хүн, тээврийн хэрэгслийг хуулийн хүрээнд саатуулж, аюулаас хамгаалах болон цагдаагийн байгууллагад нотломжоор хүлээлгэн өгнө.

2. Аюулаас хамгаалахаас бусад байгууллагын шугамаар саатуулах, хяналт тавих хүмүүсийн мэдээллийг зөвхөн ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газар, Улсын мөрдөн байцаах газраар дамжуулан авна.

3. Саатуулагдсан этгээд, тээврийн хэрэгслийг орон нутгийн цагдаагийн болон аюулаас хамгаалах байгууллага аль болох шуурхай хүлээн авч, дээд байгууллагадаа илтгэж зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

4. ЦЕГ, УАБХГ нь хилээр нэвтрэх үед саатуулах, хяналт тавих хүмүүс, тээврийн хэрэгслийн жагсаалтаас хасах тухай мэдээллийг ХЦУГ-т тухай бүр нь өгөх бөгөөд сар тутам хамтран тодотгож, протокол үйлдэнэ.

5. Мэдээ, мэдээлэл солилцох, хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах ажиллагааг ХЦ-ийн Штабын хил хяналтын хэлтэс, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Улсын мөрдөн байцаах газрын 1 дүгээр хэлтэс, УАБХГ-ын 14 дүгээр хэлтэс хариуцан зохион байгуулна.

Орон нутгийн хилийн цэрэг, цагдаа, аюулаас хамгаалах байгууллагууд энэхүү журмыг үндсэн удирдлага болгож харилцан ажиллана.

5.2. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БОЛОН ИРГЭНИЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр
Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
“Төрийн мэдээлэл”, 2002 он, № 5
(Хэсэгчлэн авав)

ТУСГАЙ АНГИ
ТАВДУГААР ХЭСЭГ
ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

89 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх

89.1. Хууль бусаар Монгол улсын хил нэвтэрсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наyas хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

89.2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй.

108 дугаар зүйл. Хүн хулгайлах

108.1. Хүн хулгайлсан нь хүн барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

108.2. Энэ хэргийг:

108.2.1. шунахайн сэдэлтээр;

108.2.2. онц аюултай гэмт хэрэгтэн;

108.2.3. давтан;

108.2.4. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

108.2.5. амь биед нь аюултай хүч хэрэглэж;

108.2.6. зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

108.2.7. хоёр буюу түүнээс олон хүнийг;

108.2.8. насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

108.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн

улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Хүн хулгайлсан үйлдэл нь бие даасан өөр гэмт хэргийн шинжгүй бөгөөд хулгайлагдсан хүнийг сайн дураараа сулласан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

109 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар хорих

109.1. Хүнийг хууль бусаар хорьсон нь энэ хуульд заасан албан тушаалын болон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, түүнчлэн хүн хулгайлах, барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

109.2. Энэ хэргийг:

109.2.1. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

109.2.2. амь биед нь аюултай хүч хэрэглэж;

109.2.3. зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

109.2.4. хоёр 109.2.5. насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. буюу түүнээс олон хүнийг;

109.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112 дугаар зүйл. Хүнийг барьцаалах

112.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.2. Энэ хэргийг:

112.2.1. шунахайн сэдэлтээр;

112.2.2. онц аюултай гэмт хэрэгтэн;

112.2.3. давтан;

112.2.4. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг;

112.2.5. барьцаанд байгаа хүний амь биед заналхийлж;

112.2.6. зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж;

112.2.7. хоёр буюу түүнээс олон хүнийг;

112.2.8. насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг:

113.2.1. насанд хүрээгүй хүнийг;

113.2.2. хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.3. хулгайлах;

113.2.4. эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.5. давтан;

113.2.6. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3. Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:

1. Энэ хуулийн 113.1-д заасан “мөлжих” гэдгийг худалдагдсан хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

/Дээрх 113 дугаар зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах

115.1. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

115.2. Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

115.3. Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

116 дугаар зүйл. Хүүхэд солих, хууль бусаар үрчлэх

116.1. Хүүхдийг санаатай сольсон, хууль бусаар үрчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

123 дугаар зүйл. Садар самууныг сурталчлах

123.1. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

123.2. Энэ хэрэгт арван зургаан насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

123.3. Энэ хэргийг насанд хүрээгүй хүнд хүч хэрэглэж буюу энэ гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах

124.1. Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

124.2. Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан, тээврийн хэрэгсэл,

орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

124.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр
Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬ
“Төрийн мэдээлэл”, 2002 он, № 7
(Хэсэгчлэн авав)

II ДЭД ХЭСЭГ
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД
ГУРАВДУГААР БҮЛЭГ
Иргэн

14 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадвар

- 14.1. Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно.
- 14.2. Иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглоно.

15 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн чадамж

- 15.1. Иргэний эрх зүйн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно.
- 15.2. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно.
- 15.3. Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон шүүхийн шийдвэрийг зохих үндэслэл байвал сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх хүчингүй болгож болно.

16 дугаар зүйл. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж

- 16.1. Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна.
- 16.2. насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, харгалзан дэмжигч/-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ.
- 16.3. насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр дараах эрхээ бие даан хэрэгжүүлж болно.
- 16.3.1. өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутаны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах;
- 16.3.2. өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх;
- 16.3.3. энэ хуулийн 16.3.1-д заасан орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах.
- 16.4. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно.

17 дугаар зүйл. Иргэний эрх зүйн зарим чадамж

17.1. 7-гоос 14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай байна.

17.2. 7-гоос 14 хүртэлх насны этгээдийн хийсэн өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хийнэ.

18 дугаар зүйл. Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн

18.1. 7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна.

18.2. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалагч/хэлцэл хийнэ.

18.3. Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ.

18.4. Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон тохиолдолд шүүх тухайн этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шийдвэрийг хүчингүй болгоно.

19 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах

19.1. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болно.

19.2. Иргэний эрх зүйн чадамжийг хэлцэл хийх замаар хязгаарлахыг хориглоно.

19.3. Иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдаагүй чадамжийнхаа хүрээнд, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийж болно.

19.4. Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон бол тухай этгээдэд тогтоосон хязгаарлалтыг шүүх хүчингүй болгож, харгалзан дэмжигчийг үүргээс нь чөлөөлнө.

Төлөөлөл

64 дүгээр зүйл. Төлөөлөх бүрэн эрх

- 64.1. Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчдийн бүрэн эрхийн талаар амаар буюу бичгээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.
- 64.2. Бичгээр олгосон итгэмжлэл нь дараахь шаардлагыг хангасан байвал зохино:
 - 64.2.1. итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;
 - 64.2.2. хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх;
 - 64.2.3. олгосон он, сар, өдрийг заах;
 - 64.2.4. хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;
 - 64.2.5. итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.
- 64.3. Энэ хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.
- 64.4. Цэргийн албан хаагчийн итгэмжлэлийг түүний алба хааж байгаа анги, байгууллагын удирдлага, хоригдлын итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчилж болно.
- 64.5. Тодорхой хугацаагаар олгох итгэмжлэл гурван жилээс илүүгүй хугацаагаар, хугацаа заагаагүй итгэмжлэл олгосон өдрөөс хойш нэг жил хүчин төгөлдөр байна.
- 64.6. Хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчөөр дамжуулан хийх хэлцлийн хэлбэрт тавигдах шаардлага төлөөлүүлэх хүсэл зорилгоо илэрхийлэхэд хамаарахгүй.

5.3. ЦЕГ-ЫН 202 ТООТ ЖУРАМ

ЖУРАМ.			
202. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ТАЛААР ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ		Батлагдсан огноо:2010-09-29	Дугаар:502
Хавсралт: Маягт:ЦБҮАЖ-№202.316		Нэмэлт тайлбар:	
ЦБҮАЖ-№202.81			
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас: 3	

202.1. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг заавал хүлээн авч хойшлуулшгүй ажиллагааг шуурхай авч явуулах нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдтэй тогтоосон холбоогоо бэхжүүлэх чухал нөхцөл мөн.

202.2. НЭР ТОМЬЁО

Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

“Гомдол” – гэмт хэрэг, зөрчлийн улмаас хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт;

“Мэдээлэл” – гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэх, завдах болон үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад ирүүлсэн мэдээлэл;

“Мэдээллийн хэрэгсэл” – Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дэх хэсэгт заасан “телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл;

“Гомдол, мэдээллийг хүлээн авах” – цагдаагийн байгууллага, алба хаагч нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах үйл ажиллагаа;

202.3. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

202.3.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл /Цаашид “гомдол, мэдээлэл” гэнэ/-ийг дор дурьдсан журмын дагуу хүлээн авна:

а/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 167 дугаар зүйлд заасны дагуу иргэнээс амаар буюу бичгээр гаргасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас бичгээр гаргасан мэдээлэл, Захиргааны хариуцлагын тухай хуулиар харьяалуулсан зөрчлийн тухай гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагч харьяалал харгалзахгүйгээр хүлээн авах үүрэгтэй.

б/ иргэний амаар буюу мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг тэмдэглэл үйлдэж хүлээн авах бөгөөд тэмдэглэлд хүлээн авсан алба хаагч гарын үсэг зурна. Тэмдэглэлийн маягт: ЦБҮАЖ-№202.316.

в/ иргэний бичгээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахдаа гомдол, мэдээлэл

гаргагчид санаатайгаар худал мэдээлбэл хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарлан өгч, энэ тухайгаа тэмдэглэлд тусган гомдол, мэдээлэл гаргагчаар гарын үсэг зуруулна.

г/ гомдол, мэдээллийг цахилгаан, захидал, утас, факс, интернэт, бусад холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглах зэрэг ямар хэлбэрээр ирүүлснийг тэмдэглэлд тусган, гарын үсэг зурж, хүлээн авна.

202.4. НЭРГҮЙ ЗАХИДАЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ

Гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр завдаж, бэлтгэж, үйлдэж байгаа тухай нэргүй захидал, мэдээлэл нь дангаараа баримт болохгүй боловч цагдаагийн байгууллага, алба хаагч хүлээн авч шалгана. Тухайн мэдээлэл нь санаатайгаар худал мэдээлэх, гүтгэх гэмт хэргийн шинжтэй бол энэ гэмт хэргийг үйлдсэн буюу мэдээллийг өгсөн этгээдийг олж тогтоох, илрүүлэх үйл ажиллагааг явуулна.

202.5. ХАРЬАЛЛЫН ДАГУУ БУЮУ ШАЛГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБА ХААГЧИД ШИЛЖҮҮЛЭХ

202.5.1. Гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага, алба хаагч ажил үүргийн дагуу шалгаж шийдвэрлэнэ.

202.5.2. Хүлээн авсан гомдол, мэдээллийг нэн даруй цагдаагийн байгууллагын даргад танилцуулах, эсхүл эрх бүхий алба хаагч шалгах арга хэмжээ авна. Даргын танилцсан гомдол, мэдээллийг бүртгэж, холбогдох нэгжид нэн даруй шилжүүлнэ.

202.5.3. Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, гомдол, мэдээллийг бүртгэлд оруулахгүй орхих, хянан үзэхгүйгээр гомдол гаргагчид буцааж өгөх, хүнд суртал, чирэгдэл учруулахгүй байна.

202.6. ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ

202.6.1. Цагдаагийн алба хаагч, хэлтэс нь гомдол гаргагч буюу албаны даргаас хүлээн авсан гомдол, мэдээллийг 24 цагийн дотор байгууллагын гомдол, мэдээллийн нэгдсэн тоо бүртгэлд оруулж, дугаар авна.

202.6.2. Байгууллага бүр гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл бүртгэх нэгдсэн бүртгэл хөтлөх ба уг ажлыг гэмт хэргийн тоо бүртгэлийн ажилтан хариуцна. Тоо бүртгэлийн ажилтан дагнан ажиллах шаардлагагүй тохиолдолд байгууллагын дарга тоо бүртгэлийг хөтөлнө.

202.6.3. Цагдаагийн байгууллагын хариуцлагатай зохицуулагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гомдол, мэдээллийн бүртгэл хөтөлнө.

202.6.4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гомдол, мэдээллийг хүлээн авч нэн даруй нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ. Энэ хугацаанд шалгалтыг зогсоохгүй.

202.6.5. Цагдаагийн байгууллагын хариуцлагатай зохицуулагч гомдол, мэдээллийг 24 цагаар хүлээн авч бүртгэн байгууллагын даргад танилцуулна.

202.6.6. Гэмт хэргийн тоо бүртгэлийн ажилтан хариуцлагатай зохицуулагчаас даргад танилцуулсан гомдол, мэдээллийг нэгдсэн бүртгэлд авч хяналтын карт бичиж, шалгах ажилтанд нэн даруй шилжүүлэн өгч гарын үсэг зуруулна.

202.6.7. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хүлээн авсан гомдол, мэдээллийг дарга танилцуулж, шалгах алба хаагчийг томилох ба даргын цохолт бүхий

шийдвэрийг хяналтын картын хамт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид албан бичгээр нэн даруй буцаана.

- 202.6.8. Дарга хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх, эсвэл өөр ажилтнаар шалгуулах шийдвэр гаргавал, гэмт хэргийн тоо бүртгэлийн ажилтан энэ тухай гомдол, мэдээлэл анх хүлээн авсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид нэн даруй мэдэгдэнэ.
- 202.6.9. Цагдаагийн алба хаагч гомдол, мэдээлэл хүлээн авмагц гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох шаардлагатай бүх арга хэмжээг шуурхай авч өөрийн үйл ажиллагааны тухай рапортын хамт шилжүүлнэ.
- 202.6.10. Гомдол мэдээллийг харьяаллаар шилжүүлэхэд, шилжүүлсэн байгууллага бүртгэлээс хасч, хүлээн авсан байгууллага нэгдсэн бүртгэлд авна.
- 202.6.11. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч нь тодорхой, байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид гаргасныг хүлээн авсан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бүртгэл хөтөлнө. Шийдвэрлэлтэд нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга хяналт тавина.

202.7. ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

- 202.7.1. Гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих ажлыг цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга хариуцна.
- 202.7.2. Гомдол мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэж байгаа байдлыг улирал тутам цагдаагийн газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.

202.8. ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАХ

- 202.8.1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг хавсралт ЦБҮАЖ-№202.81-ээр сар бүрийн 28-ны дотор гаргаж Цагдаагийн төв байгууллагын Захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.
- 202.8.2. Захиргааны удирдлагын газар нь мэдээг нэгтгэн илтгэх хуудсаар Цагдаагийн төв байгууллагын удирдлагад сар бүр танилцуулж байна.

5.4. ЦЕГ-ЫН 242 ТООТ ЖУРАМ

242. ХЭЛНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАХ	Батлагдсан: 2010-09-29	Дугаар:502
Хавсралт:	Нэмэлт тайлбар:	
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас: 3

242.1. ЗОРИЛГО

Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа монгол хэлний хязгаарлагдмал мэдлэгтэй болон хэлний бэрхшээлтэй хүнд туслалцаа үзүүлэх ажиллагааны дэг горимыг тогтооно.

242.2. НЭР ТОМЬЁО

Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

“Хэлний бэрхшээлтэй хүн” - эх хэл нь монгол хэл биш, гол төлөв гадаадын иргэн, Монгол хэлээр унших, бичих, ярих, ойлгох чадварын аль нэгийг эзэмшээгүй, эсхүл хараагүй, хэлгүй, дүлий хүнийг хамруулж ойлгоно.

“Орчуулагч” - нэг хэлнээс нөгөө рүү бичгээр хөрвүүлэгч;

“Хэлмэрч” - нэг хэлнээс нөгөө рүү амаар хөрвүүлэгч, мөн хэлгүй, дүлий хүний дохиог эзэмшсэн хүн.

242.3. ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

242.3.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа хэлний бэрхшээлтэй хүмүүст цаг тухайд нь бодитой туслалцаа, үйлчилгээ үзүүлэхийн тулд бүхий л боломжтой арга хэмжээг авна.

242.3.2.Цагдаагийн байгууллага нь цагдаагийн үйлчилгээтэй холбоотой тодорхой газруудад нийтлэг хэрэглэгддэг маягт, зааврыг орос, хятад, англи зэрэг хэлээр бичиж бэлтгэх ажлыг зохион байгуулна. Ийнхүү бэлтгэсэн материалыг байгууллагын мэдээллийн самбарт ил харагдахаар байрлуулах, эсхүл хүсэлтийн дагуу өгнө. Жишээ нь: цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах, галт зэвсэг, тээврийн хэрэгслийн бүртгэл, жолоочийн үнэмлэх, ял шийтгэлийн тодорхойлолт авах журам, гадаадын иргэний бүртгэл зэрэг үйлчилгээтэй холбоотой мэдээлэл гэх мэт.

242.4. ХЭРЭГ ОСЛЫН ГАЗАРТ АЖИЛЛАХ БОЛОН ШАЛГАЛТ ЯВУУЛАХ

242.4.1.Монгол хэлний бэрхшээлтэй хүнийг автомашин жолоодож явах үед нь зогсоох, шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн болон бусад зөрчил гаргасан үед цагдаагийн алба хаагч бүрт орчуулагч гаргаж ажиллуулах боломжгүй байдаг. Цагдаагийн алба хаагч болон түүний дарга хэлний бэрхшээлтэй хүнд хэлмэрч шаардлагатай эсэхийг үнэлж тодорхойлно.

242.4.2.Цагдаагийн алба хаагч монгол хэлний хязгаарлагдмал мэдлэгтэй хүнийг баримт бичгээ шалгуулахыг хүсэх, гаргасан зөрчил, захиргааны шийтгэл оногдуулах болсон үндэслэл зэргийн талаар түүнд ойлгуулах орос, хятад, англи хэлний мэдлэг, чадварыг эзэмшсэн байхыг шаардана.

- 242.4.3. Хэлний бэрхшээлтэй хүнээс гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, түүний дагуу шуурхай арга хэмжээ авах шаардлагатай үед тэдэнд тусламж үзүүлж ажиллахын тулд цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын албаны дуудлага хүлээн авах албан тушаалд зохих хэлний мэдлэгтэй алба хаагчийг ажиллуулна.
- 242.4.4. Цагдаагийн алба хаагч нь тухайн нөхцөл байдал, байршил, боломжоос хамааран хэлмэрчлүүлэхээр гадаад хэлний мэдлэг бүхий иргэдийн туслалцаа авч болно.

242.5. БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНД ОРЧУУЛАГЧ, ХЭЛМЭРЧ ОРОЛЦУУЛАХ

- 242.5.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаагаа монгол хэлээр явуулна.
- 242.5.2. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй бол өөрийн эх буюу мэддэг хэл, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдана.
- 242.5.3. Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулахаар орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилох тухай тогтоол үйлдэж уг этгээдэд танилцуулна. Тогтоолд орчуулагч, хэлмэрч нь дуудсан цагт ирж орчуулах, хэлмэрчлүүлэхээр даалгасан үүргийг бүрэн, зөв биелүүлэх үүрэгтэй болохыг заана.
- 242.5.4. Цагдаагийн алба хаагч байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд орчуулагч, хэлмэрч санаатайгаар худал орчуулсан, хэлмэрчилсэн бол түүнд Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэхийг урьдчилан сануулж гарын үсэг зуруулна.
- 242.5.5. Монгол хэлний бэрхшээлтэй хүнд цагдаагийн байгууллагаас санал болгож буй хэлмэрчийг үнэ төлбөргүйгээр авах, эсхүл өөрөө бусад хэлмэрч авч ажиллуулж болохыг тайлбарлана.
- 242.5.6. Цагдаагийн байгууллага нь орчуулагч, хэлмэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг тус байгууллагад мөрдөж байгаа зардлын хэмжээгээр, тэдний ажлын хөлсийг харилцан тохиролцсоны үндсэн дээр дор бүр нь олгоно. Харин эрхэлсэн ажлын хувиар орчуулагч, хэлмэрчийн үүргийг биелүүлсэн бол үүнд хамаарахгүй. Орчуулагч, хэлмэрчид олгох байцаан шийтгэх ажиллагааны зардлыг тооцож олгохдоо Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 320-д заасныг баримтална.
- 242.5.7. Монгол хэл, бичиг мэддэггүй сэжигтэн, яллагдагчид холбогдох хэрэгт өмгөөлөгчийг заавал оролцуулна. Монгол хэл мэдэхгүй этгээдийн хууль ёсны төлөөлөгч, төрөл садан, түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах боломжийг хангах үүрэгтэй.

242.6. ХЭЛМЭРЧ, ОРЧУУЛАГЧИЙН ЖАГСААЛТ

242.6.1.Цагдаагийн байгууллагын дэд дарга нь нь хэлний бэрхшээлтэй хүнд туслах, тэдний эрхийг хангах зорилгоор сайн дурын болон төлбөртэй хэлмэрч, орчуулагчдын жагсаалтыг гаргаж, түүнийгээ тогтмол шинэчилж, алба хаагчдад ашиглах бололцоог олгоно.

242.6.2.Цагдаагийн байгууллага нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авсан орчуулагчдын талаарх мэдээллийг улирал бүр тодотгож, зохих мэдээллийг цагдаагийн байгууллагуудад хүргэнэ.

242.7. СУРГАЛТ

242.7.1.Цагдаагийн байгууллагаас эргүүл, жижүүр, замын цагдаа, түр саатуулах, баривчлах байранд ажилладаг алба хаагчийг дор дурдсан чиглэлээр сургах сургалтыг улирал бүрт явуулна:

а/алба хаагч хэлний хязгаарлагдмал чадвартай, хэлний бэрхшээлтэй хүнтэй харилцахад баримтлах журам, хэвлэмэл материал болон боломжтой бусад эх сурвалжийн талаар мэдлэгтэй байх;

б/гадаадын иргэдтэй шууд харьцаж ажилладаг ажилтнууд тодорхой хэлний мэдлэг эзэмшиж, тухайн хэлээр чөлөөтэй харилцах дадал, чадварыг бий болгох;

5.5. ЦЕГ-ЫН 244 ТООТ ЖУРАМ

244. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ	Батлагдсан : 2010-09-29	Дугаар:502
Хавсралт:	Нэмэлт тайлбар:	
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас: 3

244.1. ЗОРИЛГО

Цагдаагийн байгууллагад гэмт хэрэгтэй тэмцэх ажилд туслалцаа үзүүлсэн хүн болон Авлигатай тэмцэх байгууллагаас⁴⁰ хамгаалалтад авахуулахаар ирүүлсэн гэрч, бусад этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллага тэднийг хамгаалах ажлын дэг горимыг тогтоох зорилготой.

244.2. НЭР ТОМЬЁО

Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

“Гэрч, хохирогч” – Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу хохирогчоор тогтоогдсон хүн, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд туслалцаа үзүүлсэн, мэдээлэл өгсөн, хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүн эсхүл Авлигатай тэмцэх байгууллагаас хамгаалалтад авахуулахаар ирүүлсэн гэрч, бусад этгээдийг;

“Гэрч, хохирогчийг хамгаалах” – дээр дурьдсан хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас сэргийлэхийн тулд сахин хамгаалж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ.

244.3. ХОХИРОГЧТОЙ ХАРЬЦАХ

244.3.1. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон иргэний гомдол, мэдээллийг шалгах явцад дор дурьдсан асуудалд анхаарч ажиллана:

- а/ сэтгэл санааны онцлогийг нь мэдэрч, тайвшруулан аль болох хохирогчийг дахин сэтгэл зүйн таагүй байдалд оруулахгүй байхад анхаарах;
- б/ цаг төлөвлөх, баримтлах асуудалд нухацтай хандах /боломжтой бол цаг төлөвлөхдөө хохирогчтой зөвшилцөх боломжийг бүрдүүлэх, төлөвлөсөн цагаа баримтлан ажиллах/;
- в/ шаардлагатай тохиолдолд хохирогчтой харьцахдаа тусгай өрөөнд уулзах;
- г/ гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хэргүүд дээр цагдаагийн эмэгтэй алба хаагчийг ажиллуулахад анхаарч, хувь хүний нууцлалыг чанд хадгалах;
- д/ хохирогчийг буруутгасан, үл итгэсэн байр сууринаас хандахгүй байх;
- е/ аль болох ганцаарчилсан, тайван нөхцөлд уулзах /эмзэг хохирогч, бусад хохирогчийн хувьд анх удаа мэдүүлэг өгөх үед нь/;
- ж/ хохирогчид шаардлагатай байгаа байгууллага, алба хаагчаас хамаарах дэмжлэг, туслалцааг шуурхай өгөх.

244.3.2. Хохирогчийг мэдээллээр хангах

а/ өмгөөлөгч сонгон авах болон бусад эрх, үүргийг нь уншиж өгөх, тайлбарлах;

⁴⁰ Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт тус тус заасан. Төрийн мэдээлэл, 2006 он, № -т хэвлэгдсэн.

- б/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, хугацаа, журмын талаар энгийн үг, хэллэгээр тайлбарлан өгч байх;
- в/ хэргийн явцын талаарх өөрт нь хамааралтай мэдээллээр хангах;
- г/ дахин хохирохоос урьдчилан сэргийлэхийн тулд сэрэмжлүүлэх зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- д/ хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлэх байгууллагын талаар мэдээлэл өгөх;
- е/ нууцлал хадгалах болон аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн найдвартай байдлын талаарх мэдээлэл өгөх;
- ж/ хохирол тооцох, барагдуулах журмын талаарх мэдээллийг өгөх.

244.3.3. Хохирол барагдуулах

- а/ хохирсон иргэнд хохирлоо бодитой үнэлэх боломж олгох /сэтгэл санаа, эд хөрөнгө, бие махбодь, нэр төр, алдар хүнд гэх мэт/;
- б/ нуугдмал эд хөрөнгө болон гэмт хэргийн замаар олж авсан эд зүйлсийг илрүүлэх, олж тогтоох, битүүмжлэх;
- в/ учирсан хохирлыг бодитой тогтоож, бололцоотой бүхий л тохиолдолд хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, захиргааны зөрчлийг хянан шалгах шатанд нөхөн төлүүлэх.

244.4. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХУВИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ

- а/ аюулгүй байдал, нууцлалыг хангахдаа байцаалт авах үед төдийгүй бусад ажиллагааны явцад хамгаалах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;
- б/ хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах үүднээс түүний хаяг, ажил эрхлэлтийн байдал, шилжин суурьшилт зэрэг хувийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг нууцлах;
- в/ шаардлагатай тохиолдолд хохирогч, гэрч болон түүний гэр бүлийн гишүүд, өмч хөрөнгийг хамгаалалтад авах;
- г/ болзошгүй аюул тулгарсан тохиолдолд авч болох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, туслалцаа үзүүлэх;
- д/ хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл өгөхдөө хохирогч, гэрчийг таньж мэдэж болохуйц мэдээлэл өгөхгүй байх;
- е/ хохирогч, гэрчид хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр худал мэдүүлэг өгүүлэх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж буй тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд цагдаагийн байгууллага гэмт этгээдийг илрүүлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авах.

244.5. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАЛТАД АВАХ

244.5.1. Цагдаагийн байгууллагын дарга нь гэрч, хохирогчийг хамгаалуулах дор дурьдсан үндэслэл тогтоогдвол тогтоосон маягтыг бөглөж цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдал хариуцсан нэгжид хүргүүлнэ:

- а/ гэрч, хохирогч үндэслэл бүхий хүсэлт гаргасан;
- б/ гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хохирогч, гэрчийг хамгаалалтад авах шаардлагатай тухай мэдээлэл ирүүлсэн;
- в/ гэрч, хохирогчийн эрхэнд халдсан нь тухайн хэрэгтэй холбоотой байж болох хангалттай үндэслэлтэй бол.

- 244.5.2.Цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдал хариуцсан нэгж гэрч, хохирогчийг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах ба түүнд холбогдох цагдаагийн байгууллага цагдаагийн төв байгууллагын даргаас өгсөн үүргийн дагуу дэмжлэг үзүүлж, хэрэгжүүлнэ.
- 244.5.3.Гэрч, хохирогчийн гэрт нь эсхүл гэрийн гадна талд, ажилдаа ирэх, буцах замд, ажлын байранд нь, тодорхой газар, орон байранд хамгаалах зэрэг төрлүүд байж болох бөгөөд эдгээрээс аль нэгийг эсхүл хамтад нь авах эсэхийг тухайн нөхцөл байдалд тохируулан дотоод аюулгүй байдал хариуцсан нэгжийн дарга шийдвэрлэж батлагдсан маягтыг бөглөж, гарын үсэг зурна.
- 244.5.4.Цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдал хариуцсан нэгж нь авлигатай тэмцэх байгууллагаас өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах хүсэлтийн хамт тухайн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хамгаалалтад авах болсон үндэслэл, холбогдох зардлыг хэрхэн шийдвэрлэх саналыг авна.
- 244.5.5.Цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах нэгж нь гэрч, хохирогчийг хамгаалуулахтай холбогдон гарах зардлын төсвийн саналыг жил бүр Санхүү, ар тал хариуцсан албанд хүргүүлнэ. Санхүү, ар тал хариуцсан алба нь тухайн жилийн хамгаалалтад шаардлагатай төсвийг хянан үзэж, цагдаагийн төв байгууллагын төсөвт тусгуулах арга хэмжээг авна.
- 244.5.6.Санхүү, ар тал хариуцсан алба, дотоод аюулгүй байдлыг хангах нэгжтэй хамтарч тухайн жилд зарцуулсан хамгаалалтын төсвийн тайланг Цагдаагийн төв байгууллагын даргын зөвлөлийн хуралдаанд тайлагнана.
- 244.5.7.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хамгаалах байранд байрлуулж хамгаална⁴¹.
- 244.5.8.Цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын алба нь гэрч, хохирогч болон бусад этгээд хамгаалалт хүссэн дуудлага, мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 200-т заасны дагуу хүлээн авч, зохих арга хэмжээ авах үүрэгтэй.

244.6. ХОХИРОГЧ, ГЭРЧИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААР ХИЙХ АЖИЛ

Цагдаагийн төв байгууллага нь 1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалд нэгдэн орох, Гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах, төрөөс хохирлыг нөхөн төлөх хуулиуд баталж хэрэгжүүлэх саналыг боловсруулж шийдвэрлүүлэх ажил зохион байгуулна.

244.7. БУСАД АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНИЙГ ХАМГААЛАХ

Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, Авлигатай тэмцэх байгууллагын ажилтан, цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын штабын алба хаагч, түүнчлэн бусад цагдаагийн алба хаагч, ажиллагсад, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 622-т заасны дагуу авна.

⁴¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйл. Төрийн мэдээлэл, 2004 он, №23 -т хэвлэгдсэн

5.6. ЦЕГ-ЫН 317 ТООТ ЖУРАМ

317. БЭЛЭГСИЙН ГЭМТ ХЭРГИЙН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	Батлагдсан: 2010-09-29	Дугаар: 501
Хавсралт:	Нэмэлт тайлбар:	
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас: 3

317.1. ЗОРИЛГО

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж сэтгэл зүйн эерэг орчинг бүрдүүлэх дэг горимыг зохицуулахад оршино.

317.2. ХАМРАХ ХҮРЭЭ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заагдсан дараах гэмт хэргүүдийн улмаас хохирсон хүүхдийн хууль ёсны эрх ашиг, нэр төрийг хамгаалахад энэхүү журмыг мөрдөж ажиллана:

- а/ арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх;
- б/ садар самууныг сурталчлахад хүүхдийг татан оролцуулах;
- в/ биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах;
- г/ хүчиндэх.

317.3. НЭР ТОМЬЁО

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Хүүхэд” - Үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу 18 насанд хүрээгүй хүн,

“Эрүүгийн хуулийн бага насны хүүхэд” – 14 насанд хүрээгүй хүүхэд;

“Эрүүгийн хуулийн насан хүрээгүй этгээд” – 14 наснаас 18 хүртэлх насны хүүхдийг ойлгоно.

317.4. ХОХИРОГЧТОЙ ХАРЬЦАХ

317.4.1. Цагдаагийн алба хаагч бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчтой холбоотой хэргийг шалгахад дараах асуудалд анхаарч ажиллана:

- а/ сэтгэл санааны өвөрмөц онцлогийг харгалзах, хохирогчийг аль болох дахин сэтгэл зүйн таагүй байдалд оруулахгүй байхад анхаарч гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүсийг сэтгэлийн шаналалтай, эсвэл уй гашуунд автагдсан үед зөвлөгөө өгөхөөс зайлсхийж, хохирогчийн гэр бүлийнхэн ойлгож ухамсарлах чадвартай болсон үед нь зөвлөгөө өгнө;
- б/ олон дахин дуудах явдлаас зайлсхийж хийгдэх ажлыг төлөвлөхдөө хохирогчийн гэр бүлийн гишүүдтэй зөвшилцөх;
- в/ эмзэг хохирогч хүүхэдтэй харьцахдаа тусгай өрөөнд орж уулзахыг эрмэлзэх;
- г/ энэ төрлийн гэмт хэргүүд дээр цагдаагийн эмэгтэй албан хаагчийг ажиллуулахад анхаарах;

- д/ хувь хүний нууцлалыг чанд хадгалж байх;
- е/ хохирогчийг буруутгасан, үл итгэсэн байр сууринаас хандахгүй байх;
- ж/ аль болох тайван нөхцөлд уулзах /ялангуяа хохирогчийн хувьд анх удаа мэдүүлэг өгөх үед нь;
- з/ хохирогчид хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, алба хаагчаас хамаарах дэмжлэг, туслалцааг шуурхай өгч байх.

317.4.2. Хохирогч нас барсан, насанд хүрээгүй түүнчлэн эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл зоригоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн нь эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу байцаан шийтгэх ажиллагаанд хохирогчийн төлөөлөгчөөр оролцуулна.

317.4.3. Хохирогч хүүхдийг байцаахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгөх ба харин 16 насанд хүрээгүй хохирогчид мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахыг хориглоно.

317.4.4. Хохирогч хүүхдийг байцаахдаа түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийн аль нэгийг заавал байлцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.

317.4.5. Байцаалтад байлцаж байгаа хүмүүс хохирогч хүүхдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр асуулт тавьж болох боловч хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нь тавьсан асуултад хариулт өгүүлэхгүй байх эрхтэй. Харин тавьсан асуултыг тэмдэглэлд тусгана.

317.5. ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

- а/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, хугацаа, журмын талаар энгийн үг, хэллэгээр тайлбарлан өгч байх;
- б/ хүүхэд оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй эсхүл гэмт хэргийн улмаас цочирдсон сэтгэл санааны таагүй байдалд байгаа үед сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг байлцуулах;
- в/ өмгөөлөгч сонгон авах эрх болон бусад эрх, үүргийг нь сайтар тайлбарлан ойлгуулах /уншиж өгөхөөс гадна тайлбарлах/;
- г/ хэрэг шалгах явцын талаарх өөрт нь хамааралтай мэдээллээр хангах;
- д/ дахин хохирохоос урьдчилан сэргийлэхийн тулд сэрэмжлүүлэх чиглэлээр холбогдох зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- е/ нууцлал хадгалах болон аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн найдвартай байдлын талаарх мэдээлэл өгөх;
- ж/ хохирол тооцох, барагдуулах журмын талаарх мэдээллийг тайлбарлаж өгч байх.

317.6. ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ

- а/ хохирсон хүүхдийн эрх ашгийг хамгаалах эцэг, эх гэр бүлийн гишүүд, төрөл саданд хохирлоо бодитой үнэлэх боломж олгох /сэтгэл санаа, эд хөрөнгө, бие махбодь, нэр төр, алдар хүнд гэх мэт/

- б/ гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нуугдмал эд хөрөнгө болон гэмт хэргийн замаар олж авсан эд зүйлсийг илрүүлэх, олж тогтоох, битүүмжлэхэд анхаарах,
- в/ учирсан хохирлыг бодитой тогтоож, бололцоотой бүхий л тохиолдолд хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлэх.

317.7. ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХУВИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ

- а/ гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдэд аюулгүй байдал, нууцлалыг хангахдаа зөвхөн байцаалт авах үед төдийгүй бусад ажиллагааны явцад болон үргэлжлүүлэн хамгаалах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах,
- б/ насанд хүрээгүй хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүднээс түүний хаяг, сургууль, шилжин суурьшилт зэрэг хувийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг нууцлах,
- в/ болзошгүй аюул тулгарсан тохиолдолд авч болох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, туслалцаа үзүүлэх,
- г/ "хэрэг шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлнө" гэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үзвэл хохирогч хүүхдийг байцаах болон бусад ажиллагаанд гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүнийг байлцуулахгүй байх арга хэмжээ авч болно.
- д/ хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд прокурорын зөвшөөрлөөр гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл өгөхдөө тухайн хохирогч хүүхдийг таньж мэдэж болохуйц онцлогийг тодорхойлсон мэдээлэл өгөхийг хориглоно.
- е/ шаардлагатай тохиолдолд цагдаагийн алба хаагч гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, алба хаагчтай хамтран хохирогч, гэрч болон түүний эрхэнд халдах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж буй тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд гэмт этгээдийг илрүүлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авах,

317.8. ХОХИРОГЧ ХҮҮХДИЙГ ХАМГААЛАЛТАД АВАХ

- 317.8.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч хүүхдийг тодорхой хугацаагаар хохирогчид үйлчилгээ үзүүлэх хамгаалах байранд байрлуулж хамгаалахдаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 244/Гэрч, хохирогчийг хамгаалах/-т зааснаар гүйцэтгэнэ.

5.7. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008.03.26

Дугаар 12

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 113 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

- 1.1. “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.
- 1.2. “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ.
- 1.3. “Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.
- 1.4. “Хууран мэхэлсэн” гэж үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ.
Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.
- 1.5. “Эмзэг байдлыг нь далимдуулсан” гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.
- 1.6. “Элсүүлсэн” гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.
- 1.7. “Тээвэрлэсэн” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг ойлгоно.

Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.

- 1.8. “Дамжуулсан” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.
- 1.9 “Орогнуулсан” гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.
- 1.10. “Хүлээн авсан” гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.
- 1.11. “Эрх мэдлээ урвуулан ашиглах” гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын -аогасан шийдвэрийн дагуу еөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.
- 1.12. “Эрхшээлдээ байгаа” гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.
- 1.13. “Хил давуулан” гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар, эсхүл хуурамч буюу хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна.
Хүнийг хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- 1.14. “Хүнд хор уршиг учирсан” гэдэгт хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амь нас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр давар бий болсныг ойлгоно.

Хоёр. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбарын 1 дэх хэсгийн зарим заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

- 2.1. “Биеийг нь үнэлүүлэх” гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүийг бусадтай гэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.
“Бэлгийн хүчирхийлэлд оруулах” гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан’ ээлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно.
Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.
- 2.2. “Албадан хөдөлмөр хийлгэх” гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг телбергүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.
- 2.3. “Боолчлох” гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.
- 2.4. “Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах” гэж хуульд харшилсан зан

заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.

- 2.5. “Эд эрхтнийг нь аөч ашиглах” гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, эндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.

Гурав. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2.3-т заасан хүн хулгайлах хэрэг нь хүнийг худалдаалах зорилготой байдгаараа мөн хуулийн 108 дугаар зүйлд заасан гэмт хэргээс ялгагдана.

Хүнийг худалдаалах зорилгоор хулгайлсан нь энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн тул энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Дөрөв. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбарын 1 дэх хэсгийн “биеийг нь үнэлүүлэх” гэдэг нь мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана.

- 4.1 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан “биеийг нь үнэлүүлэх” гэдэг нь хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, түүнийг бэлгийн харьцаанд оруулдаг бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд энэ нь заавал байх шинж биш болохыг анхаарвал зохино.
- 4.2 Хүнийг худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бусад хүмүүсийн мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар, төлбөртэйгөөр эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож шилжүүлдэг бол биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.
- 4.3 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд ашиг, орлогын тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ. Түүнчлэн биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хохирогчид биеэ үнэлсний орлогын зарим хэсэг үлддэг бол Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.
- 4.4 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай, боолчлогдох шинжтэй бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн тухайд биеэ үнэлж байгаа этгээд нь гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна.
- 4.5 Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирогч “биеийг нь үнэлүүлэх”-ийг урьдчилан мэдээгүй байдаг бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд биеэ үнэлж байгаа этгээд үүнийг урьдчилан мэдсэн

байдгаараа ялгагдана.

4.6 Биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Тав. Хүн худалдаалах тухай хэлцэл (амаар болон бичгээр) хийгдсэн болон талууд үүргээ гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран хүнийг худалдаалахаар элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан, эсхүл дээрх үйлдлүүдэд бэлтгэсэн, завдсан бол хүн худалдаалах гэмт хэргийг тегс үйлдэгдсэнд тооцно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.БАТСАЙХАН

5.9. ХҮНИЙ ЭРХ БОЛОН ХҮН ХУДАЛДААЛАХ АСУУДЛЫН ТАЛААР САНАЛ БОЛГОЖ БУЙ УДИРДАМЖ

Удирдамж 1: Хүний эрхийг дэмжих, хамгаалах.

Хүний эрхийг уландаа гишгэх нь хүн худалдах хэргийн нэг шалтгаан, шууд үр дагавар нь юм. Тиймийн тул хүн худалдах явдалтай тэмцэх, таслан зогсоох аливаа ажиллагааны төвд хүний эрхийг хамгаалах асуудал бүхнээс түрүүнд тавигдах ёстой.

Хүн худалдах явдлын эсрэг авч байгаа аливаа арга хэмжээ худалдаалагдсан хүмүүс, цагаачид, хөөгдмөл хүмүүс, улс төрийн орогнол хүсэгчдийн эрх, халдашгүй дархан байдалд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.

Улс орнууд, олон улсын болон, төрийн бус байгууллагууд дараах үйл ажиллагааг удирдлага болгоно.

1. Хүн худалдах болон түүнийг таслан зогсоох аливаа арга хэмжээ худалдагдсан хүмүүсийн эрх, халдашгүй дархан байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байлгах алхмуудыг хийх
2. Хүн худалдах явдалтай хийх тэмцлийг зохион байгуулах хуулийг батлах, хэрэгжүүлэх, бодлого, хөтөлбөр боловсруулах ажилд шүүх, хууль үндэсний хүний эрхийн байгууллагууд болон иргэний нийгмийн бусад холбогдох газруудыг оролцуулах, тэдэнтэй зөвшилцөх
3. Хүн худалдах явдлыг таслан зогсоох үндэсний хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн үр дүнд хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх засгийн газрын байгууллагууд, худалдаалагдсан хүмүүст туслах хөдөлгөөн, иргэний нийгмийн холбогдох газруудын хооронд түншлэл буй болгож, хамтын ажиллагаа буй болгоно.
4. Хүн худалдах явдлын эсрэг авч байгаа арга хэмжээ хүйсээр ялгаварлах байдал үүсгэж байгаа эсэхэд анхаарлаа хандуулах
5. Хүний чөлөөтэй зорчих эрхийг хамгаалах. Хүн худалдах явдлын эсрэг авч байгаа арга хэмжээ хүний энэ эрхийг зөрчиж байгаа эсэхэд анхаарал тавьж энэ эрхийг нь баталгаажуулах
6. Хүн худалдахтай тэмцэх тухай хууль, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа хүн худалдахтай тэмцэх хөтөлбөр, аливаа хөндлөнгийн оролцоо нь худалдаалагдсан хүн болон олон улсын цагаачлалын хуулийн дагуу улс төрийн орогнол хүсч байгаа этгээдийн эрхийг зөрчиж байгаа эсэхэд хяналт тавих.

7. Хүн худалдахтай тэмцэх тухай хууль, хөтөлбөр, аливаа хөндлөнгийн оролцоо, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн асуудал хэрхэн тусгагдаж байгаад хяналт тавих механизм бүрдүүлэх. Энэ үүргийг бие даасан хүний эрхийн байгууллагад шилжүүлэх тухай хэлэлцүүлэг явуулах. Төрийн бус байгууллагууд энэ хяналтыг хэрэгжүүлэхдээ худалдаалагдаж байсан хүмүүстэй хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих.
8. Хүн худалдах явдлын эсрэг аливаа арга хэмжээнд хүний эрхийн асуудал тусгахыг дэмжих
9. Хүн худалдах явдлыг таслан зогсоох, түүнтэй тэмцэх аливаа арга хэмжээтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг НҮБ-ын хүний эрхийн хяналтын байгууллагад мэдээлж байх.
10. 2 талын болон бүс нутаг, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомж хүний эрхийг зөрчиж байгаа эсэхэд хяналт тавьж баталгаажуулах. Эдгээр олон улсын хууль нь хүний эрхийн хууль, цагаачлалын хууль зэрэг болно
11. Хүн худалдах явдлын эсрэг стратеги хэрэгжүүлж байгаа улсын иргэний нийгмийн холбогдох газруудад техникийн болоод санхүүгийн туслалцаа санал болгох

Удирдамж 2: Худалдаалагдсан хүн болон гэмт хэрэгтнийг илрүүлэх

Хүчинд автах болон албадлага, зальт этгээдүүдэд хууртан хилээр хууль бусар нэвтрэн орж ирэх явдлаас хүн худалдах гэмт хэрэг ихээхэн ялгаатай. Энэ хоёрыг ялгаж салгахад их төвөгтэй байдаг бөгөөд нарийн нягт мөрдлөг шалгалт явуулалгүйгээр хэн нь худалдаалагдсан хүн, хэн нь хууран мэхлэгдсэн хүн болохыг олж тогтоох нь ихэнх тохиолдолд хэцүү байдаг. Тийм учраас улс орнууд эдгээрийг ялгаж салгах үүрэг хүлээдэг. Түүнээс гадна төр худалдаалагдсан хүмүүсийг таньж тогтооход туслах үүрэг хүлээнэ. Улс орнууд Засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд дараахь зүйлийг удирдлага болгон ажиллана.

1. Эрх баригчид цагдаа, хил, цагаачлалын алба болон цагаачдыг хүлээн авах саатуулах, илрүүлэх үүрэг бүхий холбогдох албан тушаалтнуудад богино хугацаанд Худалдаалагдсан хүмүүсийг олж танихад нь туслах удирдамж, журмыг боловсруулж өгөх
2. Худалдаалагдсан хүмүүсийг таних үүрэгтэй төрийн холбогдох албан тушаалтнуудыг сургалтанд хамруулах, Дээр дурдсан удирдамж журмыг боловсронгуй болгоход нь туслалцаа үзүүлэх
3. Худалдаалагдсан хүмүүст тусламж үзүүлэх, тэднийг танихад нь холбогдох албан тушаалтан, эрх мэдэлтэн ТББ-уудын хооронд хамтын ажиллагаа буй

болгож баталгаажуулах. Үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд хамтын ажиллагааны хэрэгжилт, зохион байгуулалтыг хамгийн тохиромжтой хэлбэрээр явуулах

4. Болзошгүй аюулын талаар болон хүн худалдах явдлын тухай анхааруулгыг шилжин ирэгсдэд өгөх, хэрэв шаардлагатай гэж үзвэл тэднээс хэрэгцээтэй мэдээлэл гаргуулах
5. Худалдагдсан хүн цагаачлалын хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр шүүхэд татагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх. Хулгайлагдаж ирсэн хүн бусдын эрхэнд орсны улмаас энэ бүхнийг хийдэг.
6. Ямар ч нөхцөлд хулгайлагдсан хүнийг саатуулах, аль нэг хэлбэрээр хорихгүй байх нөхцлийг баталгаажуулах

Удирдамж 3: Судалгаа, анализ, үнэлгээ, мэдээлэл түгээх

ХХГХ-тэй тэмцэх үр дүнтэй, бодитой стратеги нарийн боловсруулсан мэдээлэл, туршлага, анализ дээр үндэслэсэн байх ёстой. Асуудлыг ойлгомжтой байлгах үүднээс стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх талууд оролцох нь чухал. Хүн худалдах явдлыг олон нийтэд ойлгуулахад мэргэжлийн ёс зүй сахидаг хэвлэл мэдээллийн байгууллагууд гол үүрэгтэй.

Улс орнууд, засгийн газрын болон төрийн бус байгууллагууд дараах байдлаар ажиллавал зохино.

1. ХХГХ-ийг тодорхойлсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Палермогийн протоколыг дагаж мөрдөх
2. Хүний наймаа болон түүнтэй холбоотой /хууль бусаар шилжин суурьших/ зэрэг мэдээллүүдийг цуглуулж, стандартад оруулах
3. Худалдаалагдсан хүмүүстэй холбоотой мэдээллийг нас, хүйс, үндэс угсаа болон бусад хэлбэрээр төрөлжүүлэн цуглуулж, баталгаажуулах
4. Харилцан ойлголцол, туслалцаан дээр үндэслэн хүний худалдааны талаарх судалгааг хамтран хийх. Судалгааг худалдаалагдсан хүний сэтгэлийн шархыг хөндөлгүй ёс суртахууны өндөр түвшинд хийх ёстой. Судалгаанд хэрэглэгдэж буй арга барил, техник төхөөрөмж хамгийн сайн нь байвал зүгээр
5. Хүний наймааны эсрэг тэмцэх хууль, бодлого, хөндлөнгийн оролцооны хоорондох харилцааг үнэлж, шалгаж байх хэрэгтэй. Ялангуяа ХХГХ-г бууруулах болон нэг газраас нөгөөд шилжих зэрэг хөдөлгөөний тухай арга хэмжээнүүдийн хоорондох ялгааг баталгаажуулах хэрэгтэй.

6. Хүн худалдах гэмт хэргийн золиос болж зовлонг нь биеэр үзсэн хүмүүс энэ хэргийн эсрэг төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг сайн дураараа хүсвэл хүсэлтийг нь хүлээн авах нь чухал.
7. Хүний наймааны асуудалтай холбоотой хэрэгцээтэй мэдээллээр холбогдох албан тушаалтнуудыг хангадаг төрийн бус байгууллагууд хуулийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Удирдамж 4: Хуулийн тогтолцоог баталгаажуулах

Нарийн тодорхой хуулийн заалт байхгүйгээс зарим оронд хүн худалдаалахтай хийх тэмцэлд ихээхэн саад учирдаг. Бүс нутаг, улс орны хуулийн заалт, процедур, хамтын ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зайлшгүй шаардлага буй болоод байна. Олон улсын стандартад нийцсэн хууль, эрх зүйн орчин хүний хулгайг таслан зогсооход гол үүрэг гүйцэтгэнэ.

Улс орнуудад дараах алхмуудыг хэрэгжүүлбэл зохимжтой

1. Өөрийн орны хуулинд нэмэлт оруулах, эсвэл шинээр батлагдаж байгаа хүний хулгайтай тэмцэх хуулийг олон улсын стандартад нийцүүлснээр хүн худалдах гэмт хэргийг хуулинд нарийн тусгаж, оноох ял шийтгэлийг тодорхой болгоно. Хүн худалдах гэмт хэргийг, боолчлох, албадан биеийг нь үнэлэх зэрэг гэмт хэргүүдийн нэгэн адилаар маш нарийн хуульчлах ёстой.
2. Хуулийн этгээд болон хувь хүмүүс хүн худалдах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн ямар хариуцлага хүлээхийг хуульчлан баталж, засаг захиргаа иргэний байгууллагуудад мэдээлэх. Хүн худалдах гэмт хэргийг өнгөлөн далдлах боломжтой гэрлэлт болон ажилд зуучлах товчоод, аялал, зочид буудал, амралтын газрын үйл ажиллагаанд тавих хяналт, зөвшөөрөл олгох хууль ямар байгааг нягтлан үзэх.
3. Хүн худалдах болон түүнтэй холбоотой гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж хэрэгсэл зэргийг хураах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх. Болж өгвөл хүн худалдах ажиллагаанд хэрэглэсэн зүйлсийг хураан авч хохирогчдын тусын тулд зарцуулах. Хохирогчдод нөхөн олговор олгох сан бүрдүүлэх хэлэлцүүлэг явуулах. Хураагдсан үл хөдлөх хөрөнгө зэргийг тус санг санхүүжүүлэхэд хэрэглэх боломжийг бүрдүүлэх.
4. Эрүүгийн хэрэгт оноох ял шийтгэлийг үр дүнтэй болгох. Зарим тохиолдолд хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хүүхэд худалдах эсвэл төрийн албан хаагч энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн бол оноох ял шийтгэлийг чангатгах нь зүйтэй.
5. Худалдаалагдсаны улмаас хүчинд автан хил давсан, эсвэл худалдагдан ирсэн газартаа ямар нэг зөвшөөрөлгүй амьдарч байгаа хүмүүсийг үүнийх нь төлөө

шүүхэд тагах хорьж цагдахгүй байх хууль, эрх зүйн орчинг баталгаажуулах.

6. Урьд нь худалдагдаж байсан хүн энэхүү гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн тохиолдолд тэднийг хамгаалах явдлыг баталгаажуулах. Тэднийг албадан гаргах, Худалдагдсан оронд нь буцаан шилжүүлэх зэрэг алхмууд нь уг хүнд болоод ар гэрт нь аюул учруулах магадлалтай бол үүнээс хамгаалах
7. Худалдагдсан хүмүүс сайн дураараа хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллахад нь тэднийг хамгаалах хуулийн хамгаалалт буй болгох. Ийм хүмүүс хуулийн аливаа ажиллагааны үеэр тухайн байгаа орондоо хууль ёсны бүрэн хамгаалалтад хамрагдах зэрэг болно.
8. Худалдагдсан хүн хууль, эрх зүйн мэдээлэл авах, нэн шаардлагатай хэрэгцээгээ илэрхийлэхэд нь түүний төрөлх болон ойлгодог аль нэг хэлээр нь харьцах бололцоог бүрдүүлэх. Төр дээр дурдсан мэдээлэл өгөх, хэлмэрчээр үйлчлэх, зайлшгүй туслалцаа үзүүлэх зэргийг үл огоорох ёсгүй бөгөөд хулгайлагдсан хэнд ч болов боломжийн хэрээр туслалцаа үзүүлэх нь зүйтэй.
9. Хүн худалдах гэмт хэргийн золиос болсон хүмүүс гэмт этгээдүүдийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхийг хуулиндаа тусгаж баталгаажуулах
10. Гэрчийг хамгаалах үйл ажиллагааг хуулиар баталгаажуулах
11. Иргэний сектор хүн худалдах болон энэ төрлийн гэмт хэрэгт орооцолдсон бол ял шийтгэл оногдуулах хуулийн орчинг бүрдүүлэх.

Удирдамж 5: Хариуцлага хүлээлгэх хуулийг баталгаажуулах

- Хүн худалдах гэмт хэрэг дэлхийн бүх хэсэгт өсөн нэмэгдэж байгаа боловч илрэх нь тун бага байдаг. Худалдагдсан хүмүүсээс цөөхөн нь л суллагддаг.
- Хүн худалдаалагчдад цохилт өгөхөд үр дүнтэй, нягт нямбай хууль хэрэгтэй байгаа юм.
- Гэмт этгээдийг илрүүлэн хариуцлага тооцоход хулгайлагдсан хүмүүс болон гэрчүүдтэй холбоо тогтоож хамтран ажиллахаас их зүйл шалтгаална.
- Ихэнх тохиолдолд хүмүүс хулгайлагдсан хүмүүсийн тухай мэдээлэл өгөх эсвэл гэрчийн мэдүүлэг өгөхөөс дургүйцдэг. Учир нь тэдний ихэнх нь хууль цагдаагийн байгууллагад итгэдэггүй бөгөөд гэрчийн болон бусад хэлбэрээр мэдүүлэг өглөө гэхэд тэднийг найдвартай хамгаалах тогтолцоо байдаггүйтэй холбоотой.
- Хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүн худалдах хэрэгт оролцогоос ийм үл итгэх байдал үүсдэг. Тэгэхээр ийм ажиллагаанд оролцсон хуулийн байгууллагын ажилтнуудыг мөрдөн шалгаж, шүүхэд шилжүүлэн зохих ялыг нь эдлүүлдэг хүчирхэг арга хэмжээ үгүйлэгдэж байгаа юм.
- Хууль хүчний байгууллагын ажилтнууд худалдагдсан хүмүүсийн аюулгүй байдлыг хангахдаа сонор сэрэмжтэй байх ёстой. Мөрдөгчидтэй холбоотой

ажиллаж, энэ үүргээ хөсөрдүүлэх ёсгүй.

Төр, холбогдох засгийн газар болон төрийн бус байгууллагууд дараах байдлаар ажиллавал зохимжтой.

1. Хууль сахиулах байгууллагын удирдлага болон ажилтнууд худалдагдсан хүмүүсийн аюулгүй байдалд анхаарал тавьж, сонор сэрэмжтэй байх.
2. Хуулийн байгууллагын бие бүрэлдэхүүн хүн худалдах гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүх ажиллагаанд оролцох зэрэг зохих сургалтанд хамрагдсан байх. Ийм сургалтанд хамрагдсанаар ихээхэн дадлагажиж хулгайлагдсан хүмүүс ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг танихад тус болохоос гадна хүмүүсээс итгэл олж, цаашид хамтран ажиллах харилцан итгэлцлийг олж, давуу тал бий болгоно. Иймэрхүү сургалтанд холбогдох төрийн бус байгууллага оролцох нь ихээхэн үр дүнтэй.
3. Хүн худалдаалагч этгээдүүдийг мөрдөн шалгах, шүүхэд татахад хэрэгцээтэй зохих эрх мэдэл, техник хэрэгслээр хуулийн байгууллагыг хангах. Төрөөс урьдчилан сэргийлэх аливаа ажиллагааг хөхиүлэн дэмжих.
4. Хүний наймаатай тэмцэх байгууллагын чадамжийг дээшлүүлэхийн тулд ажилтнуудыг нь мэргэшүүлэх.
5. Хүний наймаатай тэмцэх стратеги одоо ч хойшид ч гэмт хэрэгтнүүдийг хараалж байх болно гэдгийг баталгаажуулах.
6. Худалдагдсан хүмүүсийг суллах ажиллагаа тэдгээр хүмүүсийн эрх, халдашгүй дархан байдалд хөнөөл учруулахгүй байна гэсэн баталгаа гаргах.
7. Цагдаа, прокурор, цагаачлал, хуулийн байгууллагын эрх мэдэл бүхий хүмүүс, эрүүл мэндийн байгууллагууд хүн худалдах гэмт хэргийг илрүүлэх зохих сургалтанд хамрагдаж энэ гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх, хохирогч нарыг хамгаалах талаар тодорхой мэдээлэл авах
8. Мөрдлөг болон шүүх хуралдааны явцад хүнийг хамгаалах, шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ, боломжийг эрэлхийлэх
9. Худалдагдсан хүнд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэхэд нь төрийн бус байгууллагатай хамтран ажилласан хуулийн байгууллагын эрх мэдэлтэй хүмүүсийг урамшуулах

Удирдамж 6: Худалдаалагдсан хүнийг хамгаалах, дэмжих

Худалдагдсан хүний эрхийг хамгаалах, хэрэгцээтэй туслалцааг нь үзүүлэхгүйгээр хүн худалдах гэмт хэргийг таслан зогсоох боломжгүй. Тэдэнд шаардлагатай хамгаалалт дэмжлэгийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлээс ангид байлгах ёстой.

Төр, засгийн газар болон төрийн бус байгууллагууд дараах байдлаар ажиллах хэрэгтэй.

1. Худалдагдсан хүний хэрэгцээ, шаардлагыг хангах аюулгүй газар байгуулахдаа төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах. Тухайн газарт хулгайлагдсан хүнийг байлгахдаа түүнийг хүн худалдах гэмт хэргийн тухай мэдээлэл өгсөн эсэхээс хамаарч ялгавартай хандахыг хориглоно. Худалдагдсан хүнийг цагаачдыг саатуулах төв болон бусад саатуулах байр, хаяг тогтоох газарт байлгахыг хориглоно.
2. Худалдаалагдсан хүний эрүүл мэндэд санаа тавих асуудал дээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана. Худалдаалагдсан хүнээс эрүүл мэндийн болон бусад иймэрхүү туслалцаа хүсэх, ДОХ зэрэг өвчний шинжилгээ өгөхийг албадах ёсгүй.
3. Худалдаалагдсан хүн тухайн улсад байгаа өөрийн орны дипломат төлөөлөгчийн газраас туслалцаа авах эрхтэй гэдгийг нь заавал таниулж өгнө. Худалдаалагдсан хүнд хэрэгцээтэй тусламж үзүүлэх зорилгоор элчин сайдын яамд төлөөлөгчийн газартай ажиллах хүмүүс энэ талын сургалтанд хамрагдах. Эдгээр нөхцлүүд улс төрийн орогнол хүсч байгаа худалдаалагдсан хүнд хамаарахгүй.
4. Худалдаалагдсан хүний оролцож байгаа аливаа хуулийн ажиллагаа түүний эрх, халдашгүй байдал, биеийн болоод сэтгэл санааны эсрэг чиглэгдэх ёсгүй.
5. Ямар ч үед худалдаалагдсан хүнд хуулийн болоод бусад туслалцаа үзүүлэх ёстой. Хохирогчид түүний ойлгодог хэлээр нь мэдээллийг өгөх ёстой.
6. Худалдаалагдсан хүнд гэмт хэрэгтнүүдийн зүгээс үзүүлэх аливаа хор хөнөөл, заналхийллээс найдвартай хамгаалагдах баталгааг гаргаж өгнө. Гэмт хэргийн хохирогч болсон хүнийг олон нийтэд зарлах ёсгүй бөгөөд тэдний хувийн нууцыг хүндэтгэн үзэж хамгаална. Худалдаалагдсан хүнд бүх зүйлийг урьдчилан анхааруулах ёстой бөгөөд худал, бодит бус мэдээллийг хууль сахиулах байгууллага өгөх ёсгүй.
7. Аюулгүй байдлыг нь баталгаажуулж, өөрөө хүссэн тохиолдолд эх оронд нь буцаах бөгөөд дахин худалдаалагдах аюул хэвээр байна гэж үзвэл худалдаалагдсан иргэнийг одоо байгаа газраа эсвэл гуравдагч оронд суурьших боломжоор аль болох хангах

8. Худалдаалагдсан хүн төрөлх эх орондоо буцаж байгаа тохиолдолд тэдэнд хэрэгцээтэй тусламж, дэмжлэгийг өгөхдөө төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, дахин худалдаалагдахаас болгоомжлуулах. Уг хүнийг буцаахдаа бие сэтгэлийн болон орон байр, боловсрол, ажил эрхлэлтийн талаар боломжтой зөвлөгөө өгөх арга хэмжээг авах,

Удирдамж 7: ХХГХ-ийг таслан зогсоох

Хүн худалдах аливаа үйл ажиллагааг таслан зогсоох стратеги түүний үндсийг үгүй хийхэд гол анхаарлаа хандуулах ёстой байдаг. Төрийн, засгийн газар хоорондын байгууллага хүний худалдааг гааруулдаг хүчин зүйлс болох тэгш бус байдал, ядуурал, ялгаварлан гадуурхах, ашиг сонирхолд нь гэм хор учруулах зэрэгт анхаарлаа хандуулж тооцож үзэх ёстой. Энэ гэмт хэргийг таслан зогсоох үр дүнтэй стратеги нь нарийвчилсан мэдээлэл, ажлын туршлага дээр үндэслэн хийгдэх ёстой. Төр болон засгийн газар хоорондын байгууллагууд, төрийн бус байгууллага хамтын ажиллагааны бодлого, төлөвлөгөө боловсруулахдаа дараах зүйлсийг удирдлага болгох хэрэгтэй.

1. Анализ хийхдээ секс үйлчилгээ, мөлжлөгийн хөдөлмөр үүсгэдэг хүчин зүйлсийг анхааралдаа авч, тэдгээрийг таслан зогсоох хүчирхэг хууль, бодлого боловсруулах хэрэгтэй.
2. Хөтөлбөр боловсруулахдаа суурь боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, бичиг үсэг сургах ажиллагаанд эмэгтэйчүүд, хүүхдүүд нийгмийн хоцрогдсон хэсгийг хамруулах талыг тооцож үзэх
3. Хүүхдүүдийн сургуульд хамрагдах боломжийг дээшлүүлж, аль болох дараа дараагийн шатны сургуульд тасралтгүй хамруулах. Ялангуяа эмэгтэй хүүхдүүдийг.
4. Хууль бусаар өөр оронд шилжин суурьших нь мөлжлөгт автах, боолчлогдох, эрүүл мэнд аюулгүй байдлын баталгаа алдагдан ДОХ зэрэг халдварт өвчин тусч болохыг ялангуяа эмэгтэйчүүдэд сайтар ойлгуулах. Түүнээс гадна хууль ёсоор шилжин суурьших нь боломжтой гэдгийг таниулах
5. Хүн худалдах явдлын хор хөнөөлийг таниулсан компанит ажлыг олон нийтэд зориулан зохион байгуулах, компанит ажлын үеэр хүн худалдах явдлын талаарх хүмүүсийн үзэл бодлыг сонсч, зарим хүн аюул осолтойг нь гадарласаар байж шилжин суурьших осолтой шийдвэр гаргадгийг нь ойлгож авах
6. Хүмүүс шилжин суурьшихаас өөр аргагүй байдалд хүрдэг шалтгааныг олж засч залруулах, ингэх явцдаа эмэгтэйчүүдэд яс үндэс, хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхах, цагаачлал, шилжин суурьших асуудал хэрхэн дарамт учруулдгийг тогтоох

7. Хууль ёсоор шилжин суурьшиж ажил хөдөлмөр эрхлэх боломжийг хайх явдал өсч байгаа эсэхийг нягтлах. Хууль ёсоор шилжин суурьшиж, ажил эрхлэхийг төрөөс дэмжиж байгаа явдал байнгын зохицуулалт, хяналтын механизмаас хамааралтай эсэхийг тогтоох
8. Хүн худалдаалах хэрэгт оролцсон хэнийг ч болов баривчлах, шүүхэд шилжүүлэх боломжийг хууль сахиулах байгууллагад олгох нь энэ гэмт хэргийг таслан зогсоох нэг гол үндэс юм. Гэхдээ хуулийн байгууллагууд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэхгүй байх баталгааг буй болгох ёстой.
9. Худалдаалах явдлыг багасгахын тулд бүх хүмүүсийг төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гэрлэлтийн баталгаа зэрэг бичиг баримтаар хангах арга хэмжээг авах хэрэгтэй

Удирдамж 8: Худалдаалагдсан хүүхдийг хамгаалах, туслалцаа үзүүлэх тусгай арга хэмжээ

Худалдаалагдсан хүүхэд биеийн болон сэтгэл зүйн хувьд хүнд цохилтонд ордог бөгөөд тэдэнтэй харилцах хууль, бодлого, хөтөлбөр, хөндлөнгийн оролцоо насанд хүрсэн хүмүүсийнхээс өөр байх ёстой. Олон нийт нийгмийн хамгааллын байгууллага, шүүх, засаг захиргаа, хуулийн байгууллагын аль нь байлаа ч хулгайлагдсан хүүхдийн ашиг сонирхлыг бүгдээс түрүүнд тавих ёстой. Хүн худалдах хэргийн золиос болсон хүүхэд боломжтой бүх тусламж, хамгаалалтыг авах ёстой бөгөөд тэдний онцгой байдлыг үргэлж тооцож үзэх хэрэгтэй.

Төр, засгийн газрын болон төрийн бус байгууллагууд 6—р удирдамж дээр нэмэлт болгон дараах арга хэмжээг мөрдлөг болгоно.

1. Худалдаалагдсан хүүхдийн асуудлыг хууль болон аливаа бодлогод томъёолохдоо тэдэнд тусгай хамгаалалт хуулийн өмгөөлөл хэрэгтэй гэдгийг байнга тусгаж баталгаажуулна. Энэ бүхнийг Палермогийн протоколд нийцүүлэн хийнэ.
2. ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдийг хэн болохыг нь тодруулах ажлыг аль болох түргэн зохион байгуулна
3. ХХГХ-ийн хохирогч болсон хүүхдэд эрүүгийн хэрэг үүсгэх ёсгүй. Тэдний нөхцөл байдал, хулгайлагдсан хүмүүсийнхтэй адилд тооцогдоно.
4. Хүүхдийг хэн болохыг нь тогтоохдоо зөвхөн гэр бүлийн гишүүдийг нь оролцуулна. Өөр хэн нэгэнд даатгахыг хориглоно. Хараахан ухаан суугаагүй хүүхэдтэй энэ талаар ярилцах нь эрсдэл дагуулж болохоор байвал гэр бүлийнх нь хүмүүсийн ашиг сонирхолд нийцүүлэн хүүхдийг тэдэнд буцаан өгнө
5. Хүүхдийг гэр бүлд нь буцаан өгөхөд аюулгүй байдал нь найдвартай биш дахин

хулгайлагдаж мэдэхээр байвал уг хүүхдийн эрх, халдашгүй байдалд нийцүүлэн тусгай арга хэмжээ авна.

6. Нөхцөл байдал 4,5 дугаарт заасантай ижил байгаа тохиолдолд гэртээ буцаж очихтой холбоотой шийдвэрийг гаргах нас биед хүртэл нь асуудлыг хойшлуулна.
7. ХХГХ-ийн золиос болсон хүүхдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, тусгай бодлого хөтөлбөрийг боловсруулна. Хүүхдэд хэрэгцээтэй биеийн, сэтгэл санааны, хуулийн, боловсролын, эрүүл мэндийн, орон байрны туслалцааг үзүүлэх ёстой.
8. Гэм буруутай этгээдийг шүүх, нөхөн төлбөр гаргуулах хүртэл бүх хугацаанд хулгайлагдсан хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй арга хэмжээг батлах ёстой.
9. Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн хувийн нууцыг хамгаалж, хэн болохыг нь олон нийтэд танилцуулахгүй байж болно. Олон нийтэд хэн болохыг нь зарласнаар ялгаварлан гадуурхах байдал үүсэхээр байвал түүнээс зайлсхийх арга хэмжээг авах учиртай.
10. ХХГХ-ийн хохирогч болсон хүүхэдтэй ажиллах хүмүүсийг хуулийн болон сэтгэл зүйн сургалтанд хамруулах арга хэмжээ авна

Удирдамж 9: Туслалцаа авах

1. Хүний эрх нь зөрчигдөн, ХХГХ-ийн золиос болсон хүмүүс олон улсын хуулийн дагуу хангалттай тусламж дэмжлэг авах эрхтэй. Гэвч мэдээлэл дутмаг байдгаас худалдагдсан хүмүүс нөхөн төлбөр, туслалцаа авах эрхээ эдэлж чадахгүй байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд худалдаалагдсан хүмүүст хууль ёсоор ямар тусламж ёстойг ойлгуулах хэрэгтэй.
2. Тусламж авах процедурыг худалдаалагдсан хүний ойлгодог хэлээр тодорхой хэлж таниулна.
3. Худалдаалагдсан хүн эрүүгийн, иргэний, засаг захиргааны ямар ч хэргийн үеэр туслалцаа хүсэх, аюулгүй байх нөхцлөөр хангахад санаа тавина.

Удирдамж 10: Энхийг сахиулагчид, цагдаа, хүмүүнлэг болон дипломат ажилтнуудын үүрэг

Хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох үйл ажиллагаанд энхийг сахиулагчид, цагдаа хүмүүнлэг болон дипломат ажилтнуудын шууд ба шууд бус оролцоо өсөн нэмэгдсээр байна. Төр, засгийн газрын болон төрийн бус байгууллагууд өөрийн удирдлагад ажиллаж байгаа хүмүүс болон өөрийн орны иргэдийг худалдаалагдах болон энэ төрлийн гэмт хэрэгт орооцолдохоос сэргийлэх, хамгаалах хариуцлага хүлээнэ. Мөн тэд хүн худалдах хэрэгт буруутгагдаж байгаа тохиолдолд мөрдлөг шалгалтын ажилд саад учруулахгүй байх, бие бүрэлдэхүүнээс нь хэн нэг нь хүн худалдах гэмт хэрэгт оролцсон нь тогтоогдвол түүний эрх хэмжээг хязгаарлах ажиллагаанд туслах шаардлагатай.

Төр, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд дараах байдлаар ажиллавал боломжтой.

1. Энхийг сахиулагчид, иргэний цагдаа, хүмүүнлэгийн болон дипломат ажилтнуудад албан үүргээ гүйцэтгэхээс нь өмнө болон дараа нь хүн худалдах гэмт хэргийн талаар сургалтанд хамруулах, харилцааны хэмжүүр буй болгох. Сургалтыг туршлагатай хүмүүс хөтлөн явуулах.
2. Шинэ хүн авах, шилжүүлэн байршуулах, процедур шилжүүлэх үйл ажиллагааг нарийн нягт, ил тод байлгах баталгааг гаргах.
3. Энхийг сахиулагчид, иргэний цагдаа, хүмүүнлэг болон дипломат төлөөлөгчдийн газарт ажиллаж буй хүмүүс хүн худалдах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт ямар нэг байдлаар оролцохгүй байх ёстой. Хахууль авах болон бусад ямар нэгэн байдлаар хүн худалдах гэмт хэрэгт оролцсон хэмээн сэжиглэгдэж байгаа хувь хүн болон бүлэг этгээдүүдтэй ажиллахыг хориглоно.
4. Сахилга батын стандарт тогтоох тусгай журам, багц дүрмийг боловсруулан батлана. Эдгээр стандартыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээг тодотгоно.
5. Энхийг сахиулагчид, иргэний цагдаа, хүмүүнлэгийн болон дипломат төлөөлөгчдийн газрын бие бүрэлдэхүүн хүн худалдах болон түүнтэй холбоотой сэжиг бүхий аливаа үйлдэл анзаарсан бол зохих газарт мэдээлэх үүрэг хүлээнэ.
6. Энхийг сахиулагчид, иргэний цагдаа, хүмүүнлэгийн болон дипломат төлөөлөгчдийн газрын бие бүрэлдэхүүнд багтаж байгаа хэн нэгэн хүн худалдах хэрэгт буруутгагдаж байгаа бол түүнийг мөрдөх шалгах механизмыг бүрдүүлнэ.
7. Хүн худалдах болон үүнтэй холбоотой хэрэгт орооцолдсон ажилтанд эрүүгийн, иргэний болон засаг захиргааны хориг тавих арга хэмжээг нэн даруй авна.

Засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд өөрийн ажилтан хүн худалдах болон түүнтэй төстэй хэрэгт орооцолдсон тохиолдолд сахилга батын арга хэмжээ авах, төрийн холбогдох албанаас эрхийг нь хязгаарлах аливаа шийдвэр гаргуулахыг хүсэх ёстой. Уг ажилтан хүн худалдах болон бусад ноцтой гэмт хэрэгт орооцолдож байгаа бол түүнийг хамгаалахаар дипломат эрх ямба, хамгаалалт эдлүүлэх хүсэлт тавих ёсгүй.

Удирдамж 11: Улс орнууд болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа

Хүн худалдах гэмт хэрэг бол нэг улсын хэмжээнд шийдвэрлэхэд төвөгтэй глобаль шинжтэй үйлдэл юм. Улс орон болгон хариуцлагаа дээшлүүлэх нь хамгийн үр дүнтэй арга. Хүн худалдах явдалтай тэмцэхэд олон улсын болон олон талт, хоёр талт хамтын ажиллагаа гол үүрэг гүйцэтгэнэ. Иймэрхүү хамтын ажиллагаа хүн худалдах явдал ижил бус түвшинд байгаа орнуудын хооронд байх нь нэн чухал.

Төр, засгийн газрын болон төрийн бус байгууллагууд дараах удирдамжийг мөрдлөг болгууштай.

1. Хүн худалдах явдлыг таслан зогсоох, худалдагдсан хүний эрх, халдашгүй дархан байдлыг хамгаалахад чиглэгдсэн хоёр талт хэлэлцээр байгуулах
2. Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны байгууллагууд хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хүний үндсэн эрхийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа бол техникийн болон санхүүгийн тусламж үзүүлэх.
3. Палермогийн протокол болон хүний эрхийн талаархи бусад олон улсын гэрээ хэлэлцээг үндэслэн бүс нутгийн хэмжээнд хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх гэрээ боловсруулах
4. Олон улсын стандартад тэнцсэн ажлын наад захын хэрэгцээг хангасан ажлын гэрээг шилжин суурьшигчидтай байгуулах нөхцлийг бүрдүүлж, батлах. Хүн худалдах болон бусад гэмт хэргийг устгахын тулд иймэрхүү гэрээг дагаж мөрдөх явдлыг төрөөс хөхиүлэн дэмжих
5. Худалдагдсан хүн хэн болохыг аль болох түргэн тогтоохын тулд тэдгээр хүмүүсийн эх орон, байнга оршин суудаг газрын холбогдох албатай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх
6. Хүн худалдах гэмт хэрэг болон худалдаалах арга барилын талаар мэдээлэл солилцох механизм бүрэлдүүлэх.
7. Хамтарсан мөрдлөг явуулах боломж бүрдүүлэх процедур, протокол байгуулахад төр анхаарал тавих. Орон нутгийн удирдлагууд бие биендээ харилцан туслах

гэрээг байгуулж, нөхцөл бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээг хүлээн зөвшөөрөх. Ингэснээр ажлын үр дүн ихээхэн дээшилнэ.

8. Хүн худалдах болон түүнтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах, ял төлөвлөх зэрэг ажлуудыг төрийн хэмжээнд баталгаажуулах. Ялангуяа шүүх ажиллагааны арга барилд. Иймэрхүү хамтын ажиллагаа нь хулгайлагдсан хүнийг хэн болохыг нь тогтоох, гэрч нараас аюулгүй байдлын баталгаа өгсний үндсэн дээр мэдүүлэг авах, нотлох баримт цуглуулах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд туслалцаа үзүүлнэ.
9. Гэмт хэрэгтнүүдийг цаг алдалгүй шилжүүлэн өгөх явдлыг баталгаажуулах
10. Хүн худалдах хэрэгт хэрэглэсэн эд зүйлсийг хураан авах хамтын ажиллагааны механизм буй болгох. Ийм хамтын ажиллагаа худагдагдсан хүн хэн болохыг тогтоох, гэмт хэргийн мөрийг илрүүлэх, гэмт хэрэг хийхэд ашигласан эд зүйлсийг хураан авах нөхцлийг бүрдүүлнэ.
11. Хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэр болох мэдээлэл, туршлага солилцох, хөтөлбөр боловсруулах
12. Улс орнуудын төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллахыг хөхиүлэх дэмжих. Худалдагдсан хүнийг эх оронд нь буцаан авчрахад туслалад энэ төрлийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг.